

**ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭГ
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД (ОЛОН УЛСЫН) ХУУЛЬ, ЭРХ
ЗҮЙН БАРИМТ БИЧИГТ ТУСГАСАН БАЙДАЛ**

*Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн
тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D),
цагдаагийн хошууч В.Амарсанаа*

Товчлол: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын хууль, эрх зүйн акт, баримт бичигт хэрхэн тусгасан байдлыг тодруулахаар зорилоо.

Түлхүүр үг: Сэжигтэн, хүний эрх, эрх, эрх чөлөө, яллагдагч.

Үндсэн хэсэг. Өнөө цагт дэлхий нийтээрээ хүний эрх, эрх чөлөөг хүндлэн дээдлэж, язгуур эрх ашгийг хөндөхгүй байх, бусдыг ялгаварлан гадуурхахгүй байхыг эрхэм зорилгоо болгож буй бөгөөд, Монгол улс ч мөн адил энэ чиглэлийг баримтлахыг эрмэлзэж, Нэгдсэн Үндэстний Байгууллагын гэрээ, конвенциудад нэгдэн орсон.

Цагдан хорих арга хэмжээ нь хүний халдашгүй, эрх чөлөөтэй байх салшгүй эрхийг хөнддөг учраас үндэсний төдийгүй олон улсын түвшинд эрх зүйн хамгаалалт тогтоодог бөгөөд, энэ нь ч зүйтэй юм. Тухайлбал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын (Цаашид – НҮБ гэх) 1945 оны Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 9 дүгээр зүйлд “Хэнийг ч дур мэдэн баривчлах, саатуулах буюу хөөн зайлуулах ёсгүй”¹, 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пактын 9.1-д “...Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй”² гэж заасан.

Мөн НҮБ-аас “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц”-ийг 1984 онд, “Цагдан хорих болон хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хамгаалах зарчмууд”-ыг 1988 онд тус тус батлан гаргасан. Эдгээр бичиг баримтад нийцүүлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13³-д Монгол Улсын иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг тодотгож, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэний ч эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон заалтыг тунхагласан. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “...Шүүхийн өмнөх шатанд байгаа хүнийг заавал цагдан хорьж байх нийтлэг журам байх албагүй бөгөөд, шүүх хуралд оролцох, шүүн таслах ажиллагааны аль ч шатанд байлцах, шаардлагатай тохиолдолд, шүүхийн шийдвэр гүйцэтгэхэд байх баталгаа гаргаж өгсөн бол этгээдийг суллаж болно” гэж заасан.

Хүний болон ард түмний эрхийн тухай Африкийн Хартийн 6 дугаар зүйлд:

¹ <https://legalinfo.mn/mn/detail/1271>

² <https://legalinfo.mn/mn/detail/1257>

³ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

“Хувь хүн бүр эрх чөлөөтэй, аюулгүй байх эрхтэй. Хуульд урьдчилан заасан үндэслэл ба нөхцлүүдээс гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй. Ялангуяа, хэнийг ч дур мэдэн баривчлах ба цагдан хорих ёсгүй”⁴ гэж заасан.

Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн 7 дугаар зүйлд:

“1. Хүн бүр эрх чөлөөтэй ба аюулгүй байх эрхтэй.

2. Оролцогч Улсын үндсэн хууль болон түүнд нийцсэн хуулиар тогтоосон үндэслэл, нөхцлүүдээс гадуур хэний ч хувийн эрх чөлөөг хасч болохгүй.

3. Хэнийг ч дур мэдэн баривчилж, эсхүл хорьж үл болно” гэж заажээ.

Хүний эрхийн тухай Европын Конвенц бол оролцогч Улсуудад хуулийн дагуу эрх чөлөөг хасч болох үндэслэлүүдийг тусгайлан заасан цорын ганц гэрээ юм. Энэхүү жагсаалт нь бүрэн бөгөөд, түүнийг “шууд утгаар нь тайлбарлах ёстой”⁵. Тус Конвенцийн 5 дугаар зүйлд:

“1. Хүн бүр эрх чөлөөтэй ба аюулгүй байх эрхтэй. Хуульд заасан журам ба доорх тохиолдлуудаас гадуур хэний ч эрх чөлөөг хасч болохгүй:

(a) Хүнийг эрх бүхий шүүхээр шийтгэсний дараа хууль ёсоор хорих;

(b) Хүнийг шүүхийн шийдвэрийг дагаж мөрдөөгүйн төлөө, эсхүл хуульд заасан аливаа үүргийг биелүүлүүлэх зорилгоор хууль ёсоор баривчлах буюу цагдан хорих;

(c) Хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх үндэслэл бүхий сэжиг байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэхээс болон үйлдсэний дараа оргон зайлахаас нь урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үндэслэлтэйгээр тооцсон тохиолдолд эрх бүхий хуулийн байгууллагад хүргэх зорилгоор хуулийн дагуу баривчлах буюу цагдан хорих;

(d) Насанд хүрээгүй хүнийг хүмүүжлийн хяналтын зорилгоор гаргасан хууль ёсны шийдвэрээр цагдан хорих, эсхүл түүнийг эрх бүхий хуулийн байгууллагад хүргэх зорилгоор хуулийн дагуу цагдан хорих;

(e) Хүнийг халдварт өвчин тараахаас урьдчилан сэргийлэх зорилгоор, эсхүл сэтгэцийн өвчтэй, согтууруулах болон мансууруулах бодисонд донтсон, эсхүл тэнэмэл хүмүүсийг хуулийн дагуу цагдан хорих;

(f) Хүнийг тухайн оронд зөвшөөрөлгүйгээр нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор, эсхүл албадан гаргах, шилжүүлэн өгөх ажиллагаанд хамрагдаж байгаа хүнийг хуулийн дагуу баривчлах буюу цагдан хорих” хэмээн заасан байна.

Дотоодын хууль тогтоомжид тодорхойлон заагаагүй үндэслэлээр хувь хүнийг баривчлах буюу цагдан хорих нь хууль ёсны зарчмыг зөрчсөн хэрэг гэж Хүний эрхийн Хороо үзжээ. Өөрөөр хэлбэл баривчлах ба цагдан хорих үндэслэлүүдийг “хуулиар тодорхойлсон” байх ёстой.

Дотоодын хуульд нь баривчлах зөвшөөрлийг баривчилснаас хойш 72 цагийн дотор өгөх ёстой гэж заасныг зөрчиж, эсрэгээр хүнийг зөвшөөрөлгүй баривчилснаас хойш зөвшөөрлийг гурван хоног гаран хугацааны дараа өгсөн тухай нэгэн хэрэгт 9(1) дүгээр зүйлийг зөрчсөн гэсэн дүгнэлтийг тус Хороо хийсэн байна. Учир нь тухайн хүний эрх чөлөөг “хуулиар тодорхойлсон журмыг зөрчиж хассан” байна.

9(1) дүгээр зүйлд “дур мэдэн баривчлах” гэж заасныг тус Хороо: “дур мэдэх” гэдэг нь “хуулийн эсрэг” гэдэгтэй яг дүйцэхгүй боловч түүнд зүй бус, хууль бус, урьдчилан тааварлах

⁴ Африканская Хартия Прав Человека и Народов, Неофициальный перевод с английского. Принята на встрече глав государств — членов Организации африканского единства 26 июня 1981 г. в Найроби. Вступила в силу 21 октября 1986 г. <http://hrlibrary.umn.edu/russian/instreet/Rz1afchar.html>

⁵ <https://nhrcm.gov.mn/>

аргагүй, хуульд заасан журмыг баримтлаагүй ... гэсэн бүрдэл хэсгүүдийг багтаан илүү өргөн хүрээтэй тайлбарлах ёстой.

Энэ нь хэдийгээр хуулийн дагуу үргэлжлүүлэн цагдан хорьсон тохиолдолд, зөвхөн хууль ёсны байх нь хангалттай бус бөгөөд, мөн тухайн нөхцөл байдалд зүй зохистой байх ёстой гэсэн агуулгатай юм. Цаашилбал, үргэлжлүүлэн цагдан хорих нь оргон зайлах, нотлоход саад хийх, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэх гэсэн бүх л нөхцөл байдлуудад зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл, үргэлжлүүлэн цагдан хорих нь “хууль ёсны байхаас гадна, дээр дурдсан зорилгын үүднээс бүх нөхцөл байдалд үндэслэлтэй, “шаардлагатай” байх ёстой. Тодорхой хэрэгт тэдгээр хүчин зүйлүүд байгааг харуулах нь оролцогч Улсын үүрэг мөн гэж заасан байна.

Жишээ нь: Муконгийн хэрэгт гомдол гаргагч “түүнийг дур мэдэн баривчилж, хэдэн сараар цагдан хорьсон” гэж гомдол гаргасан бөгөөд, оролцогч Улс түүнийг нь Камеруны дотоодын хуулийн дагуу баривчилж, цагдан хорьсон гэсэн заргыг хэрэгсэхгүй болгосон байна. Тус Хороо тийнхүү цагдан хорьсон нь “хэргийн тухайн нөхцөл байдалд үндэслэл ч байхгүй, шаардлага ч байхгүй” байсан учир 9(1) зүйлийг зөрчсөн гэж дүгнэжээ.⁶

Тухайлбал, тус оролцогч Улс тийнхүү цагдан хорьсон нь “оргон зайлах, нотлоход саад хийх, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхэд...зайлшгүй шаардлагатай” байсан гэдгийг нотлоогүй, харин ердөө л баривчлах ба цагдан хорихдоо Пактын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарлахыг зөвшөөрсөн 19(3) дугаар зүйлийг иш татахад хангалттай гэж үзжээ. Гэхдээ тус Хороо “олон намын тогтолцоотой ардчилал, ардчилсан үзэл баримтлал, хүний эрхийг хавчин боогдуулах аргаар улс төрийн төвөгтэй нөхцөлд үндэсний эв нэгдлийг хангах боломжгүй бөгөөд, гомдол гаргагчийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг зөрчсөн байна” гэсэн дүнэлтийг хийжээ. Эцэст нь тус Хороо гомдол гаргагчийг баривчилсан цагдан хорьсон нь Пактын 9(1) зүйлд нийцэхгүй гэж мөн дүгнэжээ.

Европын шүүх нь “Хүний эрхийн тухай Европын Конвенц”-ийн 5(1) дүгээр зүйлийн “зорилго” нь “хэний ч эрх чөлөөг дур мэдэн хасахгүй байхыг баталгаатай хангах явдал юм” гэж тогтоожээ. Өөрөөр хэлбэл, “5 § 1 дүгээр зүйл дэх “хууль ёсны” ба “хуульд заасан журмын дагуу” гэсэн нэр томъёо нь үндэсний хууль тогтоомжийн байцаан шийтгэх ажиллагааны болон материаллаг хэм хэмжээнүүдэд бүрэн нийцсэн байхыг илэрхийлэхээс гадна, эрх чөлөөг хасах аливаа үйлдэл дур зоргын биш байх ба 5 дугаар зүйлийн зорилготой нийцэж байх утгыг агуулна. Нэмж тэмдэглэхэд, хувь хүний эрх чөлөөнд ач холбогдол өгч байхыг харгалзан тус конвенцоор тогтоосон “хууль ёсны” байх стандартад үндэсний хууль тогтоомжууд нийцэж байх нь чухал. Энэхүү стандартын дагуу аливаа бичмэл, бичигдээгүй хууль нь тухайн үйлдлийг хийхэд ямар үр дагавартай болохыг урьдчилан харах, шаардлагатай бол зөвлөгөө авах боломжийг иргэдэд олгосон байхыг шаардана”⁷ гэж заажээ.

1988 оны “Хоригдсон болон цагдан хоригдсон бүх хүмүүсийг хамгаалах зарчим”-ууд нь 39 зарчмаас бүрдсэн дэлгэрэнгүй мэдэгдэл юм. Эдгээр зарчмуудад тусгаагүй гэсэн шалтгаар үндэсний болон олон улсын хуулийн эх сурвалжид зөвшөөрсөн эрхийг эрх чөлөөгөө хасуулсан хүний эрхийг хязгаарлахад үндэслэж үл болно. Эдгээр зарчмуудад ялангуяа шүүхийн буюу бусад хэлбэрээр бүх төрлийн цагдан хорих газрыг үр ашигтайгаар хянах асуудлыг онцлон

⁶ Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь. Шүүгч, прокурор, өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага. 162-163 дахь тал.

⁷ Мөн бүтээл. 165-166 дахь тал.

заасан байна. Жишээлбэл, хууль бусаар хорих, эрх чөлөөгөө хасуулсан хувь хүнтэй хууль бусаар харьцаж байгааг эсэргүүцэх арга замыг заасан байна.⁸

НҮБ-ын Дүрэмд “...хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжихэд улс орнуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхийг чухалчилна”⁹ гэсэн байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 5 дугаар зүйлд “...хэнд ч эрүү шүүлт тулгах буюу хэрцгий, хүний ёсноос гадуур эсхүл нэр төрийг нь доромжлон харьцах, шийтгэхийг хориглоно”¹⁰ гэж заасан нь орчин үеийн эрүү шүүлттэй тэмцэх тэмцэл, үйл ажиллагааны эх суурийг тавьсан юм.

“Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмууд”¹¹-ын цогцод: “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгээ энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндийг хэрэгжүүлэх эрх эдлэх ёстой хэмээгээд, хэрцгий хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэх гэдэг нэр томъёог биеийн болон сэтгэл зүйн хүчирхийллээс гадна, хоригдож буй байрны нөхцөл нь хүний харах, сонсох болон орон зай ба цаг хугацааг баримжаагаар төрөлхийн аливаа мэдрэхүйгээс түр болон бүр мөсөн хагацахаар байх ёсгүй гэсэн өргөн утгаар ойлгоно”¹² гэж заажээ. Энэ баримт бичгийг хэрэгжүүлэхдээ хэрэглэх нэр томъёог сУбъект бүрээр тайлбарлан гаргаснаас гадна, аливаа нэг хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон бүх этгээд өөртэйгээ энэрэнгүй харьцах, хүний хувьд заяасан нэр хүндээ хүндэтгүүлэх эрхтэй болохыг тодорхойлсон.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей “Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнуудын зан үйлийн тухай хууль”¹³-д ...хууль хэрэгжүүлэх албан тушаалтан гэдэгт цагдаагийн бүрэн эрх эдэлдэг, ялангуяа бусдыг баривчлах, хорьж саатуулах эрх бүхий томилдог болон сонгогддог бүх албан тушаалтнууд хамаарна... хэмээн тодорхойлсон байна. Хууль хэрэгжүүлэх албан тушаалтнууд үүргээ биелүүлэхдээ бүх хүмүүсийн нэр төрийг хүндэтгэж, тэдний хүний эрх, эрх ашгийг хамгаалан дэмжинэ гэжээ. Энэ баримт бичигт эрүү шүүлтийг хориглох талаар заахдаа: “хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгий, хүнлэг бус, хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэх аливаа үйлдлийг хийх, өдөөн хатгах болон эвлэрэнгүй хандаж болохгүй бөгөөд, хууль хэрэгжүүлэх нэг ч албан тушаалтан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр харгис хэрцгийгээр, хүнлэг бусаар, нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийг дээд шатны албан тушаалтны захирамж, дайны байдал, дайны аюул, үндэсний аюулгүй байдалд заналхийлэх, дотоодын улс төрийн бодит байдал болон бусад ямар ч онцгой нөхцөл байдлаар зөвтгөж болохгүй” гэж тодорхойлсон байна. Үүний дараа НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг Конвенц”¹⁴-ийг батлан гаргасан.

Дээр дурдсан олон улсын баримт бичгүүдээс үзэхэд, гэмт хэрэгтэй тэмцэх, эсхүл гэмт хэрэгтнүүдтэй харьцах тухай олон улсын баримт бичгүүдийн бараг тэн хагас нь шүүхээс өмнө,

⁸ Мөн бүтээл. 59 дэх тал

⁹ Права человека “Сборник международных договоров”, Нью-Йорк, 2002, Женева.

¹⁰ Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. УБ. 1998. 3 дахь тал.

¹¹ 1988 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн 43/173 дугаар тогтоолоор батласан.

¹² Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. УБ. 1996. 28 дахь тал.

¹³ НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1979 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 34/169 дүгээр тогтоолоор батлагдсан.

¹⁴ 1984 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Нью-Йорк хотноо батлаж, 1987 оны 6 дугаар сарын 26-ны өдөр хүчин төгөлдөх болсон. Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэн орсон. Төрийн мэдээлэл, I боть, УБ.2004. 109 дэх тал.

эсхүл шүүхээр хэлэлцэлгүй хоригдсон, мөн захиргааны журмаар хоригдсон хүмүүсийн эрхийг хамгаалахад нэн түрүүнд чиглэгдсэн байдаг байна.

Монгол Улсын ЭБШ хууль шинээр батлагдаж, 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн сэжигтнийг баривчлах, сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих эвшөөрлийг шүүгч өгөх болсонтой холбогдуулан Улсын Дээд шүүхээс энэ чиглэлээр “Зөвлөмж” гаргаж байжээ. Үүнд:

"Баривчлах", "Цагдан хорих" тухай ЭБШ хуулийн 58, 59, 68, 69, 366, 408 дугаар зүйлүүдэд тодорхой заасан боловч урьд нь шүүгч энэ тухай асуудлыг шийдвэрлэж байгаагүй, Монголын шүүх, шүүгчдийн хувьд хуулиар олгогдсон шинэ үүрэг учраас хуулийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэх шаардлагын үүднээс ЗӨВЛӨХ нь:

"Цагдан хорих ТСАХ-г зөвхөн шүүгч авна" гэсэн ЭБШ хуулийн 62.2 дугаар зүйл, хэсгийн заалтыг хэрэгжүүлэхдээ шүүгчид туйлын нягт нямбай хандаж байвал зохино.

Хуульд зааснаар сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг дараах тохиолдолд цагдан хорино. Үүнд:

1. Хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
2. Удаа дараа ял шийтгүүлж байсан этгээд;
3. Онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол /ЭБШ хуулийн 68.1/;
4. Хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэний учир өмнө нь авсан ТСАХ-г зөрчсөн этгээд;
5. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан /ЭБШ хуулийн 68.2/ бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэрэмжлэх зорилгоор цагдан хорьж болно. Харин:

- Хөнгөн гэмт хэрэгт сэрдэгдсэн;
- Хүнд өвчтэй этгээд;
- Жирэмсэн эмэгтэй;
- Насанд хүрээгүй этгээд;
- Хөхүүл хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хувьд ЭБШ хуулийн 68.2-т заасан үндэслэл байхгүй бол цагдан хорих ТСАХ хэрэглэхийг хориглоно.

Гэвч ЭБШ хуулийн 68.8-д "Жирэмсэн эмэгтэйг" эмнэлгийн байгууллагын хяналтын дор цагдан хорьж болох талаар заасан байна.¹⁵

1999 оны 7 дугаар сарын 1-ний өдөр “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хууль батлагдаж, хэрэгжсэн. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд зорилтыг дараах байдлаар тусгасан. Үүнд: “Энэ хуулийн зорилт нь эрх бүхий албан тушаалтнаас хуульд заасан үндэслэлээр гаргасан шийдвэрийн дагуу сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх нөхцөл, журмыг тодорхойлох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино”¹⁶.

Баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх үндэслэл нь энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу, гагцхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл,

¹⁵ <https://www.legalinfo.mn/law/details/11163> (2021.08.10) Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хориход шүүхээс анхаарах зарим асуудал” зөвлөмжийн 3 дахь заалт. <https://www.legalinfo.mn/law/details/11163> (2021.08.10)

¹⁶ Төрийн мэдээлэл. 1999. №34. “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль

журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаас гаргасан захирамж, тогтоол нь баривчлах, цагдан хорих шийдвэрийг үндэслэл болдог байна.

Энэ хуулийн 17 дугаар зүйлд хоригдсон этгээдийн эрхийг тусгасан.

17.1 Хоригдсон этгээд дараахь эрх эдэлнэ:

17.1.1. өөрийн эрх, үүрэг, хорих байрны дотоод журам, өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхийн талаар мэдээлэл, тайлбар авах;

17.1.2. өөрийн хувийн аюулгүй байдлыг хангуулах;

17.1.3. хорих байрны дарга болон хорих байрны үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий албан тушаалтантай хорих байранд ажиллах үеэр нь хувиараа уулзах;

17.1.4. өмгөөлөгчтэй уулзах, хууль зүйн туслалцаа авах;

17.1.5. энэ хуулийн 19-д заасан хүмүүстэй уулзах;

17.1.6. улсын нууцтай холбоотой болон гэмт үйлдэлд холбогдолтой урвуулан ашиглаж болзошгүйгээс бусад, өөрийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах баримт бичиг, бичлэгийг биедээ хадгалах;

17.1.7. ном, сонин, сэтгүүл, ариун цэврийн хэрэгсэл өрөөндөө байлгах;

17.1.8. энэ хуулиар тогтоосон хэмжээний илчлэгтэй хоол, түүнчлэн унтах байр, дэвсгэр, хучлагаар хангагдах;

17.1.9. шөнийн цагт 8 цагаас багагүй хугацаагаар унтаж амрах;

17.1.10. эмнэлгийн тусламжийг Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд¹ заасан журмын дагуу авах;

17.1.11. хорих байрны дотоод журамд заасны дагуу захидал, цахилгаанаар харилцах, бичгийн хэрэгсэл ашиглах;

17.1.12. хорих байрны дотоод журам зөрчихгүйгээр шашны зан үйл үйлдэх;

17.1.13. хорих байрны дотоод журамд заасан хугацаагаар салхинд гарах;

17.1.14. боловсрол, мэдлэгээ дээшлүүлэх, шаардлагатай сурах бичиг, ном ашиглах;

17.1.15. эргэлт авах;

17.1.16. иргэний эрх зүйн хэлцэлд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөрөө дамжуулан оролцох;

17.1.17. өөрт холбогдох асуудлаар болон хорих байрны нөхцөл, журам, үйл ажиллагааны талаар аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах.¹⁷

Өмнө мөрдөгдөж байсан Эрүүгийн хууль, ЭБШ хуулийн 68, 69, 70, 114 дүгээр зүйлүүдийг нэг мөр хэрэглэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд цагдан хорих ТСАХ авагдаж буй хүний эрх зөрчигдөхгүй, сэжигтэн, яллагдагч, тэдгээрийн ар гэр, өмгөөлөгчид цагдан хоригдсон үндэслэлийг шуурхай танилцуулах, сэжигтэн, яллагдагч баривчлагдсан, цагдан хоригдсон үндэслэлийг эс зөвшөөрч, шүүгчид өөрийн биеэр тайлбар өгөх боломжийг хангах зорилгоор шүүх, прокурорын байгууллага эрх хэмжээний хүрээнд хуульд нийцүүлэн тодорхой журам, заавар гаргаж байжээ.

Тухайлбал: 2008 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Улсын Дээд Шүүхийн Ерөнхий Шүүгч, Улсын Ерөнхий Прокурор хамтран “Цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журам”¹⁸, Монгол Улсын Ерөнхий Прокурорын 2011 оны 12 дугаар сарын 11-

¹⁷ Төрийн мэдээлэл. 1999. №34. “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль

¹⁸ <http://supremecourt.mn/act/print/10>

ний өдрийн 214 тоот, 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/14 тоот тушаалаар “Ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын заавар”-ыг батлан мөрдүүлж байна.

“Цагдан хорихтой холбогдсон зарим ажиллагааг зохицуулах тухай журмаар” цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж буй сэжигтэн, яллагдагчийн эрхийг хангах, цагдан хорих санал гаргах эрх бүхий сУБъектийн шуурхай байх явдлыг хангах, цагдан хорих ТСАХ авагдсан хүнд, түүний ар гэр, өмгөөлөгчид энэ талаар 24 цагийн дотор мэдэгдэж байх, шаардлагатай бол шүүгч цагдан хоригдож буй хүнтэй биечлэн уулзах зэрэг харилцааг зохицуулж байна.

Дүгнэлт. Дээрх хууль, эрх зүйн акт, баримт бичгүүд нь мэдээж хэрэг хүний эрхийг дээдлэх зорилгоор төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний нэгэн илрэл төдийгүй, НҮБ-ийн конвенциудад нэгдэн орсоноор хүлээх шаардлагатай үүргийн хэрэгжүүлэлт байхаас гадна, Үндсэн хуулийн үзэл баримтлал бодит амьдралд хэлбэржин тогтож буйн илрэл билээ. НҮБ-аас 1984 онд батласан “Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц” болон 1988 онд батласан “Цагдан хорих болон хорих ял эдэлж байгаа хүмүүсийг хамгаалах зарчмууд”-д заасан хүний эрхийг хүндлэн, дээдлэх зарчмыг Монгол улсын төр засгаас дэмжиж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх, тэр дундаа цагдан хорих ТСАХ авахдаа хуулийн үзэл баримтлалыг ягштал дагаж мөрдөх чиглэлтэй байгаа нь дэвшилттэй байна.

Үүний үр дүнд Үндсэн хуульд Монгол Улсын иргэний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг тодотгож, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэний ч эрх чөлөөг хязгаарлахыг хориглосон заалтыг тунхагласан явдал нь хүнлэг энэрэнгүй, ардчилсан нийгмийг цогцлоох үйлсэд чухал хувь нэмэр оруулжээ.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад (олон улсын) хууль, эрх зүйн баримт бичигт тусгасан байдлыг эрх бүхий албан тушаалтнууд судалж, жил бүр эрх зүйн мэдлэгийн шалгалт өгч байх чиглэлийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага зохион байгуулж хэвших;
2. Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, анхаарах зарим асуудлаар сургалтыг жил бүр зохион байгуулах;
3. Жил бүр Хүний эрхийн үндэсний комисстой хамтран эрх бүхий алба хаагч нартай хамтарсан хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулах

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Африканская Хартия Прав Человека и Народов, Неофициальный перевод с английского. Принята на встрече глав государств — членов Организации африканского единства 26 июня 1981 г. в Найроби. Вступила в силу 21 октября 1986 г. <http://hrlibrary.umn.edu/russian/instate/Rz1afchar.html>.
2. Монгол Улсын Дээд шүүхийн 2002 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хориход шүүхээс анхаарах зарим асуудал” зөвлөмжийн 3 дахь заалт. <https://www.legalinfo.mn/law/details/11163> (2021.08.10).
3. Права человека “Сборник международных договоров”, Нью-Йорк, 2002, Женева.
4. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/law/details/464>.
5. Хүний эрх, Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл. УБ. 1998.
6. Шүүн таслах ажиллагаанд хүний эрхийг хангах нь. Шүүгч, прокурор, өмгөөлөгчдөд зориулсан гарын авлага.
 - Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. УБ. 1996.
 - Төрийн мэдээлэл. 1998. №34
 - <https://www.legalinfo.mn>

МОНГОЛ УЛС ДАХЬ “МӨНГӨ УГААХ” ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Н.Бадраа
ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн
ЭПЭЗТ-ийн ахлах багш,
цагдаагийн дэд хурандаа

Товчлол. Энэхүү өгүүлэлд мөнгө угаах гэмт хэргийн тухай ойлголт, эрх зүйн зохицуулалт, нийгмийн аюулын шинж чанар, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо баримт, тулгамдаж буй асуудал, цаашид анхаарах асуудлын талаар тусгасан болно.

Түлхүүр үг. Мөнгө угаах, бохир мөнгө, гэмт хэрэг, эдийн засаг, хууль эрх зүйн байдал, нөхцөл байдал, гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаа, шийдвэрлэх арга зам,

Үндсэн хэсэг. Эрүүгийн хуульд заасан гэмт хэргүүдийн ихэнх хувь нь гэмт хэрэг үйлдэж буй этгээд болон бусад гуравдагч этгээдэд ашиг олох зорилготой гэмт үйлдэл байдаг. Тиймээс ийнхүү гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө, эд хөрөнгө, орлогоо нуун далдлах, хэлбэрийг нь өөрчлөх, тараан байршуулах, хууль ёсны мэт болгож хувиргах нь зайлшгүй юм.

Гэмт этгээдүүд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгө, эд хөрөнгө, орлогыг хууль ёсны мэт болгосон, олж авсан, хадгалсан, захиран зарцуулсан, хэлбэр, шинж байдал, байршлыг өөрчилсөн, нуун далдалсан үйлдлийг Эрүүгийн хуульд¹⁹ “Мөнгө угаах” гэмт хэрэг хэмээн хуульчилсан байдаг. Мөнгө угаах гэмт хэрэг нь нарийн төвөгтэй арга хэлбэрээр, зохион байгуулалттайгаар, тусгай мэргэжилтнүүдийн тусламжтайгаар үйлдэгддэг тул түүнийг олж илрүүлэх, тогтооход хүндрэлтэй, цагдаа, мөрдөгч, прокурор, шүүгчээс нарийн мэдлэг, ур чадварыг шаардаж байдаг.

Нийгмийн хөгжилтэй зэрэгцэн мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд бүлэг зохион байгуулалтад орж үйлдлийн арга хэлбэр нь улам боловсронгуй болж техник, технологийн дэвшлийг ашиглах, гэмт хэргийн улмаас олсон орлогыг улс орон дамжуулж шилжүүлэх хандлага сүүлийн үед ихээр ажиглагдаж байна. Ийнхүү дэлхийн олон улс орны хүн амыг айдаст автуулж, сэтгэл санаа, эд хөрөнгийн асар их хохирол учруулж, хувийн бизнесийн салбар, улс орны эдийн засгийн аюулгүй байдалд заналхийж байдаг олон төрлийн гэмт хэргийн нэг нь” Мөнгө угаах”²⁰ гэмт хэрэг юм.

Цаашид мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд дараах чиглэлүүдэд анхаарах шаардлагатай байна. Үүнд:

- Хууль бус мөнгийг цахим орчныг ашиглан угаах
- Хар тамхи мансууруулах бодистой холбоотой хэргийн гаралт ихсэх болсонтой холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргийн улмаас олсон орлогыг угаах эрсдэл бий болсон
- Койн, крипто валютыг худалдан авах, улс орон дамжуулан хууль бус мөнгөний эх үүсвэрийг далдлах.

¹⁹ Төрийн мэдээлэл. 2016. №7. Монгол Улсын Эрүүгийн хууль

²⁰ Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал ОУЭШ хурлын эмхэтгэл. Уб. 2018. 25 дахь тал

- Хөрөнгийн зах зээл идэвхтэй өргөжин тэлж байгаатай холбоотойгоор гэмт хэрэгтнүүд энэ салбарт хөрөнгө оруулах, иргэдийг хохироох эрсдэл үүсч болзошгүй байна.

Гэмт хэргийн улмаас бий болсон мөнгө, эд хөрөнгө, орлогыг хууль ёсны болгох гэмт хэрэг нь улс орны эдийн засагт ихээхэн сөргөөр нөлөөлж, банк санхүү, бизнесийн зэрэг нийгмийн чухал салбаруудад хүрээгээ тэлсээр, шинж чанар өөрчлөгдөж, улс дамнасан, нарийн зохион байгуулалттай хэлбэрт шилжээд байна.

Хууль бус мөнгө дотоодынх бол энэ нь хээл хахууль, авилгыг дэмжиж, шударга өрсөлдөөнийг үгүй хийх, шударга бизнес эрхлэгчдийг зах зээлээс шахаж монопол байдал бий болгох зэрэг сөрөг нөхцөл байдлуудыг үүсгэдэг.

Монгол улсад “мөнгө угаах” гэмт хэргээр зүйлчлэгдэн шалгагдаж шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн нөхцөл байдал.

Хүснэгт №1

№	Он	Шийдвэрлэсэн хэрэг	Мөнгө угаах гэмт хэрэгт холбогдсон хүн	Хорих	Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	Ялаас чөлөөлсөн	Цагаатгасан	Хэргийг хэргэсхгүй болгосон
1	2017	3	5	3				2
2	2018	25	31	14	14		1	2
3	2019	37	49	17	25	1	1	5
4	2020	53	68	16	45		1	6
Нийт		118	153	50	84	1	3	15

Шүүхээр шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийн өсөлт, бууралтыг графикаар харуулбал:

График №1



Шүүхээр хянан шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэрэг нь сүүлийн 4 жилд тогтмол өссөн үзүүлэлттэй буюу 2018 онд 22 хэргээр буюу 8.3 дахин, 2019 онд 12 хэргээр буюу 48.0 хувиар тус тус өсжээ.

2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар шийдвэрлэсэн 53 хэргийг 2019 оны мөн үе /20 хэрэг/-тэй харьцуулахад 33 хэргээр буюу 2.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн мөнгө угаах гэмт хэргийг суурь гэмт хэргээр нь ангилсан судалгаа.²¹

Хүснэгт №2

№	Суурь гэмт хэргийн төрөл	2017 он		2018 он		2019 он		2020 он	
		тоо	Хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	Хувь
1	Хулгайлах болон мал хулгайлах	2	66.7	20	80.0	23	62.2	34	64.2
2	Залилах	1	33.3	-	-	3	8.1	2	3.8
3	Дээрэмдэх			3	12.0	7	18.9	4	7.5
4	Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах			-	-	-	-	2	3.8
5	Хахууль авах							1	1.9
6	Үндэслэлгүй хөрөнгөжих							1	1.9
7	Хөрөнгө завших			1	4.0	-	-	3	5.7
8	Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг			-	-	-	-	2	3.8
10	Мөнгө угаах дангаараа			-	-	-	-	2	3.7
11	Бусад			1	4.0	4	10.8	2	3.7
Нийт		3	100%	25	100%	37	100%	53	100%

Прокурорын байгууллагаас авсан мэдээгээр хулгайлах гэмт хэргийн дараагаар мөнгө угаах гэмт хэргээр давхар зүйлчлэгдсэн хэргийн тоогоор залилангийн гэмт хэрэг хоёрдугаарт орж байгаа бөгөөд 2017-2021 онуудад нийт 97 залилах хэргийг мөнгө угаах зүйл ангиар давхар зүйлчлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулсан байв.

Мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны өнөөгийн байдал

Мөнгө угаах нь санхүүгийн системийн тогтвортой байдлыг эвдээд зогсохгүй эдийн засгийн хямралд хүргэдэг асар их хор хөнөөлтэй, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл юм.

“Мөнгө угаах” гэмт хэрэг нь бусад гэмт хэргүүдтэй харьцуулахад илүү нарийн зохион байгуулалттай, бүр цаашлаад тусгай мэргэжилтнүүдийн тусламж, оролцоотойгоор үйлдэгддэг тул цаг хугацаа өнгөрч, нийгмийн харилцаа, техник технологи хурдацтай хөгжиж буй энэ үед илүү нарийн, илрүүлэхэд төвөгтэй болсоор байгаа билээ. Тиймээс мөнгө угаах гэмт хэргийг

²¹ ШЕЗ- ийн Шүүхийн судалгаа мэдээлэл сургалтын хүрээлэнгийн судалгааны тайлан. УБ.2021

илрүүлэхэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй этгээдээс мэдлэг ур чадвар шаардах нь дамжиггүй юм.

Практикт хулгайн гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан этгээдийг / гурван зуун мянган төгрөгнөөс дээш хохиролтой хулгайлах гэмт хэрэгт / Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл /Мөнгө угаах/ гэмт хэргээр эрүүгийн хариуцлагад татаж байгаа нь нэгдүгээрт энэ төрлийн гэмт хэргийн тоо зохиомлоор өсч байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлуудын нэг болоод байна.

Нөгөө талдаа зарим судлаачид үүнийг нийт шалгасан хэргийн дотор “Мөнгө угаах” зүйл ангиар шалгасан хэргийн тоо их байгаа нь Монгол улс ФАТФ-ын саарал жагсаалтаас гарахад нөлөөлсөн гэж дүгнэсэн байдаг.

Монгол банкны Санхүүгийн мэдээллийн алба хорин сая төгрөг /20,000,000 /-нөөс дээш мөнгөн дүнтэй сэжиг бүхий гүйлгээний талаарх мэдээллийг хууль хяналтын байгууллагад мэдээлэх, улмаар хяналт шалгалт хийгдэж байна.²²

Практикт хулгайн эд зүйлийг анх удаа худалдан авсан, эзэмшсэн, борлуулсан этгээдийн үйлдлийг “мөнгө угаах” гэмт хэргээр зүйлчлэн шалгаж байгаа нь харьцангуй зөрчилдөөнтэй асуудал болж хувираад байна.

Иймээс Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд²³ гэмт хэргийн замаар олсон хөрөнгө мөнгө орлого гэдгийг мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан, түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан хуулийн зүйл заалтад өөрчлөлт оруулах замаар гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, мөнгө, орлогын хэмжээг тодорхойлж хэдий хэмжээний хохирол учирсан бол мөнгө угаах гэмт хэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохыг ялгаж зааглаж өгөх зайлшгүй шаардлага үүсч байна.

Манай улсын хувьд гадаадаас үүсэлтэй мөнгө угаах гэмт хэргийн аюул, заналын эрсдэл дунд хэмээн үнэлэгдсэн бол дотоодоос гаралтай хууль бус мөнгөн хөрөнгийн аюул, заналыг өндөр хэмээн үнэлэгдсэн байдаг.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэгтнүүд санхүү мөнгөний бодлого, тогтолцоо сул хөгжсөн буюу хөгжиж буй орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагааны транзит төв болгон ашиглаж байгаа нь Монгол улсын санхүүгийн салбарын энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг нь ихэвчлэн тодорхой хохирогчгүй, нууц далд аргаар үйлдэгддэг тул бусад гэмт хэргүүдийн адил хэрэг гарснаар бүртгэгдэх боломжгүй байдаг онцлогтой юм.

Улсын ерөнхий прокурорын газрын эрүүгийн хэргийн төв архивт байгаа шүүхээр шийдвэрлэгдсэн “мөнгө угаах” 22 гэмт хэргийг уншиж судалгаа хийж үзэхэд дангаар зүйлчлэгдэн шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй ихэвчлэн хулгайлах гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө мөнгө орлогыг мэдсээр байж авсан, борлуулсан, ашигласан этгээдүүдийн үйлдлийг “мөнгө угаах” зүйл ангиар зүйлчлэн ял шийтгэл оногдуулсан статистик харагдаж байгаа

²² <https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/24.pdf> – Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь – Монгол банк

²³ Төрийн мэдээлэл. 2016. №7. Монгол Улсын Эрүүгийн хууль

нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учруулсан хохиролын хэр хэмжээ зэрэгт тэр бүр тохирохгүй байгаа нь харагдаж байна.

Практикаас үзэхэд, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад гаргаж буй нийтлэг хэд хэдэн алдаа ажиглагдаж байна. Үүнд:

Нэгдүгээрт мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг явуулахдаа мэдээллийг дутуу үнэлж, хэрэг бүртгэлтийн хэрэг яаравчлан нээх, үндсэн (анхдагч) гэмт хэргийг буруу зүйлчлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй этгээдийн бизнес, эдийн засаг зэрэг нарийн мэдлэг, мэдээллийн дутмаг байдал зэрэг тохиолдлууд багтаж байна.

Учир нь, энэ төрлийн гэмт хэргийн хувьд, гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй эсэхийг бус, харин хууль ёсны болгох (мөнгө угаах) үйл явц бодитой өрнөсөн, хэргийн нөхцөл байдлыг тогтоох хангалттай үндэслэл байна гэж үзсэн тохиолдолд, хэрэг бүртгэлтийн хэрэг нээх ёстой. Эс бөгөөс, гэмт хэргийн талаарх мэдээллийг шалгах ажиллагаа сунжирч, улмаар мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл үүснэ.

Гэмт хэргийн бодит байдлын талаарх мэдээлэл хангалттай цуглаагүй байхад, хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээр, гэмт хэргийн оролцогч талд, хэргийн бодит байдлын талаар ашигтай мэдээлэл олж авах боломжийг олгох аюултай. Ингэснээр, тэдний зүгээс, мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах, төөрөгдүүлэх, гэмт хэргийн ул мөр, нотлох баримтыг устгах, нуун дарагдуулах, зарим гэрээ, хэлцэл, мөнгөн гуйвуулгыг зогсоох, итгэлгүй гэж үзсэн хамтрагчтай харилцаагаа таслах зэргээр гэмт хэргээ нуун далдлах, гэмт хэрэг үйлдэх аргаа өөрчлөх, илүү нууц боловсронгуй болгох зэрэг хүндрэлтэй нөхцөл бүрдэж болно.

Хоёрдугаарт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгч хэтэрхий нэг талыг барьсан шийдвэр гаргах хандлага ажиглагддаг.

Үүний гол шалтгаан нь, ялангуяа, энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад мөрдөгчөөс, иргэний эрх зүй, нягтлан бодох бүртгэл, банк, санхүүгийн салбарын мэдлэгтэй уялдаад, олон шат дамжлага, нарийн ажиллагаа шаардсан үйл явцыг хэрэгжүүлэх асуудалтай тулгардаг.

Мөнгө угаах үйл ажиллагаанд санхүүгийн салбарын нарийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс гадна хувь хүн, хуулийн этгээд, санхүүгийн бус бизнес мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч (Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, хуульч, нотариатч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч) нар нь халхавч компани болон зуучлагч ашиглаж үйл ажиллагаа явуулах, гүйлгээ хийх нь түгээмэл байдаг.

Тиймээс энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус хөрөнгө, орлогыг илрүүлэхэд олон салбарыг хамарсан өргөн хүрээний мэдлэг шаардлагатай болдог тул мөрдөгчдийг мэргэшүүлэх шаардлагатай байна.

Тухайлбал, мөнгө болон хөрөнгийг хууль ёсны болгоход (мөнгө угаахад) чиглэсэн санхүүгийн гэрээ, хэлцэл болон гэмт хэргийн улмаас олсон эд баялагт үнэлгээ өгөхөд гэрээний эрх зүй, санхүүгийн гэрээ, хэлцлийн ойлголт, санхүүгийн тусгай мэдлэг эзэмшсэн байх шаардлага тавигдаж байна.

Гуравдугаарт Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны явцад түгээмэл тохиолддог бэрхшээлтэй зүйлийн нэг бол бусад төрлийн шинжилгээ хийлгэж, шинжээч томилохоос татгалзахтай холбоотой асуудал юм.

Тухайлбал, хууль бус аргаар олсон орлогыг хууль ёсны болгох (мөнгө угаах) гэмт хэргийг шалгах явцад, бизнесийн төлөвлөгөөний бодит хэрэгжилт, санхүүгийн байгууллага болон аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны бодит ашиг, тэдгээрийн зохиомлоор үүсгэн байгуулагдаж, оршин тогтнож буй шинж зэргийг тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Эдгээрийг шийдвэрлэхэд шүүхийн шинжилгээ чухал үүрэгтэй байдаг.

Дөрөвдүгээрт шүүхийн шинжилгээний төрөл, зүйлийг буруу сонгох, шинжээчид тавих асуултыг оновчгүй томъёолох, түүний мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн асуулт тавих зэргээс үүдэн, асуултанд хангалттай, үндэслэлтэй хариулт авч чадахгүйгээс гадна, цаашлаад хэргийн шийдвэрлэлт удааширч, хугацаа алдах зэрэг сөрөг үр дагавартай байна.

Тавдугаарт Энэ төрлийн гэмт хэргийг шалгахдаа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татахаас өмнө буюу хэрэг бүртгэлтийн шатанд хэрхэн шалгах, мэдээллийг үнэлэх, ашиглах асуудал дээр ихээхэн анхаарал хандуулах ёстой.

Зургаадугаарт Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдэхээс өмнө хийгдэх хэрэг бүртгэлтийн ажиллагааны явцад яаран эрүүгийн хэрэг үүсгэж шалгаснаас хэргийн холбогдогч гэмт хэргийн ул мөрийг баллах, төөрөгдүүлэх, нотлох баримтыг устгах, үгсэн тохирох нөхцөл боломж бүрдэх байдлаар илэрч байна.

Долоодугаарт: Гадаадын аль нэг улсаас Монгол улсын иргэн аж ахуйн нэгж байгууллагын дансанд тодорхой хэмжээний мөнгө байршаад буцаад маш богино хугацаанд буцаад гарах энэ үйл явц нь өөрөө хууль хяналтын байгууллагуудын уялдаа холбоо, мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг сайжруулах, хурдтай ажиллахыг сануулж байна.

Дүгнэлт. Судалгааны ажлын үр дүнг үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Тухайлбал:

1. Мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад, нотлох баримтыг хангалттай бүрдүүлэхийн тулд юуны өмнө, эдийн засгийн шинжилгээ, шинжээч буюу тусгай шинжээч томилоход анхаарах, мөрдөгчдөд энэ төрлийн шинжилгээний онол, арга зүйн ач холбогдлыг сайтар таньж мэдэх, тус салбарын эрдэмтэн, судлаач, багшлах бүрэлдэхүүний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай

2. Мөнгө угаах гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад, нотлох баримтыг хангалттай бүрдүүлэхийн тулд юуны өмнө, эдийн засгийн шинжилгээ, шинжээч буюу тусгай шинжээч түлхүү томилоход анхаарч, улмаар мөрдөгчид, энэ төрлийн шинжилгээний онол, арга зүйн ач холбогдлыг сайтар таниулж, ойлгуулах чиглэлд тус салбарын эрдэмтэн, судлаач, багшлах бүрэлдэхүүний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай

3. Эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох талаар холбогдох байгууллагад санал дүгнэлт хүргүүлэх шаадлагатай гэж дүгнэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулж хохиролын хэмжээг авч үзэн шинэчлэн тогтоох;

2. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хамтран ажиллах байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоог сайжруулах;

3. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах нэгдсэн бүтэцийг бий болгох;

4. Иргэд олон нийтийг энэ гэмт хэргийн талаарх мэдээллээр хангах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулах;

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Нэг. Ном, сурах бичиг, гарын авлага

1. Улсын ерөнхий прокурорын газар “Мөнгө угаах гэмт хэргийн аюул, заналын үнэлгээ”, УБ, 2019 он
2. Г.Батзаяа- “Мөнгө угаалт”, УБ, 2009 он
3. Монгол улсын эрүүгийн хуулийн тайлбар
4. “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл УБ 2018 он

Хоёр. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Эрүүгийн хууль, 2002 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль / Шинэчилсэн найруулга/, 2015 он
3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2006 он,
4. Монгол улсын эрүүгийн хууль, 2017 он
5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль / Шинэчилсэн найруулга/, 2013 он

Гурав. Бусад эх сурвалж

1. “Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл , 2018 он
2. www.legalinfo.mn

<https://www.mongolbank.mn/>

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ НЭГТГЭХ, ТУСГААРЛАХ ЯВЦАД
ҮҮСЭХ ЗАРИМ АСУУДЛУУД
SOME PROBLEMS IN THE PROCESS OF CONSOLIDATION
AND DIVISION OF CRIMINAL CASES

Б. Баярболд

Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн

Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,

хууль зүйн магистр

цагдаагийн ахлах дэслэгч,

Bayarbold14@gmail.com

Bayarbold B.

Law and Social Science School at University of

Internal Affairs, Department of Public Law,

master of law, lecturer police senior lieutenant,

Товчлол: Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйл, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 124 дүгээр зүйлд тус тус заагдсан Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах тухай заалтуудын харьцуулалт ба тулгамдсан асуудал.

Abstract: Comparison and topical issues of the provisions on merging and separating criminal cases provided for in Article 29.2 of the Code of Criminal Procedure and Article 124 of the Code of Criminal Procedure of 2002 in force in Mongolia.

Түлхүүр үг: Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах, мөрдөн шалгах ажиллагаа, яллагдагч, сэжигтэн, гэмт хэрэг үйлдсэн этгээд, хэд хэдэн гэмт хэрэг

Keywords: Consolidate and separate criminal cases, investigation, accused, suspect, the person who committed the crime, several crimes

Удиртгал. Эрүүгийн процессыг хэрэгжүүлэх явцад гэмт хэргийг хэд хэдэн этгээд хамтран үйлдэх буюу нэг этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн болох нь илэрч, түүнийг шийдвэрлэхэд эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах явдал онцгой ач холбогдолтой байдаг. Тухайлбал эрүүгийн хэргийг нэгтгэх нь хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь, бүрэн дүүрэн, бодитойгоор тогтоож, мөрдөн шалгах, гэмт хэргийг түргэн шуурхай, бүрэн илрүүлэх зорилгоор эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэгдмэл байдлаар нэг мөр явуулахад чиглэгддэг.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд²⁴ эрүүгийн хэргийг тусгаарлах талаар зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шинжлэх, зөв шийдэхэд саад болохгүй бол уг хэргийг тусгаарлаж болно хэмээн зааж өгсөн байдаг.

Харин 2017 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дахь хэсэгт²⁵ эрүүгийн хэргийг тусгаарлах зохицуулалтыг илүү

²⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=12705>

дэлгэрэнгүй байдлаар тусгаж өгсөн ч зарим нэг өөрчлөлтүүдэд нь ээдрээ төвөгтэй, олон үйлдэлт гэмт хэргийг шалгах явцад үүсч болох нөхцөл байдлыг зохицуулаагүй, хийдэл үүсгэж болохуйц хэд хэдэн дутагдал байгааг илрүүлэн тайлбарлахад оршино.

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйл²⁶ ба 2002 оны эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 124, 125 дугаар зүйлийн харьцуулалт

Монгол Улсад 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлд заагдсан “Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах” тухай үндэслэл, журам нь 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдсөн эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 124, 125-р зүйлд заасан эрүүгийн хэргийг нэгтгэх, эрүүгийн хэргийг тусгаарлах үндэслэл журмаас дараах байдлаар ялгагдаж байна. Дараах харьцуулалтанд төсөөтэй зохицуулалтыг харалдаа байрлалаар байршуулсан харуулсан болно. Үүнд:

Харьцуулалт	
2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 124 дүгээр зүйл	2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйл
124.1.Хэд хэдэн этгээд нэг буюу хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг этгээд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн, түүнчлэн урьдаас үгсэж тохиролцоогүй боловч гэмт хэргийг нуун дарагдуулсан буюу мэдээлээгүй хэрэгт яллагдаж байгаа этгээдүүдийн хэргийг нэгтгэнэ.	1.Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол үйлдэл тус бүрд нь эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулна. 9.Нэг үйлдэлд хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна.
124.2.Эрүүгийн хэргийг нэгтгэх дээ хөнгөнийг нь хүндэвтэрт, хүндэвтэрийг нь хүндэд, хүндийг нь онц хүндэд нэгтгэнэ.	4.Хүнд ял оногдуулж болох эрүүгийн хэрэгт хөнгөн ял оногдуулж болох эрүүгийн хэргийг нэгтгэнэ. 5.Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан ялын төрөл, хэмжээ ижил эрүүгийн хэргийг нэгтгэх бол эхэлж эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан хэрэгт нэгтгэнэ.
124.3.Хэргийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед нэгтгэж болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.	2.Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол хэргийг нэгтгэж мөрдөн байцаалт явуулж болно. 7.Прокурор энэ зүйлд заасны дагуу эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах тухай үндэслэл бүхий шийдвэр гаргана.
125.1.Зайлшгүй шаардлагатай бөгөөд энэ нь хэргийг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор шинжлэх, зөв	3.Хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой хянан шийдвэрлэхэд саад болохгүй бол зарим яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлаж болно.

²⁵ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

²⁶ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

шийдвэрлэхэд саад болохгүй бол уг хэргийг тусгаарлаж болно.	8.Прокурор нь яллагдагч гэмт хэрэг үйлдсэн, гэм буруутай болохыг мөрдөн байцаалтын явцад хангалттай нотолсон, тухайн хэргийг шүүхээр хянан шийдвэрлүүлэх боломжтой гэж үзвэл яллагдагчид холбогдох зарим хэргийг тусгаарлан шүүхэд шилжүүлж болно.
125.2.Хэргийг байцаан шийтгэх ажиллагааны аль ч үед тусгаарлаж болох бөгөөд энэ тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.	6.Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан боловч яллагдагчийн холбогдсон зарим эрүүгийн хэрэг нь нотлогдоогүй бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг тусгаарлан хэрэг бүртгэлтэд буцаана.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлд эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах үндэслэл журмыг зааж өгсөн байна. 2002 оны 09 дүээр сарын 01-ний өдрөөс эхлэн үйлчилж байсан Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 124 дүгээр зүйлд заагдсан эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах журмыг улам боловсронгуй болгож, дэлгэрүүлсэн боловч шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дээрх зохицуулалтанд “яллагдагч”-ийг нэмэлтээр оруулж, мөн хэргийг нэгтгэх тусгаарлах ажиллагааг мөрдөн байцаалтын шатанд хийх боломжийг олгож өгсөн байна.

Өөрөөр хэлвэл гэмт хэрэгт сэжиглэгдэж байгаа этгээдэд зөвхөн эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоол танилцуулсны дараагаар буюу хэрэг бүртгэлтийн шатанд бус, зөвхөн мөрдөн байцаалтын шатанд хэргийг нэгтгэх, эсхүл тусгаарлах боломжийг бүрдүүлж өгсөн.

Энэ нь нэг талаараа хэргийг богино хугацаанд, хурдан шуурхай шалгах, хүний эрхийн баталгааг давхар хангаж өгч байгаа сайн талтай мэт боловч нөгөө талаасаа аймаг, нийслэл, дүүрэг дамнасан олон үйлдэлтэй гэмт хэргийг шалган шийдвэрлэхэд төдийлөн ач холбогдол бүхий өөрчлөлт биш хэмээн үзэж байна.

Энэхүү өөрчлөлтийн улмаас бүлэглэн үйлдсэн гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт удаашрах, мөн түүнийг үйлдсэн этгээдүүд хуулийн энэхүү заалтыг овжин байдлаар ашиглаж, хэргийг улам ээдрээтэй болгох, давтан хэрэг үйлдэх, эсхүл хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дуусгах арга хэрэгсэл болгон ашиглах байдал анзаарагдаж байна.

Харин өмнө нь хэрэглэгдэж байсан эрүүгийн байцаан шийтгэх хуулинд гэмт хэрэг үйлдсэн нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд холбогдох нэг болон хэд хэдэн эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах ажиллагааг мөрдөн шалгах ажиллагааны аль ч үед шатанд явуулах боломжтой байсан нь өнөө цагт үйлдэгдэж байгаа ээдрээ төвөгтэй, олон хохирогч, холбогдогтай, тэр тусмаа олон үйлдэлт, удааширсан, сум дүүрэг, төв, орон нутаг дамнасан хэргүүдийг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдол бүхий утга агуулгатай байсан болно.

Тохиолодол 1: *Иргэн А нь иргэн Б, В нарыг өдөөн хатгаж, улмаар тэдэнтэй бүлэглэн орон байрны хулгайн хэрэг үйлдэж, мөрдөн шалгах ажиллагааны явцад иргэн Б, В нарыг олж тогтоосон боловч иргэн А нь Монгол улсын хилээр гарч, оргон зайлсан болохыг Хил хамгаалах ерөнхий газраас ирүүлсэн албан бичгээр нотлов.*

Энэ тохиолдолд иргэн Б, В нарт эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах боломжгүй болж байна. Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт²⁷ зөвхөн яллагдагч нарын гэмт хэрэг үйлдхэд үзүүлсэн идэвхитэй үйлдэл, оролцоогоор нь салгах боломжтой болсон.

Ингэснээр тухайн нөхцөл байдалд иргэн А-г олж тогтоон, түүнд яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулснаар хэргийг шийдвэрлэх боломжтой болж байгаа боловч, иргэн А байхгүйгээр буюу түүнд яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулахгүйгээр иргэн Б,В нарт тэднийг яллагдагчаар татсан тогтоол танилцуулж, хэргийг тусгаарлах боломжгүй байдал үүсч, мөрдөн шалгах ажиллагаа удаашрахад хүрч байна.

Практикт дээрх тохиолдолтой төсөөтэй нөхцөл байдал үүсэх үед буюу иргэн А-г эрэн сурвалжлах явцад иргэн Б,В нарыг олж тогтоон, тус бүрт нь эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан тогтоолыг танилцуулж, таслан сэргийлэх арга хэмжээ авах тохиолдол байдаг ч иргэн А олдохгүй байгаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан “Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан боловч яллагдагчийн холбогдсон зарим эрүүгийн хэрэг нь нотлогдоогүй бол эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тухай тогтоолыг хүчингүй болгож, хэргийг тусгаарлан хэрэг бүртгэлтэд буцаана” гэх үндэслэлээр иргэн Б, В нарын үйлдлийг нотолж, тусгаарлаж болдоггүй. Б,В нар нь хэдий гэмт хэрэг үйлдхэд идэвхитэй үйлдэл оролцоо үзүүлсэн боловч иргэн А байхгүйн улмаас тэдний гэм бурууг бүрэн дүүрэн нотлох боломжгүй байдалд хүрч, цаашлаад яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж, тухайн хэргийг шуурхай шийдвэрлэх боломжгүй байдалд хүргэдэг.

***Тохиолдол 2:** Иргэн А нь иргэн Б, В нарыг өдөөн хатгаж, улмаар тэдэнтэй бүлэглэн Монгол улсын хэд хэдэн аймагт, Улаанбаатар хотын хэд хэдэн дүүрэгт тус бүр 10-45 сая төгрөгний хохирол бүхий үйлдэлтэй, нийт хохирлын хэмжээ нь 200 гаруй сая төгрөг хүрэхүйц залилах гэмт хэрэг үйлдэж, мөрдөн шалгах ажиллагааны явцад иргэн Б, В нарыг олж тогтоосон боловч иргэн А нь нийт хохирлын 60 гаруй хувийг авч, Монгол улсын хилээр гарсан болох нь тогтоогдов.*

Энэхүү тохиолдолд иргэн Б, В нарыг мөн өмнөх тохиолдолд дурьдагдсан шиг яллагдагчаар татах боломжгүй болох ба үүнээс гадна тэдний хамтран үйлдсэн хэргүүдийг хэрэг үйлдэгдсэн аль нэг нутаг дэвсгэрт нь нэгтгэх боломжгүй юм. Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт:

- “Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг хамтран үйлдсэн, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол үйлдэл **тус бүрд нь** эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, мөрдөн байцаалт явуулна”,

2 дахь хэсэгт:

- “Хэд хэдэн яллагдагч нэг, эсхүл хэд хэдэн гэмт хэргийг **хамтран үйлдсэн**, эсхүл нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн бол хэргийг нэгтгэж мөрдөн байцаалт явуулж болно”²⁸ хэмээх заалтуудад зөвхөн яллагдагчаар татагдсан тохиолдолд хэргийг нэгтгэж, эсвэл тусгаарлаж болно хэмээн заагаад өгсөн.

Мөн түүнчлэн яллагдагчаар татагдаагүйн улмаас тухайн хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа газар нэгжүүд болох аймаг, нийслэл, сум, дүүргүүд дэх цагдаагийн

²⁷ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

²⁸ Төрийн мэдээлэл. 2016. №7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

газар хэлтэст шийдэгдэхгүй байсаар дээрх этгээдүүдэд холбогдох эрүүгийн хэргүүдийн тус бүрийн хөөн хэлэлцэх 3 жилийн хугацаа нь дуусах нөхцөл байдал үүсдэг.

Өөрөөр хэлбэл Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалтад “энэ хуулийн (эрүүгийн хуулийн) тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.” хэмээн заасан нь мөн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4 дэх хэгсийн 4.1 дэх заалтад заасан “их хэмжээний хохирол”-д тухайн тохиолдолд дурьдагдаж байгаа нэг гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ нь хүрэхгүй байгаа нь хөөн хэлэлцэх хугацаа дуусах нөхцөл байдлыг бүрдүүлж байна.

Нэг эсхүл хэд хэдэн этгээд бүлэглэн их хэмжээний хохиролд хүрэхгүй хохиролтой (жишээ нь тус бүр 49 сая төгрөгний хохирол) хэд хэдэн гэмт хэргийг Монгол Улсын өөр өөр нутаг дэвсгэрт үйлдэж, эзэн холбогдогч хэн болох нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон боловч хараахан баригдаагүй байгаа нөхцөл байдалд хэргийг нэгтгэх боломж байхгүй байгаа нь нэг талаасаа хэрэг мөрдөн шалгах байгууллага чиг үүргийнхээ дагуу тус бүрийн харьяа нутагт үйлдэгдсэн хэргийг нэгэн зэрэг мөрдөн шалгах давуу талтай байгаа ч хэрэв аль ч газар хэлтсийн албан хаагчид сэжиглэгдэж байгаа этгээдийг барьж чадахгүй байх тохиолдолд (жишээ нь Сэжигтэн нь Монгол улсын хилээр гарч, оргон зайлсан) хэргийг нэгтгэн шалгаж, нийт учирсан хохирлын нийлбэр хэмжээг харгалзаж, хөөн хэлэлцэх хугацааг тооцох нь зүйтэй хэмээн үзэж байна.

Эс бөгөөд нэг эсхүл хэд хэдэн этгээдэд холбогдох тус бүрийн үйлдэл нь 50 сая төгрөгийн хохирлоос бага хохиролтой эрүүгийн хэд хэдэн гэмт хэргүүдийн хөөн хэлэлцэх хугацаа нь мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй харьяа газар хэлтэс тус бүртээ тус бүр 3 жил болоод, тус бүр хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болох эрсдлийг дагуулж байна.

Учир нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлийн 9 дахь хэсэгт: “**Нэг үйлдэлд** хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна” хэмээн зааж өгсөнтэй холбоотой. Үүнээс үзэхэд зөвхөн нэг үйлдэлд хэд хэдэн газар нээгдсэн хэрэг бүртгэлтийн хэргийг нэгтгэх боломжтой болохоос нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд холбогдох өөр өөр газарт шалгагдаж байгаа хэрэг бүртгэлтийн хэргүүдийг нэгтгэх боломжгүйг харуулж байна.

Нэг, эсхүл хэд хэдэн этгээдэд холбогдох өөр өөр газарт үйлдэгдсэн гэмт хэргүүдийг шалгах байгууллагын хувьд бүгдээрээ нэгэн зэрэг, нэг зорилгын төлөө ажиллаж, аль нэг газар нь тухайн эрэн сурвалжлагдаж байсан этгээдийг барьж авч, яллагдагчаар татсан тохиолдолд бусад газарт үйлдэгдсэн хэргүүдийг нэгтгэн авч шалгаж, нийт хохирлын хэмжээг тооцож, улмаар зүйлчлэлийг өөрчлөх, хөөн хэлэлцэх хугацааг өөр байдлаар тоолох боломжтой.

Гэтэл эрэн сурвалжлагдсан этгээдийг огт олж чадахгүй тохиолдолд хэрэг бүртгэлтийн хэргүүдийг нэгтгэх боломжгүй ба хөөн хэлэлцэх хугацаа дуусах нөхцөл бололцоог бүрдүүлж байна.

Дүгнэлт. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29.2 дугаар зүйлд зөвхөн яллагдагч нарын гэмт хэрэг үйлдэхэд үзүүлсэн идэвхитэй үйлдэл, оролцоо, гэмт хэргийн хор уршиг, нийгэмд учруулах аюулаас нь хамаарч эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах боломжтой болсон бөгөөд, энэ нь зөвхөн мөрдөн байцаалтын явцад л хийгдэнэ.

Гэтэл хэд хэдэн этгээд бүлэглэн гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон боловч, яллагдагчаар татагдалгүйгээр буюу яллагдагчаар татсан тогтоолтой танилцалгүйгээр мөрдөн шалгах ажиллагаанаас зарим этгээдүүд нь оргон зайлсан тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа нь удаашрах, мөн түүнчлэн яллагдагчаар татагдсан бусад этгээдүүдийнх нь гэм бурууг бүрэн гүйцэт тогтоох боломжгүй байдалд хүрч, оргон зайлсан этгээдүүд нь олдоогүйн улмаас (жишээ нь: хилээр гарсан тохиолдол), хэргийг бүрэн дүүрэн, нэг мөр шийдвэрлэхэд хүндрэл учрах, мөн түүнчлэн яллагдагчаар татагдсан, оргон зайлаагүй этгээдүүдийн гэм бурууг бүрэн нотлох эсхүл бүрэн нотолсон ч тэдний үйлдлийг тусгаарлах боломжгүй байдалд хүрч, улмаар яллагдагчаар татсан тогтоолыг хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтын шатнаас хэрэг бүртгэлтийн шатруу шилжүүлэх нөхцөл байдал бүрдээд байна.

Мөн хэрэг бүртгэх шатанд хэргийг нэгтгэх боломжгүй байгаа нь нэг эсхүл хэд хэдэн этгээдийн үйлдсэн нэг хэд хэдэн гэмт хэргийн нийт хохирлыг тооцох, хөөн хэлэлцэх хугацааг учирсан хохирол, хор уршигаас хамааран өөрчлөх боломж бололцоог хааж өгөх бөгөөд, хэрэгт холбоотой этгээд нь хаана байгаа нь тогтоогдохгүй үед тухайн хэргүүдийг шүүхийн шатанд хэлэлцүүлэхээс өмнө нь хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах нөхцөл бүрдэж байна.

Санал. Дээрхи дүгнэлтэнд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татахын өмнө нь эсхүл хэргийн онцлог, нөхцөл байдлыг харгалзсан нэмэлт зохицуулалтыг хийх буюу ялангуяа “яллагдагч”-д хамааралтай үйлдлийг дангаар нь тусгаарлах зохицуулалт хийх,

2. Хэргийн нөхцөл байдал, бэм буруутай этгээдийн үйлдэл оролцоо болон бусад нотлох баримтыг харгалзан, үндэслэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын аль аль шатанд эрүүгийн хэргийг нэгтгэх, эсхүл тусгаарлах зохицуулалтыг нэмэлтээр оруулж өгөх

3. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэргийн нийгэмд учруулсан хор хохирлоос хамаарч өөрчлөх (жишээ нь: 300,000 төгрөгийн хохиролтой Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа нь 5 жил байхад 50 сая төгрөг хүртлэх төгрөгийн хохиролтой Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа 3 жил байгаа нь хөөн хэлэлцэх хугацаа нь учруулсан хор хохиролтой дүйцэхгүй байна)

4. Олон үйлдэлтэй гэмт хэргийн эзэн холбогдогчийн хэн болох нь тогтоогдсон боловч, олдоогүй байгаа этгээдүүдийн хэргүүдийг нэгтгэх эрх зүйн зохицуулалт хийх, улмаар нийт учирсан нийт хохирлоос хамаарч хөөн хэлэлцэх хугацааг тооцох (тохиолдол 2-т дурьдагдах жишээ)

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ
ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАГДСАН БАЙДАЛ

Цагдаа судлалын магистрант,
цагдаагийн ахмад Д.Наранбаатар

Товчлол. Төрийн тусгай албан тушаалд ажиллаж байгаа цэрэг, цагдаагийн цолтой алба хаагчид хуульд заасан ажилласан жил болон тэтгэвэр тогтоох насны болзол шаардлага хангасан тохиолдолд Тэтгэврийн даатгалын сангаас насан туршид нь амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгө авах эрх үүсдэг.

Энэхүү өгүүлэлд цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж авахтай холбоотой харилцаа Монгол Улсын хууль тогтоомжид хэрхэн тусгагдсан байгааг судалж үзэн, судлаачийн үүднээс дүгнэлт хийх, зарим дэвшүүлсэн саналын талаар товч тусгалаа.

Түлхүүр үг. Цагдаагийн алба хаагч, өндөр насны тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн даатгал, даатгуулагч

Удиртгал. Төрийн албаны тухай хуулийн 61.1.1-д “албан тушаалын цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал, урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж авах”²⁹ гэж төрийн албан хаагчийн нийтлэг баталгааны нэг төрөл хэлбэр болон тусгагдсан байдаг.

Цагдаагийн алба хаагч нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн тусгай албан тушаалд хамаардаг бөгөөд Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 83.2³⁰ -д заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авдаг.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 2¹.8-д “Өндөр насны тэтгэвэр гэдэг нь хуульд заасан тэтгэвэр тогтоох насны болон ажил хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлж ажилласан хугацааны болзол хангасан даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас насан туршид нь амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгийг хэлнэ”, 2¹.9-д “тэтгэмж гэж хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгийг”³¹ ойлгохоор тодорхойлсон байна.

Өөрөөр хэлбэл өндөр насны тэтгэвэр гэдэг нь хуульд заасан тэтгэвэр тогтоох насны болон ажил хөдөлмөр эрхэлж, шимтгэл төлж ажилласан хугацааны болзол хангасан даатгуулагч иргэнд Тэтгэврийн даатгалын сангаас насан туршид нь амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгож байгаа мөнгөн хөрөнгө юм. Нийт 10-20 хүртэл жил шимтгэл төлсөн, 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож болно.

Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж болон тэтгэвэрт гарахад түүнд 36 сарын цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгох зохицуулалт нь эдийн засгийн баталгааны нэг томоохон хэсэг юм.

²⁹ Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль

³⁰ Төрийн мэдээлэл. 1994. №8. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

³¹ Төрийн мэдээлэл 1994. №8. Нийгмийн даатгалын тухай хууль

Үндсэн хэсэг. Өнөөдөр өндөр насны тэтгэврийг даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн 20 жилийн доторх аль дуртай дараалсан таван жилийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас 45 хувиар тогтооно. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жилээс илүү төлсөн жил тутамд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлсний 1.5 хувиар бодож нэмэгдэл олгож байна.

УИХ-аас 2018 оны хоёрдугаар сарын 2-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн зүйл заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуулийн 61 дүгээр зүйлд зааснаар өндөр насны тэтгэврийг өөрийн хүсэлтээр эрэгтэй 60 нас, эмэгтэй 55 насандаа тогтоолгох даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн байвал зохих доод хугацааг 2038 он хүртэл жил бүр гурван сараар нэмэгдүүлэхээр өөрчилжээ.³²

Өнөөдөр Монгол Улсад тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой харилцаа дараах хууль тогтоомжуор зохицуулагдаж байна. Тухайлбал:

- Цагдаагийн албаны тухай хууль;³³
- Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль;³⁴
- Нийгмийн даатгалын тухай хууль;³⁵
- Нийгмийн халамжийн тухай хууль;³⁶
- Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль;³⁷
- Төрийн албаны тухай хууль;³⁸
- Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль;³⁹
- Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль⁴⁰ зэрэг хууль тогтоомжууд зохих хэмжээгээр холбогдож байна.

Харин цэрэг, цагдаагийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой харилцаанд дээрхи хууль тогтоомжууд бүгд хамаарахгүй бөгөөд Төрийн албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжуудын холбогдох зүйл заалтуудаар зохицуулагддаг байна.

Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль⁴¹д “Энэ хуулийн зорилт нь Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогч нарт тэтгэвэр, тэтгэмж тогтоож, олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан байдаг.

³² <https://news.mn/r/2464606/>

³³ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

³⁴ Төрийн мэдээлэл. 1994. №8. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

³⁵ Төрийн мэдээлэл 1994. №8. Нийгмийн даатгалын тухай хууль

³⁶ Төрийн мэдээлэл 2012. №8. Нийгмийн халамжийн тухай хууль

³⁷ Төрийн мэдээлэл 2020. №15. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль

³⁸ Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль

³⁹ Төрийн мэдээлэл 2002. №44. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль

⁴⁰ Төрийн мэдээлэл 1999. №29. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль

⁴¹ Төрийн мэдээлэл. 1994. №8. Цэргийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

Цагдаагийн алба хаагчийн Төрийн албаны тухай хуульд заасан төрийн тусгай албан тушаалд хамаардаг тул төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой охицуулалт ерөнхий суурь зохицуулалт болно.

Төрийн албаны тухай хуульд тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зохицуулалтыг түүвэрлэн авч үзвэл:

Хүснэгт №1

№	Хуулийн нэр	Зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
1.	Төрийн албаны тухай хууль ⁴²	Тэтгэвэр, тэтгэмж	
		4.5.	Төрийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг энэ хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар тус тус зохицуулна.
2.		9.2.	Төрийн албаны зардлыг бууруулах талаар төрөөс авах арга хэмжээ нь төрийн албан хаагчид олгох цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, тэтгэвэр, тэтгэмж болон бусад төлбөрийн хэмжээг бууруулах, түр буюу бүрмөсөн зогсоох үндэслэл болохгүй.
3.		46.3	Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана. Төрийн жинхэнэ албан хаагч тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц болон төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэл үргэлжлүүлэн ажиллуулахаар тогтоосон хугацаа дуусмагц төрийн албанаас чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргаагүй нь захиргааны санаачилгаар түүнийг төрийн албанаас чөлөөлөхөд саад болохгүй.
4.		59.1.4.	төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний авч байсан цалин, тэтгэвэр, тэтгэмжийн зөрүүг хөдөлмөрийн чадвараа түр алдсан буюу тахир дутуугийн тэтгэвэр авч байсан нийт хугацаанд нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
		59.1.5.	төрийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхад бие махбодид нь гэмтэл учруулсан буюу эрүүл мэндийг нь бусад хэлбэрээр хохироосноос хөгжлийн бэрхшээлтэй болж,

⁴² Төрийн мэдээлэл. 1994.№8. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

			хиймэл эрхтэн хийлгэх, сонсголын аппарат авах, нөхөн сэргээх бусад эмчилгээ хийлгэх бол зардлын тодорхой хэсгийг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу санхүүжүүлэх, зөрүүг улсын төсвөөс нөхөн олгож, хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх;
		60.1.	Төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох үндэслэлээр чөлөөлөгдсөн бол үндсэн цалингийн дунджаас ажилласан хугацааг нь үндэслэн тооцож нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгоно. Нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь 36 сарын үндсэн цалингийн дунджаас хэтрэхгүй байна. Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох цалингийн дундаж хэмжээ болон олгох шалгуур нөхцөлийг тодорхойлсон журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно. ⁴³

Төрийн албаны тухай хуульд тусгагдсан дээрхи зохицуулалтууд нь цэрэг, цагдаагийн цолтой, төрийн тусгай албан тушаалд хамаарах алба хаагчдын тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой үндсэн суурь болохын хувьд Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд холбогдох зохицуулалтууд орсон байна.

Цэргийн тэтгэвэр дараах төрөлтэй байна. Тухайлбал:

- Цэрэг, цагдаагийн байгууллагад алба хаасан тэтгэвэр;
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр;
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр.

Харин цэргийн тэтгэвэр дор дурдсан төрөлтэй байна. Үүнд:

1. хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж;
2. нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж;
3. нэг удаагийн тэтгэмж;
4. жирэмсний болон амаржсаны тэтгэмж.

Тэтгэвэр. Цэргийн тэтгэвэр, тэтгэмж тогтооход баримтлах хугацаанд цэргийн жинхэнэ алба болон тагнуул, төрийн тусгай хамгаалалт, цагдаа, шүүхийн шинжилгээний болон авлигатай тэмцэх, онцгой байдлын асуудал эрхэлсэн болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаасан нийт хугацааг тооцно.

Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч өөрөө хүсвэл цэргийн алба хаасан болон даатгалын шимтгэл төлсөн хугацааг нэгтгэн тооцож Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу өндөр насны тэтгэвэр тогтоож болно.⁴⁴

Цагдаагийн албан хаагчийн тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой зохицуулалтаас цагдаагийн алба хаагчтай холбоотой зарим зохицуулалтыг түүвэрлэн авч үзье.

Цагдаагийн албаны тухай хуулийн 91.1-д Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч тэтгэвэр тогтоолгох насны дээд хязгаарыг дараах байдлаар зохицуулж тусгажээ. Үүнд:

- цагдаагийн бага цолтой алба хаагч 47 нас;
- цагдаагийн дунд цолтой алба хаагч 52 нас;

⁴³ Төрийн мэдээлэл. 2018. №1. Төрийн албаны тухай хууль

⁴⁴ Төрийн мэдээлэл. 1994.№8. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

- цагдаагийн ахлах цолтой алба хаагч 55 нас;
- цагдаагийн дээд цолтой алба хаагч 57 нас;
- цагдаагийн бага цолтойгоос бусад эмэгтэй алба хаагчийн алба хаах насны дээд хязгаар нь 47 нас байна.

Насны дээд хязгаарт хүрсэн цагдаагийн алба хаагчийн алба хаах хугацааг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн 5 хүртэл жилээр сунгаж болно.

Мөн хуулийн 86.2-д цагдаагийн алба хаагчийн албадан эрүүлжүүлэх, саатуулах байр, улсын онц чухал объектын хамгаалалтад болон замын хөдөлгөөн зохицуулах, эргүүл, харуул, жижүүрийн албанд ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар⁴⁵ тус тус тооцохоор тусгагдсан байна.

Тэтгэмж. Цагдаагийн албаны тухай хуулийн 86.1-д “Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас амь насаа алдсан тохиолдолд 10 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тухайн алба хаагчийн сарын үндсэн цалингийн дунджаар тооцож түүний гэр бүлд нэг удаа олгоно”

Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зохицуулалт үндсэн эх сурвалж болох хууль тогтоомжид хэрхэн тусгасаныг түүвэрлэн авч үзвэл:

Хүснэгт №2

№	Хуулийн нэр	Зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
5.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль ⁴⁶	Тэтгэвэр	
		7.2	.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр тогтооход баримтлах сарын дундаж цалин хөлсийг тэдний цэргийн алба хаасан сүүлийн 20 жилийн доторх дараалсан 5 жилийн цалин хөлсний нийлбэрийг 60-д, 5 хүртэл жил алба хаасан бол цэргийн алба хаасан нийт хугацаанд авсан цалин хөлсний нийлбэрийг алба хаасан сарын тоонд тус тус хувааж тодорхойлно.
6.		9.1	.Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно
7.		9.2	Илүү алба хаасан жил тутамд 1.5, сар тутамд 0.125 хувиар цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон цалин хөлснөөс тооцож нэмэгдэл олгоно.
8.		21.1	Цэргийн алба хаагчийн тэтгэврийг тогтоох, олгох ажлыг тухайн тэтгэвэр авагчийн алба хааж байсан байгууллага буюу тэдгээрээс гэрээ байгуулсан этгээд эрхлэн гүйцэтгэнэ.
		10	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авах эрх
		12	Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн хэмжээ
		13	Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авах эрх
		14	Тэжээгчээ алдсаны тэтгэврийн хэмжээ
		Тэтгэмж	
9.		15	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах эрх
10.		16	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж олгох хугацаа
11.		17	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн хэмжээ
12.	17 ¹	Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх	

⁴⁵ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

⁴⁶ Төрийн мэдээлэл. 1994.№8. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль

13.		18	Нэг удаагийн тэтгэмж авах тохиолдол
14.		19	Нэг удаагийн тэтгэмжийн хэмжээ
15.		20	Нас барагчийн ар гэрт олгох тэтгэмж

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжийн тухай зохицуулалт нь цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж авах эрх зүйн гол эх сурвалж болж байна.

Түүчнлэн Цагдаагийн албаны тухай хуульд алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой цөөнгүй заалт тусгагдсан байна. Тухайлбал:

Хүснэгт №3

№	Хуулийн нэр	Зүйл, заалт	Зүйл заалтын агуулга
1.	Цагдаагийн албаны тухай хууль	Тэтгэвэр	
2.		76.2.	Алба хаагч.....тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн, алба хаах насны дээд хязгаарт хүрсэн үндэслэлээр албанаас чөлөөлөгдсөн бол ёслолын дүрэмт хувцсыг түүнд хадгалуулна.
3.		83.2.	Цагдаагийн алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.
4.		86.3.3	Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагчид авч байсан цалингийн зөрүү авах талаар тусгасан.
5.		91.1.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан үндэслэлээр цагдаагийн алба хаагч тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авах эрхтэй бөгөөд алба хаах насны дээд хязгаарын талаар тусгасан.
6.		97.2.	Цагдаагийн байгууллага, алба хаагчийн тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн үндэслэлээр цагдаагийн албанаас чөлөөлөгдсөн иргэнийг заналхийлсэн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
7.		Тэтгэмж	
8.		86.3.	Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу Засгийн газар дараахь нөхөх олговор, тусламж олгоно
9.		86.10.	Албан үүргээ гүйцэтгэх явцад эрүүл мэндэд нь хохирол учирснаас хөгжлийн бэрхшээлтэй болсон цагдаагийн алба хаагч, эдгээр үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнд амралт сувиллын болон нөхөн сэргээх эмнэлгийн байгууллагад эмчлүүлэхээр очих ба буцах замын зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу жилд нэг удаа олгоно.

Дээрхи хууль тогтоомжуудын холбогдох зүйл заалтуудыг авч үзвэл цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад гар нэг удаагийн буцалтгүй тусламж, олгох нөхцөл, журмыг Засгийн газар тогтоодог юм байна.

Дүгнэлт. Төрийн албаны тухай хуульд заасан төрийн тусгай албан тушаалд хамаарч байгаа цагдаагийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн харилцаа нь Төрийн албаны тухай хуульд заасан суурь зохицуулалт болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасан үндсэн зүйл, заалтаар зохицуулагджээ.

Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж болон цэргийн алба хаасны тэтгэвэрт гарахад гар нэг удаагийн буцалтгүй тусламж нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх нийгмийн болон эдийн засгийн баталгааны суурь зохицуулж болж байна.

Цагдаагийн албаны тухай хуульд цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой тодорхой зарим харилцааны зохицуулалт орсон боловч бүрэн ороогүй

Санал. Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зохицуулалтыг сайжруулах үүднээс дараах саналыг дэвшүүлж байна. Тухайлбал:

1. Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой зохицуулалтыг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиас салгаж, Цагдаагийн албаны тухай хуульд нэг бүлэг болгон тусгаж өгөх

2. Цагдаагийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмж олгохтой холбоотой ажил, арга хэмжээний талаар тусгайлсан судалгааны ажлыг хийх

3. Цагдаагийн байгууллагаас тэтгэвэрт гарсан болон тэтгэмж авдаг иргэдээс судалгаа авч эрх зүйн зохицуулалтын хувьд ямар хүндрэлтэй асуудал тулгарч байсан талаар судалгаа авч, тулгамдаж буй асуудлыг илрүүлэх.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хууль тогтоомж

1. Цагдаагийн албаны тухай хууль
2. Төрийн албаны тухай хууль
3. Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль
4. Нийгмийн даалтгалын тухай хууль
5. Нийгмийн халамжийн тухай хууль
6. Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль
7. Тэтгэмжийн доод хэмжээ тогтоох тухай хууль
8. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хууль

Сэтгүүл, гарын авлага

9. Төрийн мэдээлэл. 1994. №8.
10. Төрийн мэдээлэл 1999. №29.
11. Төрийн мэдээлэл 2002. №44.
12. Төрийн мэдээлэл 2012. №8.
13. Төрийн мэдээлэл. 2017. №8.
14. Төрийн мэдээлэл. 2018. №1.
- Төрийн мэдээлэл 2020. №15.

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ЦАГДААГИЙН АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ АЖЛЫН ЦАГИЙН АЧААЛАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

*ДХИС-ийн магистрант,
цагдаагийн дэд ахлагч
Ц.Мягмарсүрэн*

Товчлол: Энэхүү өгүүлэлд ажлын ачаалал, ажлын цагийн тухай ойлголт, түүний төрөл, хэлбэр, ажлын хэт ачааллын үр дагавар болон цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачаалал, түүний нөлөөлж буй хүчин зүйл, ачааллыг бууруулах зарим арга замын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Цагдаагийн ахлагч, ажлын ачаалал, ажлын цагийн ачаалал, ажил мэргэжил, албан тушаал, ажил үүрэг, ажил үүргийн шинжилгээ, ажлын чадамж, оюуны чадамж

Удиртгал. Цагдаагийн байгууллага нь алба хаагчдынхаа ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлтэй тооцоолж, хүн хүч, бүтэц зохион байгуулалтаа оновчтой төлөвлөх явдал нь гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, иргэдэд чанартай, шуурхай, жигд хүртээмжтэй үйлчлэх, алба хаагчдын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой.

Нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг гүйцэтгэдэг цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачааллыг тогтоох, нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, ажлын цагийн ачааллыг бууруулах, тэнцвэржүүлэх нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Бид өнөөдөр нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг голлон хэрэгжүүлдэг цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын ачааллын талаар онцлон авч үзэх нь цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны өнөөгийн нэг тулгамдсан асуудал гэж судлаачийн хувьд үзэж байна.

Үндсэн хэсэг: Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачааллын талаар авч үзэхээс өмнө ажлын цагын тухай ойлголт, түүний төрөл, хэлбэр, ажлын цагийн ачаалал, тэр дундаа ажлын хэт ачаалалтай холбоотой ойлголтыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Ажилтнууд ажил олгогч этгээдийн мэдэлд байж хөдөлмөрийн дотоод журамд захирагдан хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой хуулиар тогтоосон хугацааг ажлын цаг гэж үзнэ.⁴⁷

Ажлын цагийн дээд хэмжээг хөдөлмөрийн хууль тогтоомжоор зохицуулдаг байхад, ажлын цаг ашиглах журмыг албан газар, байгууллагын тухайд бол хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журам, ажлын ээлжийн хуваарь батлах тухай захиргааны тушаалаар, хувь хүмүүсийн тухайд бол хөдөлмөрийн гэрээгээр /нярай хүүхэдтэй эхчүүд, эрүүл мэндийн улмаас хөдөлмөрийн чадвар буурсан ажилтан, ажлын бүтэн бус цагаар ажиллагсад/ зохицуулдаг байна.

⁴⁷ www.slideshare.net/giimaabn/6-27757386

Ажлын цаг нь дараах төрөлтэй байна.

1. Хэвийн ажлын цаг
2. Богиносгосон ажлын цаг
3. Бүтэн бус ажлын цаг
4. Уртасгасан ажлын цаг .
5. Ээлжийн ажлын цаг
6. Шөнийн цаг
7. Дуудлагын цаг⁴⁸

Хэвийн ажлын цаг. Ажлын цагийн дээд хязгаарыг хуулиар “Ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 хүртэл цаг, долоо хоногийн ажлын цаг нь 40 хүртэл байна”⁴⁹ гэж тогтоосон байдаг. Хэвийн ажлын цаг нь ажилтнууд 7 хоногт 40 хүртэл цаг ажиллаж байгаа хугацааг хэлдэг.

Богиносгосон ажлын цаг. Энэ нь хэвийн ажлын цагийн үргэлжлэлийг хорогдуулсан шинжтэй ажлын цаг юм. Богиносгосон ажлын цагийг хуулиар эсвэл хамтын гэрээгээр тогтоодог. Тухайлбал 7 хоногийн ажлын цаг нь 14-15 насны ажилтанд 30 цаг хүртэл, 16-17 насны болон хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байна. Үүнд хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагсад⁵⁰, хөдөлмөрийн чадвар буурсан ажилтнууд⁵¹, жиллахын хамт суралцагсад⁵² хамаарна.

Бүтэн бус ажлын цаг. Энэ нь хэвийн болон богиносгосон ажлын цагийг тэдэнтэй байгуулах хөдөлмөрийн гэрээгээр хорогдуулан тогтоосон ажлын цаг юм. Бүтэн бус ажлын цагийг тогтоох нь ажилтны хүсэл зоригтой холбоотой байна.

Уртасгасан ажлын цаг. Энэ нь хэвийн болон богиносгосон ажлын цагийн үргэлжлэлийг нэмэгдүүлэн тогтоосон ажлын цагийг хэлнэ. Практикт уртасгасан ажлын цагийг илүү цаг гэж нэрлэдэг.

Ээлжийн ажлын цаг. Нэг ээлжийн ердийн ажлын цагийн үргэлжлэл найман цагаас илүүгүй байна. Ажил олгогч ажилтантай тохиролцсоны дагуу хуульд өөрөөр заагаагүй бол ээлжийн ажлын цагийн үргэлжлэлийг дөрвөөс илүүгүй цагаар уртасган зохион байгуулж болно.

Шөнийн цаг. Орон нутгийн цагаар 22 цагаас дараагийн өдрийн 06 цаг хүртэлх хугацааг шөнийн цагт тооцно.⁵³

Дуудлагын цаг. Ажил олгогч ажилтантай байршил, хугацааг тохиролцож ердийн ажлын цагаас бусад цагт дуудаж ажиллуулахад бэлэн байхаар хүлээлгэсэн хугацааг ажилласан цагт тооцно.⁵⁴

Ажлын цагийн ачаалалд ажлын цагийн дэглэм чухал нөлөө үзүүлдэг.

⁴⁸ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар ээлжийн ажлын цаг, шөнийн цаг, дуудлагын цаг гэсэн нэр томъёонууд шинээр тусгагдсан байна.

⁴⁹ Төрийн мэдээлэл. 2021. №31. Хөдөлмөрийн тухай хууль

⁵⁰ Ажлын байрны хэвийн бус нөхцлийг эрх бүхий байгууллага тогтоосон бол ажил олгогч нь түүнийг үндэслэн ажлын цагийг богиносгох үүрэгтэй

⁵¹ Ажлын цагийг богиносгох хэмжээг эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр тогтооно

⁵² Ажиллахын хамт орой эчнээгээр суралцагсдын ажлын цагийг богиносгох асуудлыг тухайн байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна

⁵³ <https://www.slideshare.net/giimaabn/6-27757386>

⁵⁴ Төрийн мэдээлэл. 2021. №31. Хөдөлмөрийн тухай хуулийн 87 дугаар зүйл. Ээлжийн ажлын цаг, 88 дугаар зүйл Шөнийн цаг. 89 дүгээр зүйл. Дуудлагын цагийн зохицуулалтыг тусгасан байна.

Ажлын цагийн дэглэм. Ажилтнуудын ажлын цагийг цаг тооллын тодорхой цаг үеүүдэд хувиарлан зохицуулсныг ажлын цагийн дэглэм гэнэ. Энэ нь ажлын цагийн хэмжээ, ажлын ээлжийн зохицуулалт, ээлжийн үргэлжлэл, ажил эхлэх, дуусгавар болох хугацаа, үдийн завсарлагын цаг гэх мэт элементүүдтэй байна.

Ажлын цагийн ачаалал нь ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлдөг тул ачааллыг бууруулах нь байгууллагын өмнөө тавьсан зорилгыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Монгол хэлний их тайлбар тольд ажлын ачааллыг “Зохих хүч чадлын хэм хэмжээнд тохирох ажил үүрэг, хувь: ачаалал ихдэх (хийвэл зохих ажил оногдсон хэм хэмжээнээсээ хэтрэх), биеийн ачаалал (биед оногдсон ажлын хэр хэмжээ), цахилгааны ачаалал (цахилгаан гүйдлийн оногдсон хувь), ажлын ачаалал (хийх ажлын хэмжээ)”⁵⁵ хэмээн тайлбарлажээ.

Мөн уг тайлбар тольд:

- ачаалал ихдэх - хийвэл зохих ажил оногдсон хэм хэмжээнээсээ хэтрэх;
- биеийн ачаалал - биед оногдсон ажлын хэр хэмжээ;
- ажлын ачаалал - хийх ажлын хэмжээ хэмээн тус тус тайлбарлажээ.

Ажил эрхлэлт гэдэг нь бидний өдөр тутмын ихэнх хэсгийг эзэлдэг бөгөөд бидэнд бага багаар тогтвортой хуваарь өгдөг бөгөөд энэ нь бидний амьдралыг зохион байгуулж, тодорхой дэг журам, тэнцвэрийг өгдөг. Гэсэн хэдий ч бид олон удаа шаардлагатай байгаагаасаа илүү их ажил хийж, амьдралынхаа бусад талыг золиосолж, сэтгэл хөдлөл, сэтгэл зүй, бие бялдрын түвшинд янз бүрийн бэрхшээлтэй тулгардаг.⁵⁶ Хүссэнээсээ илүү ажиллах нь урт хугацаанд бүтээмжийг бууруулдаг.

Цагдаагийн алба хаагч болон тэдний дээд албан тушаалтнууд хоёулаа өөрсдийн хүслээр эсвэл хууль ёсны үүргийн дагуу хамгийн ихдээ 8 цаг ажиллах, 8 цаг амрах, 8 цаг унтахыг хүндэтгэхийг хичээдэг боловч энэ нь бодит байдал дээр маш хэцүү болж хувирдаг.

Өнөөдөр цагдаагийн алба хаагчид хуульд заасан 8 цагаас илүү их ачаалалтай ажиллаж байгаа нь ажлын бүтээмжийг бууруулах нэг хүчин зүйл болж байна. Тэр дундаа ажлын хэт ачаалалтай ажиллах нь алба хаагчийн эрүүл мэнд, ар гэр амьдралд нь сөргөөр нөлөөлж байна.

Ажлын хэт ачаалал гэдэг нь хүн бүрт өөр өөрөөр мэдрэгддэг зүйл юм. Ердийнхөөсөө илүү ажил хийдэг, дарамтанд илүү сайн ажилладаг хүмүүс байдаг бол нөгөө талд илүү хурдан ажиллаж, улам дорддог хүмүүс байдаг.

Ажлын хэт ачааллын гол үр дагаврыг бид тэр дор нь харахгүй боловч хэсэг хугацааны дараа харах болно. Энэ нь дараах байдлаар илэрдэг байна.

1. Сэтгэл түгших

Илүү их ажиллах, илүү цагаар ажиллах, хүргэх хугацааг дуусгах эсвэл өдөр тутмын ажлыг сүүлчийн минутанд гарч ирдэг ажлуудтай хослуулах нь стресс үүсгэдэг бөгөөд ингэснээр бие нь стресстэй нөхцөл байдалд бэлдэж, бие махбодийн болон сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлдөг. Байнгын түгшүүртэй хүмүүс чихрийн шижин, таргалалт, зүрх, хоол боловсруулах эрхтний асуудал зэрэгт илүү эмзэг байдаг. Тэд илүү их идэх, тамхи татах, эсвэл илүү эрсдэлтэй, үйл ажиллагааны доголдол гаргах хандлагатай байдаг.

2. Сэтгэлийн хямрал

Сэтгэлийн хямрал нь ажлын хэт ачааллын хамгийн ноцтой үр дагаврын нэг бөгөөд сэтгэлийн түгшүүр юм. Сэтгэл гутралд орно гэдэг нь байнга уйлна гэсэн үг биш юм. Эсвэл

⁵⁵ <https://mongoltoli.mn/dictionary/detail/8568>

⁵⁶ <https://mn.warbletoncouncil.org/>

уйтгар гунигийг мэдэрнэ. Энэ нь цочромтгой байдал, хайхрамжгүй байдал, сэтгэлийн хөдлөлийг илэрхийлдэг.

Хэт их ажил хийх нь ажилтанг бухимдуулж, өөрсдийгөө дуртай зүйлдээ зориулж болох юм шиг мэдрэмж төрүүлдэг. Гэхдээ тэд гэртээ ирээд спорт, ном унших, зугаалах, хайртай хүмүүстэйгээ цагийг өнгөрөөх эсвэл амрах гэх мэт эрүүл мэндэд тустай ажил гэх мэт дуртай зүйлдээ цаг зарцуулах дургүй байдаг.

Энэ нь ажилтанг улам их бухимдуулж, тасралтгүй уур уцаартай байдалд ороход хүргэдэг бөгөөд сэтгэл ханамжгүй байдал, ажил нь алба хаагчийн хэрхэн яаж залгиж байгааг хараад гүн харамслын мэдрэмжийг улам бүр дордуулдаг байна.

3. Шаталтын синдром

Стресс, сэтгэлийн хямралтай холбоотойгоор бид ажлын улмаас шатсанаас болж гардаг алдарт Burnout хам шинжийн тохиолдол байдаг. Энэхүү синдромыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ) хүлээн зөвшөөрсөн ба сэтгэл хөдлөл, сэтгэлзүйн болон бие махбодийн асуудлуудыг хамардаг.

Ажилчдын чухал хэсэг нь эрүүл мэндийн энэ байдлаас болж сэтгэл гутралын шинж тэмдгүүдийн хамт байнгын стресс, түгшүүрийн байдалд амьдардаг. Хүн амын дунд тархалт нэмэгдэж байгаа бөгөөд үүнээс эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгжүүд ажлын байран дээр үүнээс зайлсхийхэд улам бүр оролцдог.

4. Унтахад асуудалтай болдог.

Шаардлагатайгаас илүү их ажил хийх шаардлагатай хүмүүс үүр цайтал ажилтай байх нь түгээмэл байдаг. Энэ нь циркадын мөчлөгийг тасалдуулж, улмаар удаан хугацаанд унтах ноцтой асуудал үүсгэдэг.

Унтаж чаддаг байсан ч унтахдаа бэрхшээлтэй болдог. Ажилтан орондоо байхдаа маргааш нь үлдсэн бүх зүйлийн талаар бодож, амарч чадахгүй. Энэ нь унтах цаг гаргахаас гадна түүний нойрыг засч залруулахгүй гэсэн үг юм Үүний үр дүнд маргааш нь ажилтан ажил дээрээ хангалттай ажиллах чадваргүй болж бүр ч их ядардаг.

5. Булчин өвддөг

Бүх ажил өөр өөр байдаг ч бүгдэд нь булчингийн тогтолцоо зовдог. Булчин өвдөх, гэмтэх нь илүү их тохиолддог. Хэд хэдэн бие бялдрын хүч чармайлт гаргах шаардлагатай байдаг эдгээр мэргэжлүүдэд үе мөч нь хэтэрхий удаан зарцуулагддаг бол мөгөөрсийг элэгдэж гэмтэх, тухайлбал лумбаго, шөрмөс сунах, сунах зэрэг эрсдэлд ордог.

Албан тасалгааны хувьд ердийн зүйл бол компьютерын ард хэдэн цаг сууж байх, ар араасаа өвдөх нь элбэг тохиолддог. Чухамдаа нэг байрлалд 20 минутаас дээш хугацаагаар суух, ялангуяа нуруу нь муруйсан байх нь булчингийн гэмтэл үүсгэдэг.⁵⁷

6. Нийгмийн харилцааны доройтол

Хийх ёстой зүйлээс илүү их ажиллана гэдэг нь ажилтан ажил дээрээ илүү их цаг зарцуулах тусам ойр дотны хүмүүстэйгээ харьцангуй бага цаг зарцуулж, улмаар харилцаа хүйтрэхэд хүргэдэг.

Гэхдээ үүнээс болж зөвхөн харилцаа мууддаггүй. Гэртээ ирэхэд гэр бүлийнхэнтэйгээ ярих эсвэл найз нөхөдтэйгээ уулзах дургүй байдаг тул тэдэнд бас нөлөөлдөг. Мөн бусад хүмүүстэй харьцах шаардлагагүй өөр хэлбэрээр орондоо хэвтэхийг эсвэл амрахыг илүүд үздэг.

⁵⁷ Роберт Херон. Ажил үүргийн болон ажлын шинжилгээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Орчуулгын бүтээл. УБ.2021. 6 дахь тал

7. Ажлын муу динамик

Эдгээр бүх эрүүл мэндийн үр дагаваруудаас гадна оффис нь ажилчдад маш их дарамт үзүүлдэг тул тэд үүнтэй холбоотой болж магадгүй юм. тэдгээрийн хоорондын харилцааны асуудлууд.⁵⁸

Ажлын цагийн ачааллаас үүдэлтэй почромтгой байдал, сэтгэлийн хямрал, сэтгэлийн түгшүүр, бухимдал нь ажилтныг өөрсдийгөө харах, будахыг хүсэхгүй байх болно. Учир нь тэд өөрсдийгөө байгаа бүх төрлийн сөрөг мэдрэмжүүдтэй холбодог. Энэ бүхэн нь энгийн үл ойлголцлыг бүх төрлийн зөрчилдөөн болгон хувиргах болно. Энэ нь ажилтны ажлын бүтээмж буурах нэг хүчин зүйл болдог байна.

Бид цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачаалал юунаас үүдэлтэй болох, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс юу болох талаар судалгаа хийлээ.

Ажлын ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар судлаж нийт давхардсан тоогоор 73 алба хаагчтай ярилцлага хийж, цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын ачаалал, ажилдаа хандах хандлагыг тодорхойлох зорилгоор санал асуулгын анкет боловсруулж, Баянзүрх, Сонгино-хайрхан дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн 125 алба хаагчаас онлайнаар судалгаа авлаа.

Судалгаанд хамрагдсан 125 алба хаагчийн 78 буюу 80.5 хувь нь эрэгтэй, 22 буюу 19.5 хувь нь эмэгтэй алба хаагчид байна.

Фокус ярилцлагын судалгааны үр дүнгээс үзвэл удирдлагаас өгч байгаа үүрэг даалгавар давхарддаг, мөн хариуцаж байгаа нутаг дэвсгэрийн хэмжээ том, хүн амын тоо их, ажилдаа баримталдаг эргүүл харуулын дүрэм журам практикт нийцдэггүй зэрэг олон шалтгааныг дурдсан байна.

Албан тушаал	Ажлын цагийн ачаалал	Учир шалтгаан
Хорооны байцаагч цагдаа нар	Өдөрт 12 цаг 7 хоногт 84 цаг	Хорио цээрийн үед амралтгүй ажилладаг.
Явган эргүүлийн офицер цагдаа нар	Өдөрт 10 цаг 7 хоногт 70 цаг	Тогтмол амардаггүй, зөвхөн ээлж тааруулж 1 хоног амрах зохицуулалт хийдэг.
Машинт эргүүл	7 хоногт 84 цаг	24:48 цагаар ажилладаг
Удирдлагуудын жолооч нар	7 хоногт 60 цаг 2 хоног амардаг	Хорио цээрийн үед 24 цаг ажилладаг
Нэмэгдэлээр гарч байгаа Хүч спорт хороо	Эхний удаа 15 хоног 360 цаг гарсан	Дараагийн ээлж 11 хоног 268 цаг 7 хоногт 72 цаг

Судалгааны дүнгээр цагдаагийн ахлагч бүрэлдэхүүнээс хамгийн их цаг ажилладаг нь хорооны хэсгийн цагдаа болон машинт эргүүлийн алба хаагч нар бөгөөд тэд энгийн өдөрт 12 цаг 7 хоногт 84 цаг ажилладаг бол хорио цээрийн үед 24:48 ажиллаж 7 хоногт 1 хоног амрах зохицуулалтаар ажилладаг гэсэн судалгааны дүн гарч байна.

Нийт судалгаанд хамрагдсан 200 алба хаагчаас 50%-аас дээш хувь нь хорио цээрийн үед 24:48 цагаар тогтмол амралтгүй ээлж тааруулж 1 хоног амрах зохицуулалтаар ажиллаж байгаа нь тухайн алба хаагчдын бие эрүүл мэндэд муугаар нөлөөлж байна.

Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн нь 2020 оноос хорио цээрийн дэглэмд шилжсэнээр тусгаарлалттай бүсүүдэд 14 хоног амралтгүй байрлаж ажиллаж байгаа нь тухайн алба хаагчдыг

⁵⁸ Роберт Херон. Ажил үүргийн болон ажлын шинжилгээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Орчуулгын бүтээл. УБ.2021. 6 дахь тал

амраах, сэтгэл зүйн засал болон бие бялдрын бэлтгэл, сургуулилт байхгүй болоход нөлөөлсөн байна.

Цагдаагийн ахлагч нар Коронавируст халдвар /Ковид-19/- цар тахлын үед өөрсдийн амь нас, эрүүл мэндээ үл хайхран олон нийтийн аюулгүй байдлыг хангах хуулиар хүлээсэн үүргээ хариуцлагатай биелүүлж байсан ч олон хоног ажиллах нь тэдний гэр бүл, үр хүүхэд нь хүндээр тусаж байна. Энэ цагдаагийн алба хаагчдын нийгмийн баталгаа болон гэр бүлийн ариун нандин холбоо алдагдаж гэр бүл салалт, архидалт, хардалт зэрэг муу үр дагавар үүсэхэд нөлөөлж байна.

Хорио цээрийн үед 1 алба хаагч 12-14 цаг ажиллаж байсан гэсэн судалгаа гарсан бөгөөд энэ нь илүү цагаар олон хоног ажиллахад тухайн алба хаагчид нэмэгдэл урамшуулал, нэмэгдэл цалин байхгүй байгаа нь тэднийг бухимдуулах, стресс өртөхөд нөлөөлсөн нэг хүчин зүйл болсон байна.

Цагдаагийн байгууллагын 60 хувийг нь ахлагч бүрэлдэхүүн эзэлдэг. Өнөөдөр цагдаагийн байгууллага ахлагч бүрэлдэхүүний ажлын хэт ачаалал, түүний сөрөг үр дагавраас зайлсхийхийн тулд нэн даруй арга хэмжээ авах ёстой.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлага хуульд заасан хөдөлмөрийн цагийг хүндэтгэхийг хичээхээс гадна байгууллагын сайн соёлыг сурталчлахыг хичээх хэрэгтэй. Ялангуяа ажлын зохион байгуулалт, дэг журамтай холбоотойгоор алба хаагчдыг илүү цагаар ажиллуулахгүйн тулд зохион байгуулалтын оновчтой арга хэмжээг авах хэрэгтэй.

Нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлага ахлагч бүрэлдэхүүнд ажлын хэт ачаалал гарсан гэж үзвэл энэ үзэгдэл юунаас болж үүссэн болохыг тогтоох ёстой. Тодорхойлсны дараа түүнийг дахин давтахгүй байхын тулд нөөцийг дайчлан ажиллуулах, эсвэл байгууллагын хамтын бүтээмжийг нэмэгдүүлэх, алба хаагчдын эрүүл мэндэд хортой нөлөөллөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй.

Ажлын хэт ачаалалд хувь нэмэр оруулж буй нэг асуудал бол том, чухал ажлуудын урт, урт хугацааны эцсийн хугацааг тавих, богино хугацаанд илүү их амжилтанд хүрэх боломжтой, өдөр бүр хялбархан биелэгдэх боломжтой жижиг зорилтуудыг хуваах явдал юм.

Аливаа байгууллагын тавьсан зорилгодоо хүрэх үндсэн арга бол багаар ажиллах явдал бөгөөд энэ нь чиг үүргийг хуваарилах, үүрэг хариуцлагыг нэг хүнд биш харин хэд хэдэн хүнд оногдуулах, зорилгодоо хүрэх нь үр дүнтэй юм. Тиймээс цагдаагийн алба хаагчдын ажлын ачаалалд ажил үүргийн шинжилгээ хийж, ачаалалд нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйлийг олж тогтоон, түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Ажил үүргийн шинжилгээ гэдэг нь гүйцэтгэх ажлыг хэд хэдэн салангид ажил үүргүүдэд нарийвчлан системтэйгээр хуваадаг аргачлалыг хэлнэ.⁵⁹

Ажлын шинжилгээ гэдэг нь ажил үүргийн шинжилгээтэй холбоотой боловч арай илүү өргөн хүрээтэй ойлголт юм. Ажил үүргийн шинжилгээ нь тодорхой үүргүүдийг багтаасан тухайлсан ажлын хүрээнд л яригддаг.⁶⁰

Ажил үүргийн шинжилгээг дараах 3 зүйлс дээр тулгуурлан хийнэ. Үүнд:

1. ажил мэргэжил (an occupation)

⁵⁹ Роберт Херон. Ажил үүргийн болон ажлын шинжилгээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Орчуулгын бүтээл. УБ.2021. 6 дахь тал

⁶⁰ Роберт Херон. Ажил үүргийн болон ажлын шинжилгээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Орчуулгын бүтээл. УБ.2021. 7 дахь тал

2. албан тушаал (a position)

3. ажил үүрэг (a job)

Ажил мэргэжил гэдэг нь гүйцэтгэх ёстой үүрэг даалгаваруудтай харьцангуй төстэй ажил үүргүүдийн нэгэн бүлэг бөгөөд тэдгээрийг амжилттай хийж гүйцэтгэхэд мэдлэг, ур чадвар, авьяас билгийг шаарддаг.

Албан тушаал гэдэг нь аливаа аж ахуйн нэгж, байгууллагын дотор аль нэг ажил үүргийн түвшинд хамаарна. Энэ нь гол төлөв тухайн албан тушаалын цол хэргэмээс харагддаг.

Ажил үүрэг гэдэг нь тухайн албан тушаалд хийж гүйцэтгэх тодорхой үүрэг, даалгаваруудыг хэлнэ.⁶¹

Албан тушаалын тодорхойлолт гэдэг нь аливаа нэг ажил үүргийн бүхий л чухал элементүүдийг тусгасан баримт бичиг юм. Энэ бол ажил үүргийн шинжилгээний нэгэн үр дүн болно.

Ажил үүргийн үнэлгээ гэдэг нь ихэвчлэн цалингийн түвшинг тодорхойлох зорилгоор ажил үүргийн ач холбогдлыг үнэлэх үйл явц юм. Энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэх хүнээс хамааралгүйгээр ажил үүргүүдийг хооронд нь ач холбогдол, үнэ цэнээр нь эрэмбэлэх үйл явц болно.

Ур чадвар гэдэг бол ямарваа нэг зүйлийг хийж гүйцэтгэхийн тулд оюун ухаан-бие махбодийн хоорондын зохицлыг шаардах чадварыг хэлнэ. Энэ нь биеийн хүчний чадамж, оюуны чадамж, мэдрэмжтэй холбоотой чадамжуудын нийлбэр гэж үзэж болно.

Аль ч тохиолдолд үүнийг ажлын хэт ачаалал гэж ойлгодог хэт их, пропорциональ бус, тогтмол байдлаар ажилтанд нэмэлт функц хуваарилсны үр дагавар. Ажилчин нь урам зоригийг мэдэрдэггүй, чанаргүй ажил хийдэг, эрүүл мэндэд нь нөлөөлж байгааг хардаггүй.

Ажлын чанарын индекс гэдэг нь тухайн ажил мэргэжил, салбарын ажлын чанарыг ажлын олон талт шинж байдлыг харгалзан биет буюу физик орчин, ажлын эрчим буюу ачаалал, ажлын цагийн чанар, нийгмийн орчин, ур чадвар ба оролцох чадамж, цалин, орлого гэсэн үндсэн 6 хэмжигдэхүүнээр багцлан хэмжиж, индексээр харуулж байгааг хэлнэ.

Цалин, орлогын индексээс бусад ажлын чанарын бүх индексийг 0-ээс 100 хүртэлх оноогоор хэмжих бөгөөд ажлын эрчим буюу ачааллын индексээс бусад индексийн оноо өндөр байх тусам ажлын чанар сайн байна гэж үзнэ.⁶²

Ажлын эрчим буюу ачааллын индекс

Ажлын эрчим буюу ачааллын индекс бага байх тусам сайн гэж үзнэ. Ажлын эрчим буюу ачааллын индекс нь тухайн ажилд тавигдах эрэлт, шаардлагын түвшинг илэрхийлнэ. Хэрэв ажлын ачаалал их, ажилд оюуны болон биеийн хүчний энерги ихээр зарцуулан янз бүрийн шаардлагад нийцэх, нарийн төвөгтэй ажиллагаа шаардагддаг бол ажлын даалгаврыг үр өгөөжтэй хийж гүйцэтгэхэд төвөг бэрхшээлтэй болдог.

Ажилд тавигдах шаардлагыг хэмжихдээ тоо хэмжээний ачаалал (ажиллах хурд), ажлын хурдыг тодорхойлогч хүчин зүйлүүд ба хоорондын хамаарал, түүнчлэн сэтгэл санаанд үзүүлэх ачааллын үзүүлэлтүүдийг ашиглаж байна.

Ажлын цаг, түүний үргэлжлэл болон зохион байгуулалт нь ажлын чанарт хоёр байдлаар нөлөөлж байна. Нэг талаас, ажлын цаг нь ажилтны эрүүл мэнд болон аюулгүй байдалд чухал

⁶¹ Мөн бүтээл. 8 дахь тал

⁶² Монгол Улсын ажлын байрны нөхцлийн түүвэр судалгаа- 2020. УБ.2021. 6 дахь тал

үүрэг гүйцэтгэнэ. Жишээ нь, ажлын үргэлжлэл урт байх хирээр ажиллагчид эрсдэлд өртөх нь нэмэгддэг бол хангалттай амрах хугацаа нь осол аюулгүй ажиллахад шийдвэрлэх үүрэгтэй.

Нөгөө талаар, ажил амралтын цагийн зохистой харьцаа нь ажилтны ажиллах, урт удаан хугацаанд үргэлжлэн ажиллах боломж олгох ёстой. Ажлын цагийн үргэлжлэл, зохион байгуулалтыг сайтар зохицуулснаар хувь хүн болон байгууллагын хоёулангийнх нь хэрэгцээнд нийцүүлэх боломжтой. Өнөө үед ажлын цагийн эхлэл болон төгсгөл, амралтын завсарлага, дуудлагын хугацаа зэргийг тооцсон илүү уян хатан, стандартын бус хэлбэрүүдийг ашиглах болсон. Энэ нь хэдийд ч, хаанаас ч ажлаа хийх боломж олгож буй мэдээллийн технологийн үр дүнтэй ч бас холбоотой юм.⁶³

Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын ачааллыг бууруулахад маш олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, урьдчилан сэргийлэх үндсэн ажилтай холбогдолгүй үүргийг хуулиар хариуцуулж, цагдаагийн байгууллагын хүн хүчийг тарамдуулж, оролцох ёсгүй зүйлд оролцуулах, түүнээс улбаалан алба хаагчийн нэр хүндийг олон нийтэд унагадаг асуудал байна. Тухайлбал, автомашины татвар хураахад, газар чөлөөлөх, албадан нүүлгэхэд оролцож байгаа нь цагдаа иргэдийн харилцаанд сөргөөр нөлөөлдөг. Тэр бүхэнд ихэвчлэн ахлагч бүрэлдэхүүн явж байгаа нь тэдний нэр хүндийг бууруулахаас гадна ажлын ачааллыг зохиомлоор нэмэгдүүлэх нэг хүчин зүйл болж байна.

Цагдаагийн алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг найдвартай хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй, тэднийг хамгаалах, дэмжих удирдлагын болон үйл ажиллагааны зөв менежмент ч хэрэгцээтэй байгаа төдийгүй алба хаагчдын нийгэм, эдийн засгийн баталгааг дээшлүүлэх асуудал нэн чухал болжээ.

Цагдаагийн алба хаагчдыг, тэр дундаа ахлагч бүрэлдэхүүнийг доромжлох, дарамтлах, тэдний хууль ёсны шаардлагыг иргэдийн зүгээс эсэргүүцэх, хүч хэрэглэх, амь биед нь халдах зэрэг үзэгдэл сүүлийн үед багагүй гарч байна.

Цагдаагийн байгууллага, ажилтны ажлыг үнэлж, дүгнэх тогтолцоог үндсээр нь өөрчлөх, шагнал, урамшуулал, хариуцлага тооцох, албан тушаал дэвших карьерын шударга тогтолцоог бий болгох зэрэг уг санал, зөвлөмжид тусгагдсан маш олон арга хэмжээний зарим нь биелэгдсэн, нөгөө хэсэг нь биелэгдэх шатандаа байгаа эдгээр төрийн бодлогын шинжтэй арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх нь нэн чухал шаардлагатай.

Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын ачааллыг зүй зохистой байлгах, ажлын чанарыг сайжруулах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд уг тогтоолд заасан нормативын дагуу улсын хэмжээнд офицер, цагдаа, энгийн ажилтан буюу нийт 5000 гаруй хүний орон тооны хомсдолтой ажиллаж байна гэсэн тооцоо судалгаа гарсан.

Цагдаагийн байгууллага нь хүнд сурталтай, цагдаагийн ажилтнууд дээрэнгүй, харьцааны соёлгүй, мэдлэг, мэргэжлийн ур чадваргүй, иргэдтэй тэгш бус харилцдаг, цагдаагийн удирдлагаас албан хаагчдын ажил үүргийн хараат бус байдалд нөлөөлдөг, танил тал, мөнгөтэй хүнд үйлчилдэг гэж олон нийт дүгнэсэн байна.

Нөгөө талаар иргэдээс цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэдэг ахлагч бүрэлдэхүүнийг дорд үзэх, гүтгэх, доромжлох нь ердийн үзэгдэл болсон, түүнчлэн алба хаагчдын ажлын цаг ихэнхдээ тодорхой бус, илүү цагаар ажилладаг, 24 цагаар

⁶³ Монгол Улсын ажлын байрны нөхцлийн түүвэр судалгаа- 2020. УБ.2021. 31 дэх тал

ажилчиад тухай өдөр үдээс хойш ахиж эргүүлийн үүрэг гүйцэтгэдэг, гэр бүлдээ анхаарал тавих цаг гардаггүй зэргээс шалтгаалж алба хаагчид бухимдах, цочрол (стресс)д орж улмаар иргэдтэй зүй бусаар харьцах байдал гаргадаг болох нь тогтоогдсон байна.

Цагдаагийн байгууллагаас үзүүлж байгаа ажил үйлчилгээнд иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг судлахад 70 орчим хувь нь дунд буюу түүнээс доош үнэлгээ өгч, харин нийт алба хаагчдын харилцааны соёлын тухайд хангалтгүй үнэлгээ өгсөн байна.

Судалгаагаар сүүлийн 2 жил ахлагч бүрэлдэхүүний ажлын ачаалал эрс нэмэгдсэн байгаа нь харагдаж байна. Уг судалгаагаар нийт алба хаагчдын 38 хувь нь цар тахалтай холбоотой өндөржүүлсэн бэлэн байдлаас үүдэлтэй ажлын ачаалал, Дарга удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн улмаас үүдэлтэй ажлын ачаалал нь 14 хувиар нэмэгдсэн.

Өдрийн 8 цаг ажиллахаар хөдөлмөрийн хуулиндаа заагдсан боловч цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг гүйцэтгэдэг алба хаагчид өдөрт 12-13 цаг ажилладаг Мөн бусад үйл ажиллагаанаас үүдэлтэй ажлын цагийн ачаалалд шууд бусаар нөлөөлж буй дор дурдсан хүчин зүйлүүд байна гэж судалгаагаар гарч ирлээ. Тухайлбал:

- Байгууллагын дотоод, гадаад соёл төлөвшөөгүй, байгууллагын үнэт зүйлийг бий болгож чадаагүй,

- боловсон хүчнийг сонгон шалгаруулж авах тогтолцоо шинэчлэгдээгүй,

- менежерийн сонголт учир дутагдалтай бөгөөд удирдах ажилтан бэлтгэх тогтолцоо бий болоогүй,

- алба хаагчдын гадаад хэлний мэдлэг хангалтгүй,

- шинэ мэдээлэл олж авах арга барилд суралцаагүй,

- багаар хамтран ажиллах чадвар муутай,

- алба хаагчдын дунд өвчлөл их,

- алба хаагчдыг цол, албан тушаалын байдлаар ялгаварлан гадуурхах хандлага бий болсон,

- төсөв хомсдолтой, төсвийн зарцуулалт оновчтой биш зэрэг бэрхшээл, сул тал байсаар байна.

Цагдаагийн алба хаагч ёс зүйн зөрчил гаргах, ёс зүйн хэм хэмжээг зөрчих явдал багагүй байна, ялангуяа танхайрах, архидан согтуурах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрэм, журам зөрчих, иргэдтэй, бусадтай зүй бус харьцах, харилцааны зарим дутагдал гаргах, бусдын биед гэмтэл учруулах, албаны нэр төрөөр далайлган, албан тушаалын байдлаа урвуулах нь цөөнгүй байгаа төдийгүй, аль болох хуурч, аргалах, өөрт ашигтай байдлаар төрийн ажлыг хийх, шударга бусаар ажиллах хандлагад зарим алба хаагч автагдаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах үүрэг гүйцэтгэгдэг ахлагч бүрэлдэхүүнийг хамгаалдаг эрх зүйн зохицуулалтгүй, нийгмийн баталгааг хангахад анхаарал тавьдаг дарга, удирдах бүрэлдэхүүн нэн ховор алба хаагчдаа гэсэн сэтгэлтэй боловсон хүчин хомс харин хамгаалахын оронд сахилгын арга хэмжээ авахыг эрмэлздэг болсон алба хаагчдыг албандаа итгэх итгэл сэтгэлгүй болгож байна.

Цагдаагийн байгууллагын шинэтгэлийн хүрээнд мэдээллийн технологийн дэвшлийг нэгдсэн бодлогоор эрчимтэй нэвтрүүлэх, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд шинжлэх ухаан, техник технологи, инновацийн үр ашигтай тогтолцоог нэвтрүүлэх замаар ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачааллыг бууруулах боломжтой юм.

Дүгнэлт: Цагдаагийн албаны тухай хуульд заасан гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг гудамж талбай, олон нийтийн газар хэрэгжүүлдэг гол хүч хэрэгсэл бол цагдаагийн ахлагч бүрэлдэхүүн юм байна.

Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын ачаалал нь судалгаагаар өндөр гарч байгаа нь тэдэнд нөлөөлж байгаа сөрөг хүчин зүйл багагүй байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

Ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачаалал өндөр байгаа нь тэдний биеийн нөхөн сэргээх боломж дутмаг болж, алба хаагчдын эрүүл мэндэд сөргөөр их нөлөөлж стресст өртөх, уур уцаартай болох, дотор эрхтэн, зүрх судас, даралт ихсэх зэрэг өвчнөөр өвдөх эрсдэлүүдийг бий болгосон байна. Тиймээс ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачааллыг бууруулах чиглэлээр цагдаагийн төв байгууллагын хэмжээнд бодлогын түвшинд ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага байна гэж дүгнэж байна.

Санал: Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн ачааллыг бууруулах, тэнцвэртэй болгоход нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын удирдлага бүр анхаарч ажиллах;

2. Ахлагч бүрэлдэхүүний ажлын цагийн зохиомол ачаалал үүсгэж байгаа хүчин зүйлсийг арилгахад цагдаагийн төв байгууллагын дотоод, хяналт шалгалтын нэгж анхаарч ажиллах;

3. Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний цагдаад тогтвортой ажиллах чин сэтгэлтэй болгоход шаардлагатай сэтгэл зүйн ажил, арга хэмжээг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулж хэвших;

4. Цагдаагаар ажиллах хүнийг сонгон авах, дадлагажуулах, сургах, төлөвшүүлэх ажлын нэгдсэн график загвар төлөвлөгөөг гаргаж хэрэгжүүлэх;

5. Цагдаагийн ахлагч бүрэлдэхүүний ажлын байранд үүсдэг “стресс”-ийг бууруулах чиглэлээр сэтгэл зүйн ажил, арга хэмжээг сар бүр зохион байгуулж хэвших;

6. Ахлагч бүрэлдэхүүний ажлыг бодитой үнэлэх, зөв зан үйлийг материаллаг зүйлээс бусад хэлбэрээр урамшуулж хэвших;

7. Удирдлагын зүгээс сэтгэл зүйчээр дамжуулан цагдаа нарын хүсэл сонирхлыг байнга сонсож, стресст өртүүлэхгүй байхад анхаарах зэрэг болно.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Хөдөлмөрийн тухай хууль
3. Роберт Херон. Ажил үүргийн болон ажлын шинжилгээ. Олон улсын хөдөлмөрийн байгууллага. Орчуулгын бүтээл. УБ.2021.
4. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код. УБ.2018
5. Монгол Улсын ажлын байрны нөхцлийн түүвэр судалгаа- 2020. УБ.2021
6. Төрийн мэдээлэл. 2021. №31.
7. <https://www.legalinfo.mn>
8. <https://mongoltoli.mn>
9. <https://mn.warbletoncouncil.org/www.slideshare.net>

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧТОЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ШИНЖИЛГЭЭ

Д.Цэрэнлхам

*Цагдаагийн сургуулийн
Цагдаагийн эрх зүйн тэнхимийн
багш, цагдаагийн ахлах дэслэгч*

Товч агуулга: Энэхүү өгүүлэлд орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаанд “гэмт хэргийн хохирогч” гэсэн ойлголтыг тодорхойлж буй 3 төрлийн үзэл баримтлал болон Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой холбоотой хууль, эрх зүйн орчин, нэр томъёоны тодорхойлолт, хохирогчийг хэрхэн тогтоож байгаа процессын эрх зүйн зохицуулалтын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: Хүн худалдаалах гэмт хэрэг, хохирогч, хүүхэд, эрх зүйн зохицуулалт

Удиртгал хэсэг: Монгол Улс хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орсноор уг гэмт хэрэгтэй тууштай тэмцэх үүргийг Дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн бөгөөд хүнийн наймаанд өртөх өндөр эрсдэлтэй орны тоонд багтаж буйн хувьд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлыг төрийн хуул тогтоох бодлогын хүрээнд зохицуулж тодорхой алхмуудыг хийж эхлээд багагүй хугацааг үдэж байгаа ч ХХГХ-тэй тэмцэх, таслан зогсоох нь тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.

Монгол Улсад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийг хамгаалах, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр дараах хууль тогтоомж мөрдөгдөж байна. Үүнд:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
2. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль
3. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль
4. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль
5. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль
6. Донорын тухай хууль
7. Зар сурталчилгааны тухай хууль
8. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
9. Зөрчлийн тухай хууль
10. Монгол Улсын Хилийн тухай хууль
11. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх тухай хууль
12. Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль
13. Төрийн хяналт шалгалтын тухай хууль
14. Хөдөлмөрийн тухай хууль
15. Хүүхдийн эрхийн тухай хууль
16. Хүүхэд хамгааллын тухай хууль
17. Эрүүгийн хууль
18. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

19. Эрүүл мэндийн тухай хууль

20. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

21. Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөр

22. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр

Үндсэн хэсэг: Өнөө үед гэмт хэргийн хохирогчид хандах чиг хандлага өөрчлөгдөж байгаатай холбоотойгоор гэмт хэргийн хохирогчийн тухай тодорхойлолт ч өөрчлөгдсөн байна. Орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаанд “гэмт хэргийн хохирогч” гэсэн ойлголтыг тодорхойлох 3 төрлийн үзэл баримтлал байна. Энэ нь:

1. Ихэнх улс оронд эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйд “Гэмт хэргийн улмаас оюун санаа, бие махбод, эд хөрөнгийн хохирол хүлээсэн хувь хүн байна⁶⁴” гэсэн үзэл хандлага,
2. Гэмт хэргийн улмаас хохирол хүлээсэн хувь хүн болон нийгмийн бүлгийг хохирогч⁶⁵ гэж үзэх хандлага,
3. Хувь хүн болон нийгмийн бүлэг төдийгүй гэмт хэргийн хохирогчийн гэр бүлийн гишүүд, тэжээлгэн тэтгүүлэгчдээс /шууд бус хохирогч/ гадна хүнд байдалд орсон хохирогчид тусламж, дэмжлэг үзүүлж байгаад хохирсон хүмүүс /дам хохирогч/ хамаарна⁶⁶ гэсэн үзэл баримтлалууд зэрэгцэн оршиж байна.

Гэмт хэргийн хохирогчийн тодорхойлолт хувь хүнээс гадна нийгмийн бүлэг байхаар өөрчлөгдөхийн эхлэл нь олон улсын эрх зүйн баримт бичгүүд, түүний дотор 1985 оны 12 дугаар сарын 11-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал”⁶⁷ байлаа.

Энэхүү үзэл хандлага нь Финляндын эрдэмтэн Матти Джоутсоны орчин үеийн гэмт явдлын хувьсал өөрчлөлттэй холбоотойгоор гэмт хэргийн хохирогчийн өөрчлөлтийн үзэгдэлд хийсэн судалгааг⁶⁸ үндэслэсэн бөгөөд Тунхаглалд: “Хохирогч гэдэгт гишүүн улсуудын дагаж мөрдөж байгаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглахыг хориглосон хуулиудыг оролцуулаад, Эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие махбодийн болон оюун санааны хохирол учирсан, сэтгэл санааны дарамтанд орсон, эд хөрөнгийн хохирол учирсан эсхүл үндсэн эрх нь ноцтойгоор зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно” гэж тодорхойлоод хохирогч, эрх зүйн зөрчил гаргагч хоёрын хоорондын төрөл садны харилцаатай байхаас үл хамааран “хохирогч” гэж тооцогдох, хохирогчдын тухай ойлголт нь арьс өнгө, нас хүйс, хэл, шашин шүтлэг, үндэс угсаа, улс төрийн болон бусад үзэл, соёл, нийгмийн болон

⁶⁴ Е.Бафия. Проблемы криминологии: диалектикакриминогенной ситуации. М.: 1983, С.108, Д.В.Ривман. Криминальная виктимология. СПб., 2002. С.35, Б.В.Сидоров. Поведение потерпевших от преступления и уголовная ответственность: Автореф. Дис. На соискание учебной степени доктора юрид. наук. Московский институт МВД России. 1998

⁶⁵ С.С.Остроумов, Л.В.Франк. О виктимологии и виктимности //Сов. Государство и право. 1976. № 4. С. 76

⁶⁶ Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх, НҮБ. Уб., 1996. 174 дэх тал

⁶⁷ Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай Тунхаглал. НҮБ-ын ЕА.40/34 дүгээр шийдвэр. 1985.11.29

⁶⁸ Joutsen M. Topic III of the Tentative agenda of the Seventh United Nations Congress on the Prevention of Crime and the Treatment of Offenders: Victims of crime and priorities in victim policy // Course on United Nations criminal Justice Policy. -Helsinki, 1985.-№ 6. -P. 151-152. -(HEUNI series)

язгуурын гарал, хөдөлмөрийн чадварыг үл харгалзан бүх этгээдэд нэгэн адил хэрэглэнэ” хэмээжээ.

Харин гэмт хэргийн улмаас хохирсон хүүхдийн тухай Хүүхдийн эрхийн тухай конвенцэд⁶⁹ “... 18 наснаас өмнө насанд хүрсэнд тооцогдоогүй бол 18 нас хүрээгүй хүн бүрийг хүүхэд гэнэ” гэсэн тодорхойлолт олон оронд /зарим улсад 21 хүртлэх насныхныг хүүхэд гэж үздэг/ мөрдөгдөж байгаа бөгөөд Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдүүдийн асуудалтай холбогдох шүүхийн эрх зүйн үйл ажиллагааны журамд “Хохирогч, гэрч хүүхдүүд” хэмээн гэмт хэрэг болон гэмт этгээд буюу бүлэг гэмт хэрэгтнүүдийг мөрдөн шалгах ажиллагаанд гүйцэтгэж буй үүрэг ролиосоо үл хамаарах, гэмт хэргийн хохирогч буюу гэмт хэргийн гэрч болсон хүүхдүүд буюу 18-аас доош насны этгээдийг хэлнэ⁷⁰ гэсэн тодорхойлолт өгчээ.

Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдэд холбогдох байцаан шийтгэх ажиллагааны тухай Загвар хууль болон түүнд холбогдох нэр томъёоны тайлбарт: “Хохирогч хүүхэд гэж ... гэмт хэрэгт эсвэл гэмт хэрэг үйлдсэн гэх этгээд буюу бүлэг этгээдэд ял сонсгоход ямар үүрэгтэй оролцож байгаа эсэхээс үл хамааран 18-аас доош настай гэмт хэргийн хохирогч ... болсон хүнийг хэлнэ”⁷¹ хэмээн тодорхойлсон нь агуулгын хувьд насанд хүрээгүй, хохирогч хүүхдийн тухай ойлголтыг өргөжүүлсэн гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, дээрх тодорхойлолт нь гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүүхэд хэн нэгний дарамт шахалтаар гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон тохиолдолд түүнийг “хохирогч” гэж тооцох боломжийг бүрдүүлсэн гэж үзэх үндэстэй байна.

Манай улсын хувьд эрүүгийн процессийн эрх зүйн харилцааны оролцогч-хохирогч, түүний эрх зүйн байдал нь Үндсэн хууль, Эрүүгийн болон Эрүүгийн процессийн хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгаалах тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тогтоогдоно.

Монгол хэлний үг зүйн тайлбарт “хохирогч” гэж хохирсон этгээд⁷² хэмээн тайлбарласан байдаг бол, хууль зүйн шинжлэх ухаанд “хохирогч” гэсэн нэр томъёо нь “улс төрийн хохирогч буюу хэлмэгдэгч”, “гэмт хэргийн хохирогч” гэсэн ерөнхий утгаар хэрэглэгдэж байна.

Монгол Улсад үйлчилж буй хууль дээрх хууль тогтоомжуудад заасан хохирогчийг тодорхойлсон байдлаас үзэхэд, манай улс “хувь хүн, хуулийн этгээд, дам хохирогчийг ч гэмт хэргийн хохирогч” гэж үздэг үзэл баримтлалттай болох нь харагдаж байна.

Гэсэн хэдий боловч үндэсний хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлан үзвэл хохирогчийн талаарх тодорхойлолт эрх зүйн баримт бичгүүдэд ялгаатай байдлаар туссан нь хохирогчийг тодорхойлсон хуулийн заалт хооронд агуулгын зөрүү байгааг илтгэж байв. Улмаар уг нөхцөл байдал нь хохирогч хуулийн байгууллагаар албан ёсоор хохирогчоор тогтоогдсон эсэхээс хамааран зарим тохиолдолд тусламж дэмжлэг авч чадахгүй байхад хүргэж байна.

*Хүснэгт 1. Хохирогчийн талаар хуульд заасан тодорхойлолтуудын харьцуулалт*⁷³

⁶⁹ Хүүхдийн эрхийн тухай Конвенц. НҮБ-ын ЕА. 1989. 1 зүйл. 1990 онд Монгол Улс соёрхон баталсан.

⁷⁰ Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдүүдийн асуудалтай холбогдох шүүхийн эрх зүйн үйл ажиллагааны журам. НҮБ E/CN. 15/2005/L.2/Rev.1

⁷¹ Гэмт хэргийн хохирогч, гэрч болсон хүүхдэд холбогдох байцаан шийтгэх ажиллагааны тухай загвар хууль болон түүнд холбогдох тайлбар. I бүлэг. (а) хэсэг. НҮБ-ын Хар тамхи, гэмт хэрэгтэй тэмцэх алба. НҮБ-ын Хүүхдийн сан. Олон улсын хүүхдийн эрхийн товчоо.

⁷² Цэвэл Я. Монгол хэлний товч тайлбар толь. 1966. 699 дэх тал

№	Хууль	Тодорхойлолт
1	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль ⁷⁴	3.1.2. Хохирогч гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хэлнэ.
2	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль ⁷⁵	4.1.1. “Гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгоно.
3	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль ⁷⁶	8.1. Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.

Эдгээр тодорхойлолтуудыг харьцуулан авч үзвэл аливаа гэмт хэргийн хохирогч гэж үзэх хамгийн гол зохицуулалт болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан хохирол хүлээсэн хүнийг гэмт хэргийн хохирогч гэж тооцоход шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тогтоол, захирамжийг заавал гаргахаар зохицуулжээ.

Гэтэл хүн худалдаалах асуудалтай тэмцэх чиглэлийн гол хууль болох Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хохирогч гэж тооцож тэдний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, шаардлагатай туслалцааг үзүүлэх асуудлыг мөн хуулиар зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл хохирогч төвтэй үйл ажиллагааг зохицуулсан хохирогчдод ээлтэй зохицуулалт болсон гэж үзэж байгаа юм.

Мөн хохирогч хамгааллын үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай хохирогчид үзүүлэх Хууль зүйн туслалцааны тухай, Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал батлагдаагүй байгааг анхаарах хэрэгтэй байна.

Хууль, эрх зүйн бусад баримт бичгүүдэд судалгаа хийж үзэхэд энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг илрүүлэхтэй холбоотой тусгайлсан эрх зүйн зохицуулалт байхгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 30.2 дугаар зүйлд гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах шалгах ажиллагааны талаар дараах зохицуулалттай байна.

Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн хохирогчийг илрүүлж буй байдал.

⁷³ Зөрчил шалгаж шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2017, №24. 3.2. “Хохирогч” гэж зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл сэтгүүл, УБ., 2017, №05, 5.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.

⁷⁴ Төрийн мэдээлэл. 2012. №7. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль

⁷⁵ Төрийн мэдээлэл. 2013. №30. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль

⁷⁶ Төрийн мэдээлэл. 2017. №23. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Зураг 1. Гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах ажиллагааны зураглал



Мөрдөгч, прокуророос хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гэмт хэргийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн; гэмт хэргийн шинжийг өөрөө шууд илрүүлсэн; гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийгөө илчилж ирсэн үндэслэлээр гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагааг явуулна.

Хүснэгт 2. Цагдаа, прокурор, шүүхийн байгууллага ХХГХ-ийн хохирогчийг тогтоохдоо баримталж буй эрх зүйн зохицуулалт

1. Цагдаагийн байгууллага:

№	Хууль	Дүрэм, журам
1	Эрүүгийн хууль	Гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгах, түүнд прокурор хяналт тавих харьяаллыг шинэчлэн тогтоох тухай А/33 дугаар тушаал
2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	
3	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	
4	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	

Прокурорын байгууллага:

№	Хууль	Дүрэм, журам
1	Эрүүгийн хууль	Байхгүй

2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	
3	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	
4	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль	

3. Шүүх эрх мэдлийн байгууллага:

№	Хууль	Дүрэм, журам
1	Эрүүгийн хууль	Байхгүй
2	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль	
3	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч тогтоох аргачлалд дүн шинжилгээ хийхэд мэдээлэл цуглуулах зорилгоор хохирогч хүүхдийг тогтоох, тэдний эрхийг хамгаалах үүрэг бүхий зарим /цагдаа, прокурор, шүүх/ байгууллагын алба хаагчидтай бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагыг хийн тодорхой хэмжээнд судалж үзлээ.

Дүгнэлт: Монгол Улс 2002 оноос эхлэн эрх зүйн орчноо боловсронгуй болгох чиглэлээр тасралтгүй ажилласаар иржээ. НҮБ-ын Палермогийн протоколд нэгдэн орж, соёрхон баталснаар өөрийн орны хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэн, хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хуулийг батлан гаргаж, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийг байгуулан үйл ажиллагаа нь тогтмолжсон байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэхээр төрийн захиргааны төв байгууллагуудаас нийт 7 журмыг хэрэгжүүлэхээр байгаа боловч цагдаа, прокурор, шүүхийн байгууллагын хүрээнд шаардлагатай байгаа 2 журам болох “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам” батлагдаагүй байна.

Төрийн болон төрийн бус байгууллагын аль алинд нь хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамж байхгүй, байгууллага тус бүр өөр өөрийн бичиг баримтын хүрээнд хохирогчийг тогтоож байна. ХХГХ-н хохирогчийг таньж мэдэх, ирүүлэх, тогтоох нэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжийг боловсруулах, батлуулах хэрэгцээ бий болжээ.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. үүнд:

Нэг. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамжийг нэн яаралтай боловсруулах;

Хоёр. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг илрүүлэх, тогтоохтой холбоотой сургалтыг энэ чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, алба хаагч нарт жил бүр явуулах

Гурав. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид шаардлагатай байгаа “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”-ыг нэн яаралтай батлуулах

**МӨНГӨН УСНЫ ХОР ХӨНӨӨЛ,
ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**
Damage of mercury (hg) related legal regulations

Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн нэгдүгээр тасгийн дарга, цагдаагийн хошууч, докторант Я.Билэгдэмбэрэл

Chairman of the first compartment of criminal department of the ecological police service Ya.Bilegdemberel (police major, doctoral student)

Товч утга: Химийн хорт, аюултай бодис, мөнгөн ус илэрсэн үед хэргийн газрын үзлэгт оролцогчид, тухайн орчинд байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах, хураан авсан химийн бодисыг аюулгүй тээвэрлэх, түр хугацаанд хадгалж байгаа байдлыг судлан үзсэн болно.

Briefing: When toxic, safe chemicals and mercury are found the participants of an inspection of a crime scene shall ensure the safety of the citizens in the area and should transport confiscated chemicals safely. The safe transport of chemicals was investigated.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, аюултай бодис, байгаль орчин, химийн хорт бодис, хортой нөлөөлөл.

Keywords: Safety, hazardous Substances, environment, toxic chemicals, harmful impacts.

Шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж буй өнөө үед химийн хорт, аюултай бодисын нэр төрөл, хэрэгцээ шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэхийн хэрээр байгаль орчин бохирдох, хүний эрүүл мэндэд хор, хөнөөл учруулах тохиолдол харьцангуй ихээр гарах болсон. Химийн хорт бодист арьс үрэвсүүлэгч, нүдийг хүчтэй гэмтээгч ба цочроогч бодис, амьсгалын зам болон арьс цочроогч бодис, үр удамд нөлөөлөгч бодис, хавдар үүсгэгч бодис, нөхөн үржихүйд хортой бодис, нэг удаагийн нөлөөллөөр тодорхой эрхтэн системийг хордуулагч бодис, олон удаагийн давтамжит нөлөөллөөр тодохой эрхтэн системийг хордуулдаг бодис, амьсгалахад, усан орчинд болон озоны давхаргад хортой бодисууд хамаардаг бол химийн аюултай бодист тэсрэмтгий, шатамхай, аэрозол, исэлдүүлэгч хий, даралтат савласан хий зэрэг бодисууд багтдаг.⁷⁷

Химийн хорт, аюултай бодисын орчиндоо үзүүлэх нөлөөлөл харьцангуй их, хамрах цар хүрээ өргөн, учрах эрсдлийн хэмжээг урьдчилан тооцоолох боломжгүй байдлаас гадна байгаль орчин, хүний эрүүл мэндэд ямар их хор хөнөөл учруулдаг болох нь тодорхой байна.

Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, тэр дундаа химийн хорт, аюултай бодисыг эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ойлголт, бүрэлдэхүүний шинж талаас нь академич С.Нарангэрэл⁷⁸, доктор (Sc.D) С.Жанцан⁷⁹, Ж.Болбаатар⁸⁰, доктор (Ph.D),

⁷⁷ Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/356/396 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт.

⁷⁸ С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. УБ. 1998.

⁷⁹ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал) УБ. 2004., Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги) УБ. 2003.

⁸⁰ Ж.Болбаатар. Эрүүгийн эрх зүй. (ерөнхий ба тусгай анги). УБ. 2016.

Н.Баатаржав⁸¹, Т.Сэнгэдорж⁸², С.Гантулга, Б.Энхболд⁸³, судлаач Э.Хулан⁸⁴, Ц.Ариунцэцэг⁸⁵, А.Мяасүрэн⁸⁶, химийн хорт, аюултай бодисын талаас нь химийн шинжлэх ухааны доктор (Sc.D), Б.Жаргалсайхан⁸⁷, доктор (Ph.D), П.Чимэдцэрэн⁸⁸ нар олон тооны бүтээл туурвиж, эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан боловч химийн хорт, аюултай бодис, тодруулбал, мөнгөн ус илэрсэн үед хэргийн газрын үзлэгт оролцогчид, тухайн орчинд байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар тусгайлан судалсан бүтээл хараахан гараагүй байна.

Бусад төрлийн химийн хорт, аюултай бодисуудтай харьцуулахад мөнгөн усыг уул уурхайн олборлолт хийхэд өргөн ашигладаг учир иргэдийн хэрэглээнд ихээр нэвтэрч, танигдсан бодис гэж хэлэхэд болно. Мөнгөн ус /Hg/ гэсэн тэмдэглэгээтэй энэ бодис химийн үелэх системийн 80 дахь элемент. Хүний эрүүл мэнд, амь насанд маш аюултай. Анх алт угаах зориулалтаар 1550 онд Африкт ашиглаж эхэлсэн байна.

Мөнгөн ус нь тасалгааны температурт шингэн байдаг цорын ганц металл бөгөөд металлтай нэгдэж амальгам үүсгэдэг ба энэ шинж чанарыг ашиглан, уул уурхайн салбарт хүдрээс металлыг ялгаж авахад хэрэглэдэг. Мөнгөн усны уур нь маш хортой бөгөөд амьсгалын замын эрхтнүүдийг гэмтээдэг байна. Хүний биед орсон тохиолдолд амьсгал давчдуулж, амьсгалахад хүнд болох, толгой өвдөх, булчин татах, цуллаг эрхтнүүд, тэр тусмаа элгэнд хуримтлагдаж гэмтээх, хорт хавдар үүсгэх зэрэг аюултай байдгийг анагаахын шинжлэх ухаан тогтоожээ. Мөн арьс, салстад хүрсэн тохиолдолд түлж, шархлуулах, арьсаар нэвчиж хүний биед орох аюултай.

Мөнгөн ус нь байгаль дээр:

- Металл буюу элемент;
- Органик бус;
- Органик гэсэн 3 хэлбэрт оршдог.

Японы Кюшү арлын Минамата хотод үйл ажиллагаа явуулдаг “Чисо” групп химийн үйлдвэр хог хаягдлаа далай руу хаядаг байснаас тэнд амьдарч, далайгаас хоол хүнсээ залгуулдаг байсан олон мянган япон иргэн 1956 онд мөнгөн усанд хордож амь насаа алдсан харамсалтай түүх бий. Минамата гэж нэрлэгдсэн уг өвчин нь метилийн мөнгөн уснаас үүдэлтэй, төв мэдрэлийн системийг эмгэгшүүлж, генийг гэмтээн удамшдаг хорт, аюулт өвчин юм. Мөнгөн усны хордлого авсан эхчүүдээс төрөлхийн ургийн гажигтай хүүхдүүд төрж, уг хор хохирол хэдэн арван жил үргэлжилж, өдгөө ч Японы Засгийн газраас нөхөн олговор олгосоор байна.

⁸¹ Н.Баатаржав нар. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги. УБ. 2012.

⁸² Т.Сэнгэдорж. Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал, уламжлал шинэчлэл. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 1994

⁸³ С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги (Сурах бичиг). УБ. 2018., С.Гантулга. Хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаа. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2015.

⁸⁴ Э.Хулан. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. Дотоод хэргийн их сургууль. 2020.

⁸⁵ Ц.Ариунцэцэг. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2006.

⁸⁶ А.Мяасүрэн. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, тогтоомж зөрчих гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологи шинж. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2013.

⁸⁷ Б.Жаргалсайхан. Химийн бодисын найрлага. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2009

⁸⁸ П.Чимэдцэрэн. Химийн хорт бодисоос үүсэх эрсдэл, түүнийг бууруулах арга зам. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2018.

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс 2016-2018 онд төрөхийн өмнөх үеийн мөнгөн усны өртөлтийг тодорхойлох судалгааг Сэлэнгэ аймгийн Сүхбаатар, Мандал сумдын 2016 оны 7-11 сарын хооронд төрсөн нийт 265 эхэд хийжээ. Судалгаагаар эхчүүдийн биологийн дээж дэх мөнгөн усны агууламж бага гарсан байна. Гэхдээ дөрвөн эхийн шээсэнд, нэг эхийн хүйн цусанд мөнгөн усны агууламж Германы хүний биомониторонгийн зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр гарсан байна.⁸⁹

Тус төвөөс 2014 онд мөнгөн усгүй технологи ашигладаг бичил уурхай эрхлэгчдийн дунд мөнгөн усны нөлөөллийн судалгаа хийжээ. Судалгаанд мөнгөн усгүй технологи ашигладаг баяжуулах цех, нөхөрлөлийн зохион байгуулалтад орсон 33 бичил уурхай, нөхөрлөлийн 147 бичил уурхай эрхлэгчдийг хамруулахад 7 хүн мөнгөн усны архаг хордлоготой болох нь тогтоогджээ.

Судалгааны явцын турш оролцогчдын цус болон шээсэнд хийсэн шинжилгээгээр 20-30 хувьд нь мөнгөн усны агууламж өндөр гарсан байна. Тэгэхээр, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компани, хайгуул, олборлолт явуулдаг аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хууль бус үйл ажиллагааны үр дүнд мөнгөн усанд хордох явдал иргэдийн дунд цөөнгүй гарч байгаа болох нь батлагдаж байна. Тиймээс мөнгөн усны ашиглалт, хадгалалт, хамгаалалтай холбоотой эрх зүйн зохицуулалтын боловсронгуй болгох шаардлагын хүрээнд, энэ төрлийн химийн хорт бодисын талаарх Монгол Улсын хэмжээнд хэрэглэгдэж буй эрх зүйн зохицуулалтын талаар авч үзэх хэрэгтэй юм.

Хэдийгээр Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж заасан боловч, уг заалт нь сүүлийн жилүүдэд үйлдвэржилт, уул уурхайн олборлолт, хүн амын төвлөрөл зэрэгтэй холбоотойгоор зөрчигдөх тохиолдол гарах болсон. Монгол Улсад 1961 онд Шинжлэх ухааны Академи байгуулагдаж, байгаль шинжлэлийн хүрээлэнгүүдэд химийн хорт, аюултай бодисыг бага хэмжээгээр хэрэглэж эхэлсэн.

1970 оноос эхлэн газар тариалангийн салбарт ургацын гарцыг нэмэгдүүлэх, болцыг түргэсгэхэд, 1990 оноос эхлэн зах зээлийн харилцаанд шилжиж, байгалийн нөөц баялаг, ашигт малтмалыг олборлоход химийн бодисыг ашиглаж эхэлсэн байдаг.⁹⁰ Гэвч химийн хорт, аюултай бодисын хэрэглээ нэмэгдэхийн хэрээр, тэдгээрийн хууль бус хэрэглээ өсөж, хяналтгүй байдал үүсэх эрсдэл өссөөр байна.

2006 онд баталсан “Химийн хорт, аюултай бодисын тухай” хуульд, химийн бодисыг хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь хортой ба аюултай гэж ангилахаар заасан. “Химийн хорт бодис” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг, “Химийн аюултай бодис” гэж тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг, “Хориглосон химийн бодис” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэглэхийг хориглосон химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг, “Хязгаарласан химийн бодис” гэж зөвхөн зөвшөөрсөн газарт, заасан зориулалт, хэмжээ, технологийн дагуу тодорхой хяналтын дор хэрэглэхийг зөвшөөрсөн химийн

⁸⁹ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Орчны эрүүл ахуй, хор судлалын лабораторийн химич Д.Баатарцолтой хийсэн ярилцлага. News.mn сайт.

⁹⁰ Э.Хулан. Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. УБ. 2020 он. 1 дэх тал.

хорт ба аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг, “Химийн хорт болон аюултай бодисын хаягдал” гэж олон улсын гэрээгээр ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодис, түүнчлэн хадгалах, ашиглах хугацаа дууссан буюу чанарын шаардлага хангахгүй болсон, тэрчлэн нэр томъёо, ашиглах хугацаа тодорхойгүй химийн хорт ба аюултай бодис, тэдгээрийн үлдэгдэл болон сав, баглаа боодлыг хэлнэ⁹¹ гэж тодорхой заажээ. Эдгээр тодорхойлолтод багтах, хор аюулын хэмжээ өндөртэй бодисуудын тоонд мөнгөн ус орох бөгөөд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүний эрүүл мэндэд хор уршиг үзүүлдэг химийн бодисын эхний 10-т мөнгөн усыг багтаасан явдал нь тохиолдлын зүйл биш юм.

Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор мөнгөн усыг хэрэглэхийг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад оруулж, Байгаль орчны сайдын 2008 оны 135 дугаар тушаалаар уул уурхайн үйлдвэрлэлд мөнгөн ус ашиглахыг хориглосон. Мөн “Мөнгөн усны тухай Минаматагийн конвенц”-ийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр баталсан бөгөөд, уг Конвенцид дэлхийн 92 улс орон нэгдэн орсон бол Монгол Улс 2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр нэгдэн орж, конвенцид заасан үүргээ хэрэгжүүлж байна.

Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, байгаль хамгаалах болон химийн хорт, аюултай бодисыг үйлдвэрлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, ашиглах журамд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм.⁹² Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн 24.3 дугаар зүйлд “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах” гэмт хэргийг хуульчилж, энэ төрлийн үйлдэл хийсэн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахаар заасан. Энэ зүйлийн 1 дүгээр хэсэгт “Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан” гэсэн 9 төрлийн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон.

Энэ зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт:

- хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон;
- их хэмжээний хохирол учирсан;
- хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэсэн 3 төрлийн хүндрүүлэх нөхцөлийг тус тус заасан.

Мөнгөн ус бол байгальд байдаг шингэн төлөвт, хүнд элемент. Харин хүний үйл ажиллагааны улмаас хүний амьдрах орчинд дэгдэж, биед орвол буцаж хэзээ ч гардаггүй учраас эрүүл мэндэд заналхийлдэг. Дээр дурдсанчлан мөнгөн усны хордлогод орох нэг эрсдэлт нөхцөл нь Монгол Улсын нутаг дэвсгэрт бичил уурхай эрхлэгчид юм. Хэдийгээр мөнгөн усыг хил, гаалиар нэвтрүүлэхийг хориглож, хязгаарласан боловч, ямар нэгэн байдлаар ашигласаар байгаа нь анхаарал татаж байна.

Мөнгөн усыг хэрэглэж байгаа газруудын байршлыг тодорхойлох зорилгоор Экологийн цагдаагийн албаны Эрүүгийн цагдаагийн хэлтсийн 20 албан хаагчдын дунд судалгаа явуулахад:

⁹¹ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail/526>.

⁹² С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй. Тусгай анги (Сурах бичиг). УБ. 2018. 438 дахь тал

- Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороонд байрлах “Урт цагаан” худалдааны гудамжинд “Алт авна, хайлна” гэсэн зар байрлуулсан газарт алтыг өндөр температурт хайлуулж, мөнгөн усыг ууршуулдаг тухай,

- Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах “Нарантуул” олон улсын худалдааны төвийн хойд хаалганы орчимд мөнгөн усыг жижиг шилэнд хийн, зарж борлуулдаг тухай,

- Сэлэнгэ, Төв, Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг алтны тээрмүүд шорооноос алт ялган авахдаа мөнгөн усыг ашигладаг тухай, эдгээр газруудад мөнгөн усыг хууль бусаар ашиглаж байж болзошгүй талаар мэдээлэл өгсөн юм. Мөн урьд өмнө мөнгөн ус ашиглаж байгаа хөрсөнд нь нэвтрэн үлдсэн байж болзошгүй газруудыг тогтоох зорилгоор Экологийн цагдаагийн албаны нутаг дэвсгэр хариуцсан албан хаагчдын мэдэгдсэнээр:

- 2020 оны 9 дүгээр сард Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Цагдаагийн газартай хамтран, хариуцсан нутаг дэвсгэрт мөнгөн усны хууль бус хэрэглээ байгаа эсэхийг тогтоох зорилгоор шалгалт явуулж, Манлай суманд хуучин тээрэм ажиллаж байсан газрын хөрс, уснаас дээж авч, Байгаль орчны тогтвортой хөгжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг “Эко трейд” компанийн итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийхэд, хөрснөөс мөнгөн ус илэрч байжээ.

- Сэлэнгэ аймгийн Баянгол сумын “Нарангийн гол” гэх газарт 2000-2003 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд 5 газарт, 2008 онд “Капитал ресурс” ХХК, 2010-2011 онд “Жамп алт” ХХК тус тус тээрэм ажиллуулж, мөнгөн ус ашиглан алтны олборлолт явуулж хөрсийг бохирдуулж байжээ. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газартай хамтран 2008 онд хэрэгжүүлсэн төслийн хүрээнд “Нарангийн гол” гэх газраас мөнгөн усаар бохирлогдсон шороог зөөж, “Бортолгой” гэх газарт булж, хорыг саармагжуулах арга хэмжээ авч байжээ. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас 2020 оны 5 дугаар сард уг байршил бүхий газрын 5 цэгээс дээж авч шинжилгээ хийж үзэхэд, мөнгөн усны хэмжээ их гарсан байна. Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгийн нутаг дэвсгэрт ашиглаж байсан мөнгөн ус нь хөрс, усанд нэвтрэн үлдсэн байна. Харин Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Урт цагаан” худалдааны гудамж, Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр “Нарантуул” олон улсын худалдааны төвийн алт худалдан авдаг ченжүүд, Дорноговь, Төв, Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт байрлах тээрэм ажиллуулдаг иргэд мөнгөн ус хэрэглэдэг байж болзошгүй гэж үзэхээр байна.

Тэгэхээр, мөнгөн усны хүн ам, байгаль орчинд үзүүлэх хор хөнөөл үлэмж их атал, уг бодисын хууль бус ашиглалтад хяналт тавьж, цаашдын тархацыг зогсоон, хүн амын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалахад чиглэсэн төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байгаа болохыг анхаарч, химийн хорт, аюултай бодистой харьцах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна.

Дүгнэлт

Химийн хорт, аюултай бодис нь байгаль орчин, хүний биед үзүүлэх хортой нөлөөллийн хэмжээ маш ихтэй, байгалийн тэнцвэрт байдлыг алдагдуулах хэмжээний хор хөнөөлтэй учир, энэ төрлийн бодис илэрсэн газарт хийх үзлэгийн үед эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлагатай байна. Химийн хорт бодис, тэр дундаа мөнгөн ус нь олон улсын

жишигт нийцсэн, агаарт тархалтаас бүрэн хамгаалсан, зориулалтын саванд хийгээгүй тохиолдолд, орчиндоо шууд тархаж, хүний эрхтэн систем, амьсгалын замыг аажмаар хордуулдаг, аажмаар үхэлд хүргэх эрсдэлтэй бодис юм.

Монгол Улсын Эрүүгийн хууль болон бусад хуулиар химийн хорт, аюултай бодисын хэрэглээг хязгаарласан боловч, хууль бусаар мөнгөн ус ашиглах, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд ноцтой хохирол учруулах явдал буурахгүй байгаагаас гадна, мөнгөн усыг хууль бусаар ашиглах үйлдэлд тавих хяналт сул байна. Мөн химийн хорт, аюултай бодисын хууль бус эргэлт, ашиглалтыг хянах чиглэл бүхий төрийн албан байгууллагуудын харилцан уялдаа, хамтын ажиллагаа сайнгүй байгаа явдал нь химийн хорт, аюултай бодис, тэр дундаа мөнгөн усны хууль бус эргэлтийг таслан зогсоох ажиллагааг үр дүнтэй явуулахад хүндрэл учруулж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. А.Мяасүрэн. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, тогтоомж зөрчих гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологи шинж. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2013.
2. Б.Жаргалсайхан. Химийн бодисын найрлага. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2009.
3. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн А/356/396 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт.
4. Ж.Болдбаатар. Эрүүгийн эрх зүй. (ерөнхий ба тусгай анги). УБ. 2016.
5. Н.Баатаржав нар. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн тусгай анги. УБ. 2012.
6. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Орчны эрүүл ахуй, хор судлалын лабораторийн химич Д.Баатарцолтой хийсэн ярилцлага. News.mn сайт.
7. П.Чимэдцэрэн. Химийн хорт бодисоос үүсэх эрсдэл, түүнийг бууруулах арга зам. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2018.
8. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй: тусгай анги (Сурах бичиг). УБ. 2018.
9. С.Гантулга. Хүн худалдаалах гэмт хэргийг эрүүгийн тагнуулын ажлаар урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаа. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 2015.
10. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал) УБ. 2004., Монгол Улсын Эрүүгийн эрх зүй (тусгай анги) УБ. 2003.
11. С.Нарангэрэл. Монгол Улсын Эрүүгийн эрх зүй. Тусгай анги. УБ. 1998.
12. Т.Сэнгэдорж. Байгаль орчныг хамгаалах эрх зүйн асуудал, уламжлал шинэчлэл. Докторын зэрэг горилсон бүтээл. УБ. 1994.
13. Ц.Ариунцэцэг. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэргийн эрүүгийн эрх зүй, криминологийн зарим асуудал. Магистрын зэрэг горилсон бүтээл. УБ. 2006.
14. Э.Хулан. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. Хууль зүйн магистрын зэрэг горилсон бүтээл. Дотоод хэргийн их сургууль. 2020.
15. Э.Хулан. Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж. УБ. 2020.
16. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. <https://legalinfo.mn/mn/detail/526>.

ТӨМӨР ЗАМЫН ӨРТӨӨ, ЗӨРЛӨГҮҮДЭД ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА ХЭВ ЖУРАМ САХИУЛАХ ЗАРИМ АРГА ЗАМ

Б.Бямбасүрэн

*ТЗЦГ-ын чиглэлийн ахлах ажилтан,
магистрант, цагдаагийн хошууч*

Товчлол: Төмөр зам дахь Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үндсэн чиг үүрэгтэйгээс гадна улсын хэмжээний төмөр замын хэвийн үйл ажиллагааг хамгаалах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааг явуулж байна.

Энэхүү өгүүлэлд төмөр замаар ачаа тээвэр, зорчигч тээвэрлэх үйл ажиллагаа эрчимжсэн нь төмөр замын өртөө, зөрлөгүүдэд нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны өнөөгийн байдал, тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар товч авч үзсэн болно.

Түлхүүр үг: төмөр зам, нийтийн хэв журам хамгаалах

Keywords: railway, public order

Удиртгал. Манай эх орны төмөр замын түүхийн хуудас 1938 оноос эхлэх бөгөөд анх Улаанбаатар-Налайх чиглэлд нарийн төмөр зам тавигдаж, уурын галт тэргээр нүүрс тээвэрлэж эхэлсэн нь өдгөө 1520 мм өргөн цариг бүхий төмөр замтай, гол замын урт урд хилээс хойд хил хүртэл 1111км, дэлгэмэл уртаараа 1815км Ази, Европыг холбосон төмөр замын хамгийн дөт гүүр болж, Монгол Улсын импорт, экспортын ачаа тээврийн 70 гаруй хувийг дангаараа гүйцэтгэдэг ложистикийн чухал ач холбогдолтой салбар болтлоо хөгжсөн байна.

Монгол Улс 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр улс оронд хэрэгжиж байсан цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах бүх журмыг цуцалж, агаарын болон төмөр замын хилээ нээсэн нь зорчигч, ачаа тээврийн хөдөлгөөн эрс нэмэгдэж эхэлсэн төдийгүй үүнийг дагаад төмөр замын харьяалах нутаг дэвсгэрт гарах зөрчил өсөх хандлагатай байгаа нь төрөл бүрийн судалгаа, тоон мэдээллээр нотлогдож байхад тухайн нутаг дэвсгэрт нийтийн хэв журам сахиулах асуудлыг судалж, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, тулгамдаж буй асуудлыг судалж, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэрийлэх нь тулгамдсан асуудал болж байна.

Төмөр замын дагуу харьяалах нутаг дэвсгэрт нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаатай холбоотой эрдэмтэн, судлаачдын бүтээлүүдийг судлан үзэхэд түүхийн талаас нь “Төмөр зам дахь Цагдаагийн хэлтсийн түүхэн товчоо” 2016 он, “Монгол Улсын Цагдаагийн байгууллагын түүх” 1,2,3 боть 2021 он зэрэг бүтээлүүдэд төмөр замын хариуцсан нутаг дэвсгэрт үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, галт тэрэгний хөдөлгөөн болон иргэдийн аюулгүй байдлыг хэрхэн хангаж ирсэн талаар дурдагдсан байна. Харин төмөр замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал болон техник ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж талаас Академич С.Нарангэрэл, гавъяат хуульч, доктор /Sc.D/, профессор Г.Совд, С.Жанцан, Б.Содовсүрэн, доктор /Ph.D/, профессор Г.Гантөмөр нарын эрүүгийн эрх зүйн сурах бичгүүд, эрүүгийн хуулийн онолын тайлбар, судалгаа, эрдэм шинжилгээний дагнасан бүтээл байдаг бол эрүүгийн

процесс, аргазүйн талаас нь доктор /Sc.D/, профессор Ж.Болдбаатар, доктор /Ph.D/, профессор Б.Бат-Эрдэнэ, Ж.Бямбаа, Д.Зүмбрэлхам, Ж.Хурцгэрэл, Б.Болдбаатар, Т.Оюунчимэг, Б.Батзориг нарын бүтээл, эрдэм шинжилгээний нийтлэл, гарын авлагуудад тодорхой саналыг дэвшүүлэн тавьсан байдаг боловч, төмөр замын дагуу өртөө, зөрлөгүүдэд нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагаа, тулгамдаж буй асуудал талаас дагнасан бүтээл одоогоор байхгүй байна.

1. Нийтийн хэв журам хамгаалах үйл ажиллагааны ойлголт

Нийгмийн дэг журам, хууль сахиулах явдал бол хүмүүс хоорондын харилцааг зохицуулах асуудал бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд нийгмийн нийтлэг эрх ашгийг хамгаалсан эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан өөрийн улс орны үндэстний ахуй соёл, зан заншлын онцлогийг харгалзан түүхийн хөгжлийн бүхий л явцад төрийн бүтцийн салшгүй нэг хэсэг болж, тэр дундаа хүн ам төвлөрөн суурьшсан тэр хэрээр нийгмийн олон талт харилцаа идэвхтэй өрнөсөн хот суурин газруудад нэн шаардлагатай болсонтой шууд холбогдоно. Үүний нэг болох төв суурин газрын төмөр зам, түүнд харьяалагдах нутаг дэвсгэр, өртөө, зөрлөгүүдэд нийгмийн хэв журам сахиулах нь хүн, ачаа тээврийн урсгал хөдөлгөөнд учрах саадыг арилгахад чухал үр дүн өгсөн. Цагдаагийн албаны тухай хуулиас харахад цагдаагийн байгууллага нь нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэгтэй байгууллага юм.

1993 оны Цагдаагийн байгууллагын тухай хуулиар тодорхойлж байсан “нийгмийн хэв журам” 2017 оны Цагдаагийн албаны тухай хуулиар тодорхойлсон “нийтийн хэв журам”⁹³ нь хоорондоо ялгаатай, эсвэл харилцан хамааралтай эсэхийг салгаж ойлгох нь чухал юм.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ж.Долгорсүрэн 2004 оны “Монгол улсын цагдаагийн эрх зүй” номондоо нийгмийн хэв журам, нийтийн аюулгүй байдал⁹⁴ гэсэн тодорхойлолтыг өгсөн нь 2017 онд батлагдсан “Цагдаагийн албаны тухай хууль”-ийн 11-р зүйлд заасан “нийтийн хэв журам хамгаалах”, 12-р зүйлд “Олон нийтийн аюулгүй байдлыг хангах” гэсэн чиг үүргүүдтэй дүйцүүлэн ойлгож болохоор байна.

Нийгмийн хэв журам гэдэг ойлголтыг өргөн болон явцуу гэсэн хоёр утгаар тодорхойлоход явцуу утгаар нь авч үзвэл олон нийтийн хэв журмыг зөвхөн олон нийтийн газар хүмүүсийн хоорондоо харилцах явцад бүрэлдэн тогтсон нийгмийн харилцааны нэг хэсэг тогтолцоо гэж авч үзжээ. Нийгмийн хэв журам нь хүний ухамсарт амьдралын үр дүн болох өргөн хүрээтэй ойлголт юм. Нийгмийн хэв журам нь нийгэм, төрийн тогтолцоонд баталгаажин нийгмийн харилцааг социал хэм хэмжээгээр хэлбэржүүлэн бүрэлдүүлж тогтоосон нийгмийн учир шалтгаан үндэс бүхий социал эрх зүйн ухагдахуун юм гэж ойлгож болох юм.

Нийгмийн хэв журмын талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд “нийгмийн хэв журам гэж хүн амын аж төрөн амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх, ёс заншил, бүх нийтээр хүлээн зөвшөөрч хэвшсэн буюу хуулиар тогтоосон нийгмийн хэм хэмжээний нийлбэр цогц”⁹⁵ гэж нийгмийн харилцааны шинжээр нь тодорхойлжээ.

ОХУ-ын судлаач А.С.Прудникова “нийгмийн хэв журам сахиулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах нь гэмт хэрэг, зөрчилд хяналт тавих үйл ажиллагаагаар бүрэн шийдвэрлэгдэн,

⁹³ Төрийн мэдээлэл. 2017. №8. Цагдаагийн албаны тухай хууль

⁹⁴ Ж.Долгорсүрэн, Д.Булган Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн хүрээ УБ 2014 он

⁹⁵ Г.Совд Монгол Улсын Үндсэн Хуулийн нэр томъёо УБ 1993 он

гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажил болно”⁹⁶ гэж дүгнэсэн.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Долгорсүрэн, доктор Д.Булган нар “Нийгмийн хэв журам гэдэг нь өргөн утгаараа хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх бололцоог хангах нийтийн захиргаа төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилготой иргэний нийгмийн хэрэгцээг шаардлагатай нөхцөлдөн гарсан Монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил уламжлал, ёс суртахуун эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэллэг тогтолцоо мөн”⁹⁷ гэж тодорхойлсон.

Олон улсын хэллэгт public order буюу нийтийн хэв журмыг тайлбарлахдаа “нийтийн орон зай дахь иргэдийн тайван, эмх цэгцтэй зан байдал” буюу үндсэндээ эмх замбараагүй байдал байхгүй байхыг хэлнэ гэж тодорхойлжээ. Энэ нь хүмүүс мэдрэмжтэй, зохистой харьцаа, бусдад хүндэтгэлтэй хандах явдал юм.⁹⁸

Харин үүнийг зөрчсөн үйлдлийг гадаадын улс оронд янз янзаар буюу нийгмийн хэв журмын зөрчил, нийгмийн тогтсон хэм хэмжээний эсрэг үйлдэл, олон нийтийн эсрэг үйлдэл, нийгмийн ёс суртахууны эсрэг үйлдэл гэх зэргээр нэрлэдэг байна.⁹⁹

Ийнхүү улс оронд янз янзаар тайлбарлах боловч ерөнхийд нь авч үзвэл эрх зүй, ёс зүй, ёс суртахуун болон соёлын хэм хэмжээнд нийцэхгүй үйл явдал буюу тухайн нийгэмд, тухайн цаг үед тогтсон хэм хэмжээнээс гажууд аливаа үйлдлийг хэлнэ гэж тодорхойлж болох юм.

Цагдаагийн албаны тухай хуулийн 3-р зүйлд “нийтийн хэв журам хамгаалах” гэж гудамж, талбай, олон нийтийн бусад газарт хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг сахиулах үйл ажиллагааг, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын 500.3-т “нийгмийн амгалан тайван байдал, хүний халдашгүй, чөлөөтэй байх эрх, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж буй нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон аж төрөх ёсны хэм хэмжээг” ойлгоно гэж тус тус тодорхойлжээ.

Харин захиргааны эрх зүй, цагдаагийн эрх зүйн тэргүүлэх судлаачид “нийтийн хэв журам” нь “нийгмийн хэв журам”-ын нэгэн хэсэг буюу өөр хоорондоо харилцан хамаарал бүхий, түүнээс улбаалан гарах, цагдаагийн албаны тухай хуулиар хамгаалагдан зохицуулагдах харилцаа бөгөөд олон нийтийн хэв журам буюу дээр дурдсан явцуу утгатай дүйцүүлэн ойлгож болохоор байна гэж үзэж байна.

Нийтийн хэв журмын мөн чанарыг бүрэн илэрхийлэхийн тулд арга зүйн хувьд түүний дотоод бүтцийг тодруулан үзэх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл нийтийн хэв журмын агуулга, зорилго, зохицуулах хэрэгсэл, хэрэгжих баталгаа нь бүтцийн бүрэлдүүлбэр, мөн чанарын илэрхийлэл юм. Мөн “нийгмийн дэг журам”, “нийгмийн хэв журам”, “нийтийн хэв журам” гэсэн ойлголт өөр хоорондоо олон талаар ижил боловч түүний ялгааг бас анхааран үзэх нь чухал.¹⁰⁰

⁹⁶ Прудников А.С. Безопасность личности и ее соотношение с другими правовыми категориями // закон и право № 3. 1999.

⁹⁷ Ж.Долгорсүрэн, Д.Булган Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс УБ 2014 он 35-р хуудас

⁹⁸ <http://www.open.ac.uk/arts/history-from-police-archives/Met6Kt/publicOrder/polIntro.html>

⁹⁹ Олон улсын нэршил нь antisocial behaviour, антисоциальное поведение, anti-social behavior order, О защите общественной морали, anti-social behavior act 2003, <http://www.legislation.gov.uk/ukpga/2003/38/data.pdf>

¹⁰⁰ Ж.Долгорсүрэн . Монгол улсын цагдаагийн эрх зүй . УБ ,2004, 36-40 дэх хуудас

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд “...нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн” гэж заасан бол 38 дугаар зүйлд “... нийгмийн хэв журмыг бэхжүүлэх”¹⁰¹ нь Монгол улсын засгийн газрын нийтлэг чиг үүрэг, хэрэгжүүлэх бүрэн эрх болох талаар заажээ.

Эдгээрээс үзэхэд хэрэгжүүлэх субъект нь ялгаатай төдийгүй, нийгмийн дэг журам нь өргөн агуулгатай, харин нийтийн хэв журам нь түүний доторх бүрэлдэхүүн, тэгвэл нийтийн хэв журам нь нийгмийн хэв журмын төрөл, хэсэг мэт ойлгогдохоор ажиглагдана. Өөрөөр хэлбэл нийгмийн хэв журам нь нийтийн хэв журмаас өргөн хүрээтэй ойлголт юм.

Харин нийгмийн хэв журам нь зөвхөн эрх зүйн төдийгүй, зан заншил, уламжлалын болон ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулагддаг социал, эрх зүйн өргөн хүрээтэй ойлголт юм. Тиймээс эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаа, түүний төрөл хэсэг буюу явцуу утгаар илэрхийлэгдэх нийтийн хэв журам нь эрх зүйн дэг журмын хүрээг тэлж, тэдгээр нь хоорондоо ихээхэн хэмжээгээр давхцана.

Эрх зүйн дэг журам нь нийгмийн хэв журмын гол хэсгийг бүрэлдүүлж, эрх зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан нийтлэг бүхий л харилцаа хамаарах бөгөөд зөрчигдсөн тохиолдолд эрх зүйн албадлагаар хамгаалагддаг бол нийтийн хэв журам нь тодорхой нэг харилцааг цагдаагийн байгууллагаас хууль сахиулахаар тогтоосон байна.

Төмөр замын өртөө, зөрлөгүүдэд цагдаагийн байгууллагын хэв журам хамгаалах үйл ажиллагаа

Төмөр замын Цагдаагийн газар нь БНМАУ-ын Дотоод явдлын сайдын 1950 оны хоёрдугаар сарын 02-ны өдрийн 91 тоот тушаалаар “Төмөр замын цагдан сэргийлэх пункт, нэртэйгээр байгуулагдсан түүхтэй. Тухайн үеийн сэргийлэх байгууллагын багахан нэгж 70 жилийн хугацаанд олон улсын цагдаагийн байгууллагын жишигт хүрэхүйц “Цагдаагийн газар” болсон.

Төмөр зам дахь Цагдаагийн газар нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үндсэн чиг үүрэгтэйгээс гадна улсын хэмжээний төмөр замын хэвийн үйл ажиллагааг хамгаалах, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих, Монгол-Оросын хамтарсан нийгэмлэгийн өмч хөрөнгийг халдлагаас хамгаалах үүрэгтэй ажилладаг.

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг УБТЗ-ын дарга, Цагдаагийн Ерөнхий газрын дарга нар Цагдаагийн албаны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Монгол Улсын Иргэний хуулийн 476 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны есдүгээр сарын 26-ны өдрийн 281 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн харилцан тохиролцсоны үндсэн дээр “Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг”-ийг байгуулан ажиллаж байна.

Гэрээгээр Төмөр зам дахь цагдаагийн газар нь улсын хойд хилээс урд хил хүртэл төмөр зам дагуу 1115 км-т нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж, таслан зогсоох, илрүүлэх чиг үүрэгтэйгээр Улаанбаатар хотод болон 13 өртөө, зангилаанд алба хаагчид ажил үүрэг гүйцэтгэж байна.

Төмөр замын объект, төмөр замын гарам, төмөр замын аюултай бүс, төмөр замын аюулгүйн г.м. нэр томъёоны ойлголтыг 2007 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Төмөр замын тээврийн тухай” хуулинд тусгаж хуульчилсан ба төмөр замын зурвас газар, объект, өртөө, буудалд нийгмийн хэв журам сахиулах зохион байгуулахаар мөн адил тусгасан байна.

¹⁰¹ Төрийн мэдээлэл. 1992. №1. Монгол Улсын Үндсэн хууль

Схем №1.Төмөр замын харьяалах нутаг дэвсгэрт үйлдэгдсэн зөрчил



Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, төмөр замын харьяалах нутаг дэвсгэрт нийтийн хэв журмыг сахиулах зорилгоор Төмөр зам дахь цагдаагийн газраас 13 өртөөнд 56 цагдаагийн алба хаагч нийтийн хэв журам сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа боловч 2017 онд 18,167 зөрчил, 2018 онд 29,555, 2019 онд 37,477, 2020 онд 31,189 зөрчил бүртгэгдэж 26,8% өссөн статистик үзүүлэлттэй байна.

Дэлхий нийтэд тархсан ковид-19 вирусийн цар тахлын улмаас төмөр замын зорчигч, ачаа тээвэр эрс багасч 2021 онд 16,419 зөрчил бүтгэсэн нь өмнөх оны мөн үеэс 47,4% буурсан байна.

Төмөр зам дахь Цагдаагийн газар нь 2021 онд иргэн, хуулийн итгээд, албан тушаалтнаас 458 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 169 буюу 36.9% нь гэмт хэргийн шинжтэй, 289 буюу 63.1% нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна.

Сүүлийн 7 жилийн эхний 12 сарын дунджаар 79 гэмт хэрэг, сард 6-7 гэмт хэрэг бүртгэгдсэн.

Бүртгэгдсэн гэмт хэрэг газраар /өртөө, зангилаа/

№	Өртөө	2020.XII 53	2021.XII 49	Өсөлт, бууралт	
				Тоо	Хувь
1	Сүхбаатар өртөө	-	2	+2	2 дах
2	Дархан өртөө	2	4	+2	100
3	Салхит өртөө	-	-	-	-
4	Түнхэл өртөө	-	-	-	-
5	Эрдэнэт өртөө	-	-	-	-
6	Баруунхараа өртөө	-	-	-	-
7	Зүүнхараа өртөө	-	-	-	-
8	Мандал өртөө	4	3	-1	-25
9	Төв аймаг	5	3	-2	-40
10	Улаанбаатар хот	29	28	-1	-3.5
11	Чойр өртөө	1	2	+1	100
12	Олон-овоо өртөө	-	-	-	-
13	Айраг өртөө	2	-	-2	-2 дах
14	Сайншанд өртөө	6	1	-5	-83.3
15	Замын-Үүд өртөө	4	6	+2	+50

Мөн төмөр замын өртөө зөрлөгүүдэд ажиллаж байгаа камерын хяналтын талаар үүрэг гүйцэтгэж байгаа 22 алба хаагчаас судалгаа авахад дараах статистик харагдаж байна.



2022 оны эхний зургаан сард иргэн, хуулийн этгээд, албан тушаалтнаас 132 гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас 23 буюу 17.4 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 109 буюу 82.6 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байлаа. Нийт долоон гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 75 хувиар буурсан байна.

Гэмт хэргийн илрүүлэлт, шийдвэрлэлт 100 хувьтай байна. Дээрх статистикийг харахад төмөр замын өртөө зөрлөгүүдэд нийтийн хэв жухам хамгаалах үйл ажиллагаа хүн хүч, техник технологийн хувьд шинэчлэх зайлшгүй тулгамдсан асуудал болж байгаа нь тодорхой харагдаж байна. Иймд төмөр замын өртөө зөрлөгүүдэд нийтийн хэв жухам хамгаалах үйл ажиллагааг "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулах шаардлагтай гэж харж байна. Тухайлбал уг хөгжлийг бодлогод төмөр зөмөн талаар:

- Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, уул уурхайн бүтээгдэхүүн экспортлох нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Олон улсын болон бүсийн тээвэр логиستيкийн нэгдсэн сүлжээг үе шаттайгаар байгуулж, хөрш орнуудын сүлжээтэй холбогдсон байна.
- Нийслэл орон нутгийг холбосон төмөр зөмөн дэд бүтцийг хөгжүүлэхээр тус тус тусгасан байна.


Мөн уг хөтөлбөрт хууль сахиулах байгууллагын хөгжлийг дараах байдлаар тусгасан байна. Тухайлбал:

- Салбарын хөгжил, удирдлагын тогтолцоог бэхжүүлж, байгууллагуудын барилга, байгууламж, дэд бүтцийг системтэйгээр шинэчилнэ.
- Хууль сахиулах салбарын бүтээн байгуулалтыг дэмжиж иргэдэд үзүүлэх үйлчилгээний найдвартай, шуурхай байдлыг бэхжүүлэх үе.

Ийнхүү төмөр замын өртөө зөрлөгүүдэд нийтийн хэв жухам хамгаалах үйл ажиллагааны тулгамдсан асуудал, бодлогын баримт бичигт тусгагдсан байдал зэргээс үзэхэд техник технологийн эрс шинэчлэл хийх, алба хаагчийн орон тоог нэмэх шаардлага тулгарч байна.

Төмөр замын 12 өтрөө зөрлөгт 13 офицер, 13 цагдаагийн орон тоог нэмэх зүй ёсны шаардлага тавигдаж байна. Дараах схем зургаар одоо үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид болон нэмэгдэж хамгаалатад авах өртөө зөрлөгүүд, алба хаагчдын орон тооны байдлыг харуулав.

Схем№2



Дүгнэлт. Судалгааны ажлын хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна. Төмөр замын томоохон өртөө, зангилаадад байгаа хяналтын камерууд шаардлага хангахгүй, зарим өртөөдөд бүр байхгүй байгаа нь нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагаанд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийн нэг болжээ.

Түүнчлэн Зүүнбаян, Багахангай, Багануур гэх мэт томоохон өртөө, зангилаа, бусад зөрлөгүүдэд өнөөг хүртэл цагдаагийн алба хаагч байхгүй байгаа бөгөөд ажиллуулахад шаардлагатай төсөв санхүүг шийдээгүй байгаа нь тулгамдсан асуудлын нэг болжээ. Тиймээс Төмөр замын цагдаагийн газрын судалгаагаар гаргаж ирсэн 26 алба хаагчийн орон тоог яаралтай нэмэх шаардлагатай болсон байна.

Мөн Төмөр замын цагдаагийн газраас “Гармын мэдлэг дээшлүүлэх олон улсын өдөр”-ийг УБТЗ-тай хамтран жил бүр зохион байгуулж байгаа ч төмөр замын гармын аюулгүй байдал, аюултай бүсийн дэглэмийн ойлголтыг мэдээллийн бүх сувгаар хүргэж байх ажил учир дутагдалтай байна.

Төмөр замын цагдаагийн газар “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан шинээр баригдсан төмөр замын өртөө, зөрлөгүүдэд алба хаагчийн орон тоо, ажлын байр, техник, тусгай хэрэгслийн талаар судалгааг гаргаж төлөвлөх гэх мэт олон ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлага бий болжээ.

Санал. Дээрхи дүгнэлтийг үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. УБТЗ-ын захиргаатай хамтран төмөр замын томоохон өртөө, зангилаадад байгаа шаардлага хангахгүй хяналтын камеруудыг шинэчлэх, камер байхгүй байгаа зарим өртөөдөд шинээр суурилуулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

2. Төмөр замын цагдаагийн нэгж байхгүй Зүүнбаян, Багахангай, Багануур гэх мэт томоохон өртөө, зангилаа болон бусад зөрлөгүүдэд шаардлагатай орон тоог нэн даруй шийдвэрлэж, дээрхи өртөө зөрлөгүүдэд хэв журам сахиулах ажиллагааны хэвийн байдлыг хангах;

3. Замын ангиудтай хамтран төмөр зам дагуу нутагладаг мал бүхий айл айлуудтай “Төмөр замын аюултай бүсийн дэглэм”-ийн сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах;

4. Төмөр замын бүсэд малаа бэлчээхгүй байх, бэлчээсэн тохиолдолд хариуцлага тооцох холбогдох хуулийн заалтыг тайлбарлан мэдэгдэх хуудас өгч, гарч болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмолжуулах.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Монгол Улсын хууль

1. Монгол улсын Үндсэн хууль, 1992 он
2. Цагдаагийн албаны тухай хууль, 2017 он

Ном, сурах бичиг.

1. Ж.Долгорсүрэн, Д.Булган Монгол Улсын Цагдаагийн эрх зүйн курс УБ 2014 он
2. Г.Совд Монгол Улсын Үндсэн Хуулийн нэр томъёо УБ 1993 он
3. Ж.Долгорсүрэн . Монгол улсын цагдаагийн эрх зүй . УБ ,2004

Бусад эх сурвалж:

1. Төрийн мэдээлэл. 1992. №1.
2. Төрийн мэдээлэл. 2017. №8.
3. Закон и право № 3. 1999

Цахим эх сурвалж:

4. <http://www.open.ac.uk>
5. www.legislation.gov.uk/history-from-police-archives/Met6Kt/publicOrder/polintro.html

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНОЛ ПРАКТИКИЙН АСУУДАЛ

ЗАМ ТЭЭВРИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХЭД МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ АШИГЛАХ НЬ

/Улсын чанартай авто зам/

*ДХИС-ийн магистрант, цагдаагийн
ахлах дэслэгч Х.Мөнх-Эрдэнэ
Удирдсан багш доктор (Ph.D)
цагдаагийн хошууч Г.Болор-Эрдэнэ
haku_86400@gmail.com*

Товчлол. Сүүлийн 5 жилийн хугацаанд манай улсын авто замын тодорхой хэсэг газарт байнга буюу давтамжтай зам тээврийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг газрын судалгааг гаргаж гар утасны “GPS Navigation” аппликэйшнд мэдээллийг оруулж, зам тээврийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд “GPS Navigation” аппликэйшныг үйл ажиллагаандаа хэрхэн нэвтрүүлэх, ашиглах талаар авч үзлээ.

Түлхүүр үг. Зам тээврийн гэмт хэрэг, зөрчил, улсын чанартай авто зам, хар цэг, шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх ажил, гар утасны аппликэйшн GPS Navigation

Удиртгал. Улсын чанартай авто замуудад тодорхой хэсэг газарт байнга давтамжтай зам тээврийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг газрыг “Хар цэг” гэж албаны хүмүүс нэрлэж заншжээ. Эдгээр “Хар цэг”-т үйлдэгдэж буй зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тухайн аюултай хэсгийн GPS координатыг сүүлийн 5 жилийн судалгаагаар тогтоож, гар утасны GPS Navigation аппликэйшнд нарийвчлан суулгаж, жолооч нарт ашиглахад амар хялбараар хийж, гар утсанд үнэгүй суулгах нөхцөл боломжоор хангах ажлыг хийлгэх явдал юм.

Энэ аппликэйшныг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр улсын чанартай авто замаар орон нутгийн замд зорчиж буй шинэ туршлага муутай, авто замын мэдээлэл дутмаг жолооч нарт замын нөхцөл байдлын мэдээллийг гар утсаар нь дамжуулан өгөх арга замыг тодорхойлоход оршино.

НЭГ. ЗАМ ТЭЭВРИЙН ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Зам тээврийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, статистик тоо баримт

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 3.1.6 “Зам тээврийн осол” гэж зам дээр тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс үүдэн хүний амь нас, эрүүл мэнд хохирох, тээврийн хэрэгсэл болон зам, замын байгууламж эвдэрч гэмтэх, ачаа болон бусад эд хөрөнгийн хохирол учрахыг; гэж заасан байдаг. Зам тээврийн ослыг хохирлоор ангилаад зам тээврийн гэмт хэрэг, зам тээврийн зөрчил гэж ойлгож болох юм.

2020 онд Улсын хэмжээнд зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт 65650 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс Улаанбаатар хотод 61653 буюу нийтлэг дуудлага мэдээллийн 93.2%, орон нутгийн авто замуудад 3997 буюу нийт дуудлага мэдээллийн 6.8%

бүртгэгдсэн байна. Дээрх дуудлага мэдээллээс зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 21768 ослыг цагдаагийн байгууллага хүлээн авч шалгаж, шийдвэрлэсэн байна. Үүний 18573 буюу нийт гэмт хэрэг, зөрчлийн 85% Улаанбаатар хотод, үлдсэн 3255 буюу нийт гэмт гэмт хэрэг, зөрчлийн 15 хувь орон нутгийн замд үйлдэгдсэн байна.

Цагдаагийн байгууллага шалгасан нийт дуудлага мэдээллийг зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөр нь ангилан авч үзвэл гэмт хэрэг 985, зөрчил 20783 тус тус байна. Цагдаагийн байгууллагын шалгаж байгаа нийт зам тээврийн ослын 4.5% гэмт хэргийн шинжтэй, дийлэнх буюу 95.5% зөрчлийн шинжтэй байна.

Зам тээврийн гэмт хэргийн 554 буюу 56.2% нь орон нутагт, үлдсэн 431 буюу 43.8% нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна. Нийт зам тээврийн гэмт хэргийн улмаас 430 хүний амь нас хохирч, 2718 хүний биед хүндэвтэр, хүнд гэмтэл бэртэл учирсан байна.

Улсын чанартай 5 чиглэлийн авто зам дайран өнгөрдөг, Улаанбаатар хотыг тойрон хүрээлсэн байдаг газар нутгийн онцлогтой Төв аймаг зам тээврийн гэмт хэргээр бусад аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлт үзүүлж байна.

Хүснэгт №1

Нийт хохирсон хүн 3148			
Амь насаа алдсан хүн 430		Гэмтсэн хүн 2718	
Нийслэлд 11 25.8%	Орон нутаг 319 74.2%	Нийслэлд 1722 63.3%	Орон нутагт 996 36.7%

Дээрх тоо мэдээнээс дүгнэлт хийж үзэхэд Монгол Улсын хэмжээд жилд бүртгэгдэж байгаа зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг зөрчил эзэлж байна. Нийт зөрчлийн ихэнх хувь Улаанбаатар хотод үйлдэгдэж зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдэж байна. Зам тээврийн гэмт хэргийн хувьд орон нутгийн замд үйлдэгдэх нь илүү байна. Мөн зам тээврийн гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон ослуудын 74.2% нь орон нутгийн замд үйлдэгдсэн байна.

Сүүлийн 20 жилд Улсын хэмжээнд 363924 зам тээврийн осол, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 29620 бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 7250 хүний амь нас хохирч, 23309 хүн гэмт сэн байна.¹⁰²




График №1

Сүүлийн 20 жилийн хугацаанд бүртгэгдсэн зам тээврийн ослын дийлэнх буюу 85% нь нийслэлд бүртгэгдсэн байна.

Энэ нь Улаанбаатар хотын хүн амын нягтаршил, тээврийн хэрэгслийн тооноос хамаарч үйлдэгдсэн гэх дүгнэлтэд хүрч байна.

¹⁰² Монгол Улс дахь зам тээврийн осол, зөрчлийн статистик үзүүлэлтийн эмхэтгэл. УБ., 2020. 100 дахь тал

Улаанбаатар хотын хэмжээнд хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учраагүй зөрчлийн шинжтэй зам тээврийн осол ихээр бүртгэгдэж байдаг нь энэ статистик мэдээгээр нотлогдож байна.



График № 2

Сүүлийн 20 жилийн хугацаанд зам тээврийн ослын улмаас нийт 7250 хүний амь нас хохирсон байна.

Үүний 69% буюу 5028 хүн зөвхөн орон нутгийн замд нас барсан байна. Энэ тоо бол манай улсын дундаж хүн амтай нэг сумын иргэдээс их хүн зам зөвхөн орон нутгийн замд нас барсан байна.

Дээрх судалгаанаас сүүлийн 20 жилд орон нутгийн замд 53649 зам тээврийн осол бүртгэгдсэн 14119 ТХХАБАЖЭГэмт хэрэг бүртгэгдэж, байна. Гэмт хэргийн улмаас 5028 хүн нас барж, 10634 хүн гэмтсэн.

График № 3



Дээрхи графикаас дүгнэлт хийхэд орон нутгийн замд үйлдэгдэж буй 10 зам тээврийн осол тутамд 1 хүний амь нас хохирч, 4 зам тээврийн осол тутамд 1 хүн гэмтэж байна гэсэн дүгнэлт гарч байна.

Иймд Улаанбаатар хотоос орон нутгуудыг чиглэсэн улсын чанартай авто замд үйлдэгдэж байгаа зам тээврийн гэмт хэрэг нь хүний амь нас хохирох эрсдэл ихтэй байна. Улаанбаатар хотыг аймгуудтай холбосон хатуу хучилттай авто зам буюу улсын чанартай авто

замд үйлдэгддэг зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүний тулд улсын чанартай авто замд үйлдэгдэж буй зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсүүдийг сайтар тогтоох шаардлагатай байна.

1.2 Зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөл


Зам тээврийн ослын шалтгааныг дараах төрөлд хувааж авч үздэг. Үүнд жолоочийн буруутай үйлдэл, явган зорчигчийн буруутай үйлдэл, замын нөхцөл, техникийн гэмтэл. Улсын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн 21768 зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн 21196 буюу 97.4% нь жолоочийн буруугаас, 532 буюу 2.4% явган зорчигчийн буруутай үйлдлээс, 40 буюу 0.2% нь замын нөхцөлөөс шалтгаалсан гэж үзжээ.

Зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн хамгийн их хувийг эзэлж байгаа жолооч нарын буруутай үйлдлийн шалтгаан нөхцөлийг нэг бүрчлэн тогтоож, урьдчилан сэргийлэх шинэлэг арга хэрэгслийг ашиглаж шаардлагатай байна.

Жолоочийн буруу үйлдлээс шалтгаалсан зам тээврийн гэмт хэрэг зөрчлийн шалтгаан.

- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох
- Хурд хэтрүүлэх
- Бүрэн бус тээврийн хэрэгсэл жолоодох
- Анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцох
- Зогсоох арга хэмжээ бүрэн гүйцэд авахгүй байх
- Уулзварт нэвтрэх дарааллын дүрэм зөрчих
- Эргэх, буцаж эргэх үйлдлийг буруу гүйцэтгэх
- Хажуу болон хоорондын зайг зөв тохируулахгүй зорчих
- Гүйцэж түрүүлэх үйлдэл буруу хийх
- Эсрэг урсгал сөрөх
- Ухрах үйлдэл буруу гүйцэтгэх
- Бусад төрлийн буруутай үйлдэл зэрэг үйлдлээс шалтгаалан зам тээврийн гэмт хэрэг зөрчил үйлдэгддэг.

График №4



Дээрх графикаас дүгнэлт хийхэд орон нутагт үйлдэгдэж буй зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нь жолооч хажуу хоорондын зай тохируулахгүй явах, анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцох, зогсоох арга хэмжээг бүрэн гүйцэд авахгүй байх, хурд хэтрүүлэх, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ жолоо барих үйлдлүүд нөлөөлж байна.

Хурд хэтрүүлэх нь олонх улс орны зам тээврийн гэмт хэрэг, зөрчил гарах үндсэн хүчин зүйл болдог ба энэ нь шинэ залуу жолооч нартай холбоотой байдал. Хурдыг 1 км/ц бууруулахад зам тээврийн осол 4-5 хувь буурдаг гэж олон улсад үздэг байна. Улсын чанартай авто замд хурд хэтрүүлж буй жолооч нарын дийлэнх хувь нь хууль дүрмийн мэдлэг багатай, хариуцлагагүй, ихэвчлэн яарч явсан гэх шалтгаан тоочдог. Манай Улсад хурд хэтрүүлэх зөрчил улсын чанартай авто замд буурахгүй байна. Зөрчлийн тухай хуулийн 14.7.31, 14.7.32 заасан арга хэмжээг орон нутгийн замын цагдаагийн алба хаагчид хяналт шалгалтын хүрээнд илрүүлж арга хэмжээ авч байгаа ч дээр зөрчил үйлдэгдсээр л байна.

Улсын чанартай авто замд үйлдэгдэж буй зам тээврийн гэмт, хэрэг зөрчлийн шалтгаан нөхцөлүүдийн анхаарал татаж байгаа нэг хүчин зүйл бол "анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцсон" гэх үйлдэл юм. Замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу жолооч орон нутгийн замд 80 км/ц хүртэлх хурдтай замын хөдөлгөөнд оролцох эрхтэй. Энэ нь жолооч 1 секундэд ойролцоогоор 22.2 км замыг туулдаг гэсэн үг. Жолооч улсын чанартай авто замд 1-2 секунд анхаарлаа өөр зүйлд хандуулах юм бол замаас гарч онхолдох, зам дээр байгаа амьтан мөргөх, эсрэг урсгал сөрөх зэргээр маш их аюултай нөхцөл байдал үүсдэг.

Зам тээврийн ослын хэлбэр:

Зам тээврийн осол гарч буй хэлбэрийг дараах байдлаар авч үздэг. Үүнд:

- Тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх
- Тээврийн хэрэгсэл дугуйтай хүнтэй мөргөлдөх
- Тээврийн хэрэгсэлээр явган зорчигч мөргөх

- Тээврийн хэрэгслээр үл хөдлөх зүйл мөргөх
- Онхолдох

Улсын хэмжээнд 2020 онд бүртгэгдсэн зам тээврийн гэмт хэргийн 17678 буюу 81.2% нь мөргөлдөх, 1371 буюу 6.3% нь явган зорчигч мөргөх, 1007 буюу 4.6% нь онхолдох, 1199 буюу 5.5% нь үл хөдлөх зүйл мөргөх, 55 осол зорчигч унагах, 99 унадаг дугуйтай хүн мөргөх, 193 осол мал амьтан дайрах, 168 осол бусад хэлбэрээр бүртгэгдсэн байна.

Явган зорчигч мөргөх хэлбэрээр бүртгэгдсэн нийт ослын 960 буюу 80.0% нь Улаанбаатар хотод гарсан байхад, онхолдох хэлбэрээр бүртгэгдсэн нийт ослын 888 буюу 88.2% нь орон нутагт бүртгэгдсэн байна.

Онхолдох хэлбэрээр гарсан ослын улмаас орон нутагт 152 хүн, нийслэлд 11 хүн, нийт 163 хүний амь нас хохирсон байна. Энэ нь дунджаар онхолдох хэлбэрээр гарсан 6 зам тээврийн осол тутамд 1 хүний амь нас хохирч байна гэсэн үг. Орон нутаг 5.8 осол тутамд 1 хүний амь нас, нийслэлд 10.8 онхолдох хэлбэрийн осол бүрт 1 хүний амь нас хохирч байна гэж ойлгож болох юм. 2020 онд орон нутагт онхолдох хэлбэрээр үйлдэгдсэн зам тээврийн осол бүртгэгдсэн аймгуудыг Төв аймаг 122, Өмнөговь аймаг 121 гэсэн тоогоор тэргүүлж байна.

Улсын чанартай авто замд үйлдэгддэг зам тээврийн шалтгаан, хүчин зүйлүүдээс дүгнэлт хийж үзэхэд хурд хэтрүүлэх, анхаарал болгоомжгүй замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нар ихэвчлэн онхолдох хэлбэрээр зам тээврийн осол гаргаж гэмт хэрэг, зөрчилд холбогдож өөрийн болон бусдын амь нас эрүүл мэндэд хор хохирол учруулж байна.

Зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг боловсронгуй болгох арга

“Улсын чанартай авто зам” гэж нийслэлийг аймгийн төвтэй, аймгийн төвийг хооронд нь болон хилийн боомттой холбосон авто замыг хэлдэг. Аялал зугаалга, уламжлалт баяр ёслол, бүх нийтийн амралтын өдрөөр Улаанбаатар хотоос гарч байгаа хүмүүс бүгд улсын чанартай авто замаар замын хөдөлгөөнд оролцдог. Судалгааны ажилдаа улсын чанартай авто замыг сонгож тухайн авто замд үйлдэгдэж буй зам тээврийн осол хэргийн шалтгаан нөхцлийг тогтооход Төв аймаг хамгийн тохиромжтой аймаг юм. Төв аймаг бол газар нутгийн хувьд онцлогтой Улаанбаатар хотыг тойрон хүрээлсэн байдаг. Улаанбаатар хотруу орох болон гарах бүх аймгийн хөдөлгөөн Төв аймгийн газар нутаг дээгүүр дайран өнгөрдөг. Төв аймгийн нутаг дэвсгэрт улсын чанартай 5 чиглэлийн хатуу хучилттай А0101 Улаанбаатар-Чойр, А0201 Улаанбаатар-Мандалговь, А0301 Улаанбаатар-Арвайхээр, А0401 Улаанбаатар-Дархан, А0501 Улаанбаатар-Багануур чиглэлийн авто замууд дайран өнгөрдөг. Жилд бүртгэгдэж байгаа зам тээврийн гэмт хэрэг, зөрчлийн тоо мэдээгээр бусад аймгуудаас хэд дахин илүү байдаг нь газар нутгийн онцлог, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчимтэй холбоо гэж ойлгож болно. Иймд Төв аймгийн Цагдаагийн газарт бүртгэгдэж шалгагдсан сүүлийн 5 жилийн ослын холбогдогч нарын мэдээллийг цуглуулж нийт 1452 жолоочид судалгаа хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо.

Төв аймагт сүүлийн 5 жилийн хугацаанд зам тээврийн гэмт хэрэг 352, зам тээврийн зөрчил 1100 тус тус бүртгэгдсэн байна.

Зам тээврийн гэмт хэрэгт холбогдсон 352 жолооч нарыг насны ангиллаар нь ялгаж үзэхэд.

График № 5



Зам тээврийн гэмт хэрэгт холбогдсон жолооч нарын 60%-ийг 20-40 хүртэлх насны хүмүүс эзэлж байна. Энэ нь зам тээврийн ослыг ихэвчлэн идэр насны залуу хүмүүс үйлдэж байна. Мөн 20-30 хүртэлх насны хүмүүс 29% эзэлж байгаа нь жолооч болоод удаагүй туршлага муутай жолооч зам тээврийн гэмт хэрэгт өртөх хувийг илэрхийлж байна.

Зам тээврийн гэмт хэрэгт холбогдсон 352 жолооч нарыг хүйсээр нь ангилж үзэхэд.

График № 6




Зам тээврийн гэмт хэрэгт холбогдсон жолооч нарын 13% буюу 44 нь эмэгтэй жолооч байна. Эмэгтэй жолооч зам тээврийн гэмт хэрэгт холбогдохдоо ихэвчлэн хурд хэтрүүлэх зөрчил үйлдэж, онхолдох хэлбэрээр осол гаргадаг.

Зам тээврийн гэмт хэрэгт холбогдсон жолооч нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10-т заасан хэсэг хэсгээр нь ангилж авч үзвэл.

График № 7

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10



Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйл. Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих

1.Автотээврийн хэрэгслийн жолооч хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөний улмаас хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учруулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.согтуурсан, мансуурсан үедээ;

2.2.тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй хүн;

2.3.хүний эрүүл мэндэд хүнд хохирол учруулж;

2.4.их хэмжээний хохирол учруулж үйлдсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг:

4.1.согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн;

4.2.энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг таван жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Төв аймгийн хэмжээнд сүүлийн 5 жилийн хугацаанд зам тээврийн гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон 113 гэмт хэрэг бүртгэгдэж __ хүн нас барсан байна.

Мөн Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйл. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих 51. “Жолооч замын хөдөлгөөний дүрэм зөрчиж бусдын эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэснийг зөрчиж 1100 зам тээврийн осол бүртгэгдэж зөрчлийн хэрэг бүртгэлийн ажиллаа хийгдэж арга хэмжээ авсан байна.

Төв аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн зам тээврийн гэмт хэрэг, зөрчилд холбогдсон жолооч нарын гэрийн хаяг, үндсэн харьяалал.

График №8



График №9



Зам тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч нарын 285 буюу 81%, зөрчилд холбогдсон жолооч нарын 946 буюу 86% нь Төв аймгийн нутаг дэвсгэрт явж байсан өөр аймаг, сум эсвэл Улаанбаатар хотын харьяалалтай, гэрийн хаягтай хүмүүс байна. Энэ бол улсын чанартай авто замд явж байгаа жолооч нар тухай авто замын мэдээлэл муу, зам орчныг сайтар мэддэггүйгээс шалтгаалан зам тээврийн гэмт хэрэг, зөрчил холбогдсон байх үндэслэлтэй. Иймд орон нутгийг зорьж яваа жолооч нар бусад аймаг, хотыг холбосон улсын чанартай авто замын мэдээлэл, зам орчныг нарийвчлан сайн мэддэг байх нь дээрх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга болох юм.

Зам тээврийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэдээллийн технологийг ашиглах нь

Мэдээллийн технологи гэдэг нь Америкийн мэдээллийн технологийн холбооны (ИТАА) тодорхойлсоноор "Компьютер дээр суурилсан мэдээллийн систем, програм хангамж болон техник хангамжийн дизайн, хөгжүүлэлт, хэрэгжүүлэлт, хангамж болон удирдлагыг судлахыг хэлнэ". Мэдээллийн технологи нь цахим тооцоолуур болон програм хангамжийг хэрэглэн мэдээллийг хувиргах, хадгалах, хамгаалах, боловсруулах, дамжуулах болон найдвартайгаар хүлээн авах тухайг судалдаг. Мэдээллийн технологи нь одоо дэлхийг хавтгайруулагч хүчин зүйл болоод байгаа бөгөөд дэлхийн хөгжлийг тодорхойлогч тэргүүн эгнээний зүйл болж байна.

Мэдээллийн технологи өндөр хөгжиж байгаа энэ үед хүн ухаалаг гар утасны тусламжтай мэдээллийг өдөр бүр хүлээн авч байна. Зам тээврийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мөн мэдээллийн технологийг ашиглаж жолооч нарт замын аюултай хэсгийн судалгааг мэдээллэж байх нь судалгааны ажилын гол зорилго юм аа. Сүүлийн 5 жилийн байдлаар улсын чанартай авто замд давтамжтайгаар зам тээврийн осол хэрэг үйлдэгдсэн газруудын судалгааг Тээврийн цагдаагийн албаны орон нутгийн хурдны хяналтын хэлтсийн алба хаагч нартай хамтран гаргахад Монгол Улсын хэмжээнд орон нутгийн замд зам тээврийн осол хэрэг

давтамжтайгаар үйлдэж байгаа нийт 232 аюултай хэсэг тогтоогдсон. Эдгээр 232 аюултай хэсэг нь Улаанбаатар хотоос 21 аймаг руу явах улсын чанартай авто замуудад байх бөгөөд тухай осол ихээр бүртгэгдэж байгаа аюултай хэсгийн эхлэл болон төгсгөлийн координатыг тухайн аймаг бүрийн замын цагдаагийн тасгийн алба хаагч нарын тусламжтайгаа бүртгэж авсан.

Зам тээврийн гэмт хэрэг, зөрчил ихээр бүртгэгдэж байгаа аюултай хэсгийг яаж? ямар аргаар жолооч нарт мэдээлэх вэ?

Ухаалаг гар утасны “GPS, Navigation аппликэйш”-ний тусламжтайгаа жолооч нарт мэдээлэл өгөх болно. Аппликэйшны ажиллах зарчим бол одоогоор өргөн ашиглагдаж байгаа GPS, Navigation-ний мэдээллийн санд судалгаагаар тогтоосон 232 аюултай хэсгийн мэдээллийг нэмж оруулах, тухайн хэсэгт гар утсанд дээрээ аппликэйшн татаж суулгасан жолооч машинаа унаад ойртох үед гар утас нь аюултай хэсэг ойртож байна гэж мэдээллийг жолоочид Монгол хэлээр анхааруулж хэлэх. Энгийн мэт боловч энэ арга хэмжээ нь улсын чанартай авто замд үйлдэгдэж байгаа зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх ажилд инновацийг нэвтрүүлж буй хэлбэр юм. Уг гар утасны аппликэйшныг “Жолоочийн хөтөч” буюу “Drivers guide” гэж нэрлэж байгаа.

GPS нь (англ. Global Positioning System) [АНУ](#)-ын Батлан Хамгаалах яамнаас хэрэгжүүлсэн цэрэг иргэний зориулалтын байршил тогтоох систем юм

Уг гар утасны аппликэйш нь дараах зорилго

1. Зам тээврийн гэмт хэрэг бүртгэгдэд аюултай хэсгийг жолооч нарт мэдээлэх.
2. Улсын чанартай авто замаар зорчих үедээ жолооч нар дундаж хурдаа тооцоолж сурах, *цагаа зөв төлөвлөж хол замд гарах нь жолооч нарыг хурд хэтрүүлэх зөрчил гаргахаас урьдчилан сэргийлж чадна. Хурдыг 1 км/ц багасгахад зам тээврийн осол гарах хувь 5 хувь хүртэл буурна гэдгийг дээр дурьдсан билээ.*
3. Мэдээллийн технологи учир аппликэйшныг тусламжтай хамгаалах бүс хэрэглэхийн ач тусыг жолооч нарт мэдээлэх
4. Жолоочийн хувийн оноо, тээврийн хэрэгслийн оношлогоо, татвар, даатгалыг мэдээлэл, торгууль зэргийг интернетийн тусламжтайгаар харах.
5. Зам тээврийн ослын дараах эрсдэлийг бууруулах, эмнэлэгийн анхны тусламж, цагдаагийн холбогдох утасны жагсаалтыг координатын дагуу гаргаж

Жолоочийн хөтөч Аппликэйшны ажиллагаа.

- Таныг жолоо барьж явах үед “хурдны хязгаар, гүйцэж түрүүлэх хориотой” замын тэмдгийн мэдээллийг хэлж байх болно. /*Анхааруулга тэмдгийн суурин газарт 150-50м, суурингийн гадна 300-150м, мэдээлэх тэмдгийг 50м дотор/*

- Зам тээврийн осол их бүртгэгддэг аюултай бүс ойртож байгааг анхааруулж хурдаа хасахыг шаардана, тухайн бүсийг дайрч өнгөсөний дараа хэвийн болзсоныг дахин мэдээлэх болно.

- Бүх мэдээллийг монгол хэлээр хэлж мэдээлэл.

- Та аппликэйшныг асаасан тохиолдолд заавал утасны дэлгэц харж явах шаардлагагүй утсаа түгжсэн байсан ч аюултай хэсэг дөхөх үед мэдээлэл өгөх болно.

- Замын хөдөлгөөний дүрэмд заасан хурдны дээд хязгаарыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлсэн үед дохио өгч анхааруулна

- Цаг агаарын онцгой нөхцөл байдал үүссэн буюу зам хаагдсан үед нөхцөл байдлын мэдээлэл, сайдын тушаалыг шуурхай дамжуулна. /*Интернет шаардагдана /*

- Та өөрийнхөө хаана байгаа эсэхийг шалгахад /таны байгаа байриил аймаг, сум, баг, замын чиглэл, км-ээр гарч ирэх болно./

- Яаралтай тусламж цэс /таны байгаа байрилыг тогтоож тухайн газар нутгийг хариуцсан цагдаа эмнэлэг, онцгой байдлын албаны дуудлага хүлээн авах утас гарч ирнэ./

Гар утасны аппликейшны давуу болон сул талууд:

Давуу тал

- Бусад урьдчилан сэргийлэх ажлыг бодвол бага задралаар бүтнэ
- Олон хүн мэдээллийг шуурхай хүргэж чадна
- Заавал утасны сүлжээ, интернет шаардлагагүй.
- Зөвхөн аюултай хэсгийг мэдээлэхгүй бусад олон төрлийн мэдээллийг аппликэйшнээс авах боломжтой, хөгжүүлэлт хязгааргүй.

- Яаралтай тусламжийн цэс. Танд зам тээврийн ослын дараах анхны тусламжийг цаг алдалгүй хүргэх зорилгоор эмнэлэг, цагдаагийн байгууллагад мэдэгдэх, холбоо барих утасны дугааруудын жагсаалт байна.

- Дундаж хурдыг жолооч нарт мэдээлэх болно. Ингэснээр хол замд цаг төлөвлөж сурах

Сул тал

- Жолоо барьж явах үед гар утастай харьцах шаардлага үүсэх эрсдэлтэй
- Олон удаагийн шинэчлэл татаж авах шаардлагатай
- Зөвхөн ухаалаг гар утастай жолооч нар ашиглах боломжтой.

Ашигласан материал:

Хууль, эрх зүйн акт:

1. Авто замын тухай хууль
2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
3. Монгол Улсын Эрүүгийн хууль
4. Зөрчлийн тухай хууль
5. Замын хөдөлгөөний дүрэм.

ОТНОШЕНИЕ ГРАЖДАН РЕСПУБЛИКИ МОНГОЛИИ
К БЕЗОПАСНОСТИ В ОБЩЕСТВЕННЫХ МЕСТАХ

Ганмягмар Болор-Эрдэнэ
кандидат юридических наук майор полиции
Республики Монголия

Аннотация. Состояние безопасности в общественных местах по праву стало рассматриваться как важнейший показатель эффективности деятельности органов власти и управления, а также полиции. Такой подход признан оптимальным в большинстве стран мира, где показатели преступности большей частью используются для внутриведомственной оценки работы правоохранительных органов, а соответствующие оценки граждан признаются решающими в определении эффективности функционирования всей системы безопасности.

Ключевые слова. Общественные места, угроз в общественных местах, предупреждение посягательств, жертвой преступления в общественном месте.

Основная часть. Основная гуманитарная цель деятельности органов власти управления всех уровней, включая полицию, заключается в обеспечении безопасности страны и ее населения от внешних и внутренних угроз. Оно позволяет выбрать правильные ориентиры в политике, социальной сфере, законотворческой и правоприменительной деятельности. В связи с этим значение мнение граждан о безопасности в общественных местах трудно переоценить. Общественные места – это территории и иные объекты, доступные для неограниченного количества граждан, которые преимущественно используются для их перемещения (например, общественный транспорт и его остановки), а также удовлетворения досуговых потребностей (приобретения имущества, питания, отдыха, занятия спортом и пр.).

Состояние безопасности в таких местах по праву стало рассматриваться как важнейший показатель эффективности деятельности органов власти и управления, а также полиции. Такой подход признан оптимальным в большинстве стран мира, где показатели преступности большей частью используются для внутриведомственной оценки работы правоохранительных органов, а соответствующие оценки граждан признаются решающими в определении эффективности функционирования всей системы безопасности.

Соответствующий политический подход нашел отражение и нормативных правовых актах, регламентирующих работу по предупреждению преступлений и правонарушений на территории монгольских город, в частности в Законе о предупреждении преступности 6 июля 2019 г. и Национальной программе предупреждения преступности на 2012-2020 гг. (утв. 25 июля 2012 г.).

Оценивая общественное мнение о безопасности в общественных местах, следует отметить несколько важных моментов.

Первое. Общественное мнение является одной из форм выражения отношения людей к тем или иным явлениям и процессам. Оно зависит от восприятия конкретными людьми окружающей действительности, их представлений и убеждений о содержании безопасности, имеющего личного опыта нахождения в ситуациях криминального воздействия (как в качестве потерпевшего, так и правонарушителя), а также других людей, чье мнение является для них значимым, установок относительно предназначения и фактической деятельности правоохранительных органов и пр.

Второе. Общественное мнение, будучи выраженным при заполнении анкет, не обязательно совпадает с тем, что на самом деле думают люди, например, о полиции, и как на самом они относятся к полицейским и их работе.

Граждане могут утверждать, что они готовы сотрудничать с полицией, но при этом ничего в этом направлении не предпринимать, например, проявлять фактическое безразличие. Граждане могут считать, что в общественных местах много наркоманов, пьяниц, мошенников, хулиганов, не сообщая о конкретных правонарушениях полиции, не предприняв никаких действий по улучшению ситуации.

Третье. Отношение людей к уровню безопасности, а также о деятельности полиции преимущественно формируется на основе: личного опыта общения с полицейскими, мнения близких людей (родственников, соседей, сослуживцев); сообщений средств массовой информации (газетах, телепередачах, радио, а также Интернета); сведений, предоставляемых полицией, в том числе размещенной на официальных сайтах, при встречах с гражданами по месту жительства, при выполнении задач по обеспечению правопорядка в общественных местах; оценок, даваемых деятельности полиции представителями органов власти и управления (Президентом, главами администраций, мэрами городов и пр.).

Четвертое. Подлинное отношение граждан к полиции отражается в их конкретных действиях: как выражающих доверие и поддержку, так и недоверие и осуждение. С одной стороны, граждане могут принимать участие в обеспечении охраны общественного порядка, информировании о замышляемых или совершаемых преступлениях, оказании помощи при задержании правонарушителей, обсуждении проблем деятельности полиции, освещении либо иным способом распространении положительного опыта работы полиции и т.п.

С другой стороны, граждане могут не желать вступать в личный контакт с полицейскими, особенно, если речь идет не о защите их собственных интересов и прав, оказывать сопротивление полицейским при выполнении ими своих обязанностей, распускать разнообразные слухи о негативных процессах в полиции, вводить окружающих в заблуждение относительно результатов оперативно-служебной деятельности и пр.

Для выявления отношения граждан о безопасности на территории городов Монголии был проведен выборочный опрос в форме анкетирования 225 граждан, которые представляли различные слои населения.

Большая часть вопросов носила закрытый характер, для оценки уровней безопасности и отношения к действиям полиции использовались дихотомические вопросы, а также шкалы Ликкерта Б. и Богардуса Э. Репрезентативность выборки обеспечивалась использованием

гнездового метода, что позволило получить достоверные сведения об отношении различных категорий граждан к безопасности в общественных местах на территории городов Монголии.

Статистическая обработка эмпирического материала проводилась с использованием программного продукта SPSS, что позволило оценить качество полученных данных, осуществить их группировку полученных данных. а также установить значимые корреляционные и иные виды взаимосвязей между различными группами показателей.

Соответствующее исследование показало, что наименее безопасными по мнению граждан являются: бары и рестораны (46,0% респондентов), городские автобусы (22,8%), проезжие части дорог (22,0%), остановки общественного транспорта (21,6%), лифты и подъезды (19,4%), пляжи (17,1%), такси (14,5%), входы (выходы) у торговых предприятий (12,3%).

Сравнительно безопасными считаются дворы, магазины, парковые зоны, стадионы и спортплощадки. Небезынтересно, что женщины и пожилые люди гораздо чаще мужчин и молодежи (в 1,5-2 раза) боятся находиться в общественном транспорте, на его остановках, в такси, а также в лифтах и подъездах.

При этом 11,4% опрошенных отметили, что в последние годы находиться в общественных местах стало безопаснее, хотя 66,4% респондентов свой город считают более опасным, чем другие города Монголии.

Последнее обстоятельство, скорее всего, связано с тем, что, будучи гостями, граждане ограничивают продолжительность своего нахождения в общественных местах, более тщательно выбирают маршруты передвижения и объекты с позиций собственной безопасности, более требовательно относятся к работе «своих» полицейских по обеспечению охраны правопорядка в общественных местах.

Устанавливая виды угроз, которых опасаются граждане при нахождении в общественных местах, нами были получены следующие сведения:

Таблица 1. Распределение ответов на вопрос «Каких угроз в общественных местах стоит опасаться больше всего?»

№п/п	Варианты ответов	%
1	Ограбления или кражи вещей	53,2%
2	Разбоя (изъятия у Вас имущества с причинением вреда Вашему здоровью)	44,0%
3	Хулиганства (беспричинных унижений, оскорблений)	27,7%
4	Причинения серьезного вреда здоровью	35,2%
5	Причинения побоев	25,5%
6	Угона Вашей автомашины (мотоцикла, скутера, велосипеда)	8,8%
7	Сексуальных домогательств	8,8%
8	Мошенничества	8,4%
9	Иных угроз (впишите)	3,5%

Из представленных данных видно, что наибольшую опасность, по мнению граждан, представляют ограбления и кражи, на втором месте находятся разбойные нападения, на третьем – хулиганство. Учитывая, что представленные оценки положительно коррелируют в данными

официальной статистики о состоянии преступности в общественных местах, полиции следует особое внимание обратить на предупреждение перечисленных видов посягательств. Это позволит снизить страхи не менее 50% граждан при нахождении в общественных местах и позволит лучше отзываться о деятельности полиции и органов исполнительной власти.

Наряду с этим беспокойство вызывают ответы граждан об уровне виктимизации в общественных местах – 77,0% респондентов считают, что в течение жизни каждый человек хотя бы однажды становится жертвой преступления, совершенного в общественном месте. Каждый четвертый (26,0%) гражданин на момент опроса отметил, что в течение предшествующих шести месяцев он стал жертвой преступления. Можно предположить, что в течение года гораздо большее число респондентов испытали на себе соответствующее воздействие, возможно, даже не однажды, а у 56,3% граждан жертвами посягательств в общественных местах становились близкие им люди.

Такой уровень виктимизации является весьма высоким, что не может не сказаться на негативном отношении к эффективности работы по обеспечению безопасности в общественных местах. Тем более, что вероятность того, что люди вновь станут жертвами преступлений, по мнению респондентов, довольно высока (табл. 2).

Таблица 2. Распределение ответов на вопрос «Какова вероятность того, что Вы можете стать жертвой преступления в общественном месте?»

№п/п	Варианты ответов	%
1	Со мной это не случится	44,3%
2	Вряд ли со мной это случится	28,2%
3	Никто не застрахован от этого	1,3%
4	Этого будет сложно избежать	16,3%
5	Затрудняюсь ответить	10,1%
Итого		100%

Характерно, что далеко не все (менее 44%) граждане, ставшие жертвой преступления в общественном месте, обратились с соответствующим заявлением (обращением) в полицию по поводу происшедшего. И лишь 30,8% из числа обратившихся в полицию были удовлетворены действиями полиции.

Более того, только 6,6% опрошенных считают, все граждане, ставшие жертвой преступления в общественном месте, сообщают о происшедшем в полицию, по мнению 43,1% это делает большая часть потерпевших, 40,0% – обращается незначительная часть, 1,8% – обращаются единицы.

Причины отказа от обращения в полицию разнообразны: не знают, что их интересы защищены законом (50,2%); не уверены в том, что виновные будут найдены и наказаны (31,2%); не хотят быть «втянутыми» в процесс расследования (23,8%); не верят, что им помогут (20,7%); считают, что их поведение было неправомерным (17,6%); боятся возможной расправы со стороны преступников (17,6%); не желают еще больших неприятностей (13,2%); не хотят огласки происшедшего (12,8%); считают, что происшедшее не принесло им большого вреда (5,7%). Таким образом, основную причину отказа от обращения в полицию граждане видят в

правовой некомпетентности населения, однако далее идут причины, которые связаны с качеством работы полицейских, что не может не вызывать беспокойства.

В этой связи весьма любопытными являются представления граждан о том, кто должен гарантировать их безопасность в общественных местах: 12,8% респондентов возлагают такую миссию на Президента страны, 25,1 – на мэров городов, 19,0 – на участковых полиции, 17,1 – на тех, кто охраняет порядок на улицах, 10,0 – на потенциальных потерпевших.

При этом лишь 14,5% граждан безусловно считают, что существующее число полицейских достаточно, что надлежащим образом обезопасить граждан в общественных местах от преступников, 31,7% – уверены в обратном, считая, что численность полиции следует увеличить, а 77,0% согласны с необходимостью возродить практику привлечения к патрулированию на улицах граждан, в том числе молодежи.

Основной причиной неблагоприятной криминологической обстановки в общественных местах почти половина граждан Монголии считает наличие большого числа ночных досуговых заведений, затем они указывают на слабую освещенность уличного пространства, отсутствие видеоконтроля за уличным пространством, незанятость населения. Почти треть (31,7%) опрошенных видят причину преступности в общественных местах в пьянстве и алкоголизме, 16,3% – в неэффективной работе полиции.

Полученные в результате проведенного исследования данные позволяют утверждать, что граждане Монголии испытывают очевидную потребность в расширении объемов их информирования о реальной работе представителей органов власти и управления по обеспечению безопасности в общественных местах, о необходимости повышения уровня правовой активности граждан, содействия в предотвращении и раскрытии преступлений, средствах и способах «самозащиты» (памятки для граждан по защите своего имущества, обеспечению личной безопасности, правилах поведения в ситуациях криминального взаимодействия, прежде всего, для наиболее виктимных категорий населения).

Также следует повысить качество массового информирования граждан о результатах деятельности полиции, решить задачи по созданию имиджа полицейского-профессионала, способного решать сложнейшие задачи по обеспечению безопасности в общественных местах, информированию потерпевших от правонарушений о результатах рассмотрения материалов полицией.